



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

[21 дэх жилдээ]

2022/01

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх , эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(21 дэх жилдээ)

2022/01

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл

2022/01(59)

Улсын бүртгэлийн дугаар 244

21 дэх жилдээ

Дугаарыг эрхлэн гаргасан:

- | | |
|-----------|--|
| Б.Энхболд | Ерөнхий редактор, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор |
| Х.Цэцгээ | Нарийн бичгийн дарга, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн ахлах референт |

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

О.Хишигмөнх

С.Эрдэнэболор

Хүүхэд үл хайхрах хүчирхийлэл, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдсан зарим асуудал.....7

Л.Нямдаваа

Цагдаагийн мэргэжлийн ёс зүйг тодорхойлох хүчин зүйл, тэдгээрийн онцлог27

З.Жаргалмаа

Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн зохицуулалт, уламжлалд хийсэн дүн шинжилгээ44

Д.Сүнжид

Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийн агуулга.....60

Н.Одонтуул

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан байдал.....74

Я.Билэгдэмбэрэл

Мөнгөн устай холбоотой гэмт хэргийн хор уршиг: хүний эрхийн зарим асуудал90

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

Фернанда Пирие

Эрх зүйн антропологи.....101

ЗОЧНЫ ЯРИА

Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор Б.Нармандахтай хийсэн ярилцлага

Монгол Улсад хүний эрхийг хангах эрх зүйн механизм бүрэлдэх үйл ажиллагаа эхлэлийн түвшинд байна126

CONTENT

ARTICLES

Khishigmunkh.O

Erdenebolor.C

Neglect as a violence against a child:

Law, Implementation and gaps 7

Nyamdavaa.L

Elements and unique features of police ethics..... 27

Jargalmaa.Z

Analysis of laws and conventions on women's

labour rights in Mongolia 44

Dr Sunjid.D

Structures of the European Court

Human Rights judgements 60

Odontuul.N

A brief account of international legal norms

concerning Compulsory Medical Measures..... 74

Bilegdemberel.Ya

Consequences of mercury-associated crimes and

human rights problems..... 90

ONLY IN MONGOLIAN

Fernanda Pirie.,

The Anthropology of Law 101

GUEST INTERVIEW

Narmandakh.B

Formation of legal system to fulfil human rights in Mongo-

lia is at the initial level..... 126



О.ХИШИГМӨНХ

Хуульч, докторант



С.ЭРДЭНЭБОЛОР

Судлаач, докторант

“ХҮҮХЭД ҮЛ ХАЙХРАХ ХҮЧИРХИЙЛЭЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ”

NEGLECT AS A VIOLENCE AGAINST A CHILD: LAW, IMPLEMENTATION AND GAPS

Хураангуй: Гэр бүлийн хүчирхийллийн нөлөөгөөр хүүхдийн эсрэг зөрчил, гэмт хэрэг ихээхэн үйлдэгдэж байгаа нь хүүхэд гудамжинд бус хамгийн тайван, эрсдэлгүй, аюулгүй байх орчиндоо эрх нь зөрчигдөж байгааг илтгэнэ. Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийг зөрчих 15 зөрчлийг хуульчилснаас ихэнх нь хүүхдийн бие махбодод халдсан, үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн зөрчил, шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээгээр хүүхдийн тэтгэмж хугацаанд нь төлөөгүй зөрчил нэлээдгүй байна¹ гэснээс үзэхэд илэрсэн зөрчлийн хувьд ч далд хэлбэрээр ч хүүхдийн эрхийг хамгаалах үүрэгтэй субъектүүд хамгийн их зөрчил үйлдэж байгааг харуулж байна. Үл хайхрах хүчирхийлэл нь дангаараа болон бусад хүчирхийллийн хэлбэртэй хамт үйлдэгддэг тул хамгийн түгээмэл байх боловч илрүүлэлт хангалтгүй, хариуцлагын үр нөлөөтэй байдалд анхаарах шаардлага зайлшгүй байна. Тиймээс хүүхдийн эрхийг хамгаалах үүрэг хүлээсэн бүх субъектүүд үүргээ биелүүлэх, хамтран

¹ <https://www.arslan.mn/social/news/632926.shtml> Улсын Ерөнхий Прокурорын газраас Монгол Улс дахь хүүхдийн эрхийн зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал” судалгааг хийсэн бөгөөд УПЕГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ сургалтын хэлтсийн хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаатай хийсэн ярилцлагын хэсгээс авав.

ажиллах, олон нийтийн оролцоог үр дүнтэй нэмэгдүүлэх нь зүйтэй юм. Гэр бүлийн хүрээнд архидалт, ядуурал, ажилгүйдэл их байгаа нь хүүхдээ үл хайхрах, зөрчлөө давтан үйлдэх, үйлдлээ ухамсарлахгүй байх шалтгааны нэг хэсэг болж байна. Иймд үл хайхрах хүчирхийллийг үйлдэж буй этгээдэд хүлээлгэж буй хариуцлагын хэмжээ, үр нөлөөтэй байдал, хүүхдэд учирсан хохирол, үр дагаврыг арилгах талаар авч үзэх нь чухал ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Хүүхэд хамгаалал, Хариуцлага, Хяналт, Хохирогч, Үр дагавар

Abstract: *Since violence and crime against children are committed immensely among adverse effects at family domestic, their inviolable rights that living at safety environment and be peace in everywhere are violated. There are only 15 articles related to violation against the rights of the child in the 'Infringement Code of Mongolia' (2017). Most of them concern the physical abuse, neglect, drinking alcohol and using drugs in the presence of children, and sexual abuse. Besides, unpaying childcare benefits takes up substantial parts through exportation reports on court decisions. Thereof shows that the persons responsible for protecting the rights of the child commit most violations both in overt and covert.*

Although either neglect violence against children are committed solely or combined with other violence or crime, there will be indispensable that paying attention both on insufficient detection and effectiveness of responsibility. Therefore, all officers who are responsible for the protection of the rights of the child should fulfill their responsibilities, co-operate and increase effective public participation.

Alcoholism, poverty, and unemployment in domestic life are some of the reasons why children are neglected, re-offended, and unaware of their actions. Therefore, it is most important to consider the extent and effectiveness of the liability of perpetrators of neglectful violence, and the extent to which the harm and consequences of harm to children are remedied.

Keywords: *Child protection, Responsibility, Control, Victim, Consequence*

I. ОРШИЛ

Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтэд өгсөн дүгнэлт, зөвлөмжид холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байгаа нь сайшаалтай хэдий ч хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг авах, шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хуваарилахад илүү анхаарах²-ыг сануулсан нь өнөөгийн хүүхэд хамгааллын асуудалд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг илтгэнэ. Дээрх дүгнэлт, зөвлөмжийг 2017 онд буюу 5 жилийн өмнө өгсөн хэдий ч одоо ч шаардлагатай санхүүжилт, хүний нөөц, арга зүй дутмагаас хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох, хохиролгүй болгох, хүүхдийг үл хайхрах явдлыг таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээг авах асуудал тулгамдсан хэвээр байна. Хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл нь дангаараа болон бие махбод, бэлгийн, сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийлэлтэй хавсарч үйлдэгдэг онцлогтой бөгөөд үр дагаврын хувьд хүүхдэд насан туршид нь арилшгүй ул мөр үлдэж нийгэм, ойр дотнын хүмүүс, гэр бүлээ үзэн ядах, өөртөө итгэлгүй болох зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг.

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл болон бусад зүйлсээс шалтгаалж ажилгүйдэл, ядуурал буурахгүй үед гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэж үүнд өөрийгөө хамгаалах чадваргүй хүүхэд өртөх, өртсөнөө илэрхийлэх, хохирлоо барагдуулах асуудал босго давахгүй дарагдах асуудал тулгарч буйтай бүх хүн, төрийн байгууллага, албан тушаалтан тэмцэх, шаардлагатай арга хэмжээг авч хүүхдийг хамгаалах асуудлыг сонголтоор бус, сайн санаа, сайхан сэтгэлээр хийх бус бүх нийтээрээ хариуцлага гэж хүлээн анхаарах шаардлага байна. Учир нь хүүхэд бие махбод, сэтгэл зүйн хувьд өөрийн эсрэг үйлдлийг ойлгох, ухаарах, таслан зогсоох шаардлагатай арга хэмжээг авах чадамж дутмагтай холбоотой.

Хүүхэд үл хайхрах хүчирхийлэлд өртсөнөөр гэмт хэрэг үйлдэх, өртөх, сургууль завсардах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авч чадахгүй байх, хоцрогдох, мансууруулах, согтуурах бодис, эм хэрэглэх, гэр орноосоо дайжих зэрэг түгээмэл асуудал тулгарч зөв хүн болж төлөвших, хөгжих боломж тэдний хувьд хязгаарлагдаж байна. Тиймээс хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүчирхийллээс хамгаалуулах, хүн ёсоор аж төрөхөд шаардлагатай эрхээ эдлэх боломжийг хүүхдийн хувьд бүрдүүлэх нь энэ үед амьдарч ажиллаж байгаа хүмүүст хамааралтай асуудал талаас ойлгож хандаж хамгаалах нэн шаардлагатай байна. Насанд хүрэгчид бид хүүхэд байж үзсэн, тэдний асуудлыг шийдэх, тэднийг хамгаалах чадвар, ухамсар, идэвхтэй үйлдлийг бид өөрсдөөсөө эхлүүлж хүн бүрт хэвшүүлэх нь ирээдүйнхээ төлөө хийж буй хамгийн эрхэм чухал үйлс гэдэг нь эргэлзээгүй.

² <https://mlsp.gov.mn/content/detail/1084>

II. ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ХЭЛБЭЭ

Гэмт хэрэг, зөрчилд нөлөөлөх хүчин зүйлсийг онолын үүднээс эрдэмтэн судлаачид эрт үеэс олон талаас судлан тодорхой үзэл баримтлалуудыг дэвшүүлэн практикт туршин үр дүнд хүрэхийг эрмэлзсээр ирсэн. Сэдвийн хүрээнд нийгмийн, сэтгэл судлалын, биологийн хандлагаар тайлбарласан онолын үзэл баримтлалаас сэдэвтэйгээ уялдуулан авч үзлээ. Ёс суртахууны онолын чиг хандлагуудаас харахад ёс суртахуунгүй газар хууль ёс амаа хамжих хандлага байгаа нь эртний үеэс хүний хүмүүжил, төлөвшил, ёс зүйн хөгжил төлөвшилд нь анхаардаг байсан нь аль ч улсын хувьд үл алдаж болох зүйл гэдгийг өнөө үед ч олон жишээ харуулж байна. Япон улсад гэмт хэрэгийн гаралт хамгийн бага байдаг шалтгаан нь “таван хөдөлшгүй”-³ нийгмийн ёс суртахууны үндэс болгон хүмүүжил олгодог байсантай холбон судлаачид дүгнэсэн⁴ байна. Томас Хоббесын үндэслэсэн Нийгмийн гэрээний онолоор хүн өөрийн ашиг сонирхлоо бусдынхаас илүүд үзэх төрөлхийн хандлага нь энэ ертөнцөд хүн болгон өөрөөсөө бусад бүх хүнтэй дайтахад хүргэдэг, үүнээс болж нэг ч хүн аюулаас ангид байж чадахгүй, бусдыг хохироохоос буцахгүй байдлыг хязгаарлахын тулд дундын тогтолцоо хэрэгтэй, тэр нь төр байх юм гэж үзсэн. Чезаре Беккариа Гэмт хэрэг ба ял шийтгэл номдоо “Чөлөөт хүсэл зоригийн онол”-ын дэвшүүлж хүн гэмт хэрэг үйлдэхдээ сайн ба муугийн үр дагаврыг тооцсоны үндсэн дээр өөрийн ухамсартай сонголтыг хэнээс хамааралгүй чөлөөт хүсэл зоригоор хийдэг, шийтгэхээс илүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, ял шийтгэлийн харьцаа зохистой байх, гэмт хэргийн цорын ганц үнэн зөв хэмжүүр бол нийтэд учруулсан хохирол байх, ял шийтгэлийн зорилго нь тамлан тарчлаахдаа бус гэмт хэрэгтэн дахиад гэм хор учруулахгүй байх, бусдыг тийм үйлдэл хийхээс татгалзуулахад оршино, ял шийтгэл үр нөлөөтэй байх ёстой⁵, гэж бүтээлдээ дурдаж байсан нь тухайн үеийн нийгэмд эрс шүүмжлэлд өртөж эрх баригчид бүтээлийг нь олон нийтийн хүртээл болгохоос татгалзах, хураах, хорих үйлдэл гаргаж байсан хэдий ч цаг хугацааны эрхээр хүлээн зөвшөөрөгдөж хуульчлагдсан юм. Энэ онолын үзэл баримтлалыг хуульд зохих хэмжээнд тусгалаа олсон хэдий ч гэмт хэрэгтэн үйлдлээ давтах, татгалзахгүй байх, хохирол нөхөн төлөгдөхгүй байх асуудал түгээмэл байгаа нь зөрчил, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэний дараа бус үйлдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэхэд илүү анхаарах шаардлагатайг илтгэнэ.

³ Конфуцийн таван хөдөлшгүйд захирагдагч нь захирагчдаа, эхнэр нь нөхөртөө, хүү нь эцэгтээ, дүү нь ахдаа, залуу нь ахмаддаа ёсчлон захирагдах нь гэр бүлийн, нийгмийн ёс суртахууны үндэс гэж үздэг байжээ. Монголчууд бид үүний нэгэн адил эрт үеэс хүн ахтай, дээл захтай, ахаа алд хүндэл, эгчээ дэлэм хүндэл, цэр нь цээжиндээ, бөөр нь бөгсөндөө, төр түвшин бол түмэн олон амар амаглан гэх мэт ёс суртахуун, эмх цэгцтэй байх хэм хэмжээг дагаж мөрдөхийг уламжилсаар ирсэн.

⁴ Д.Зүмбэрэлхам “Криминологийн онол” 2022 х.29

⁵ Beccaria, C “On crimes and punishment”. New Brunswick, NJ Transaction Publishers 1764/2009

Эдвин Сатерлэндийн суралцах онолын үзэл баримтлалаар хүмүүс нь зөвхөн шагнал, шийтгэлийн аргаар ажиллаж дасах бус нийгмийн орчноос, хүрээлэл, бусад хүмүүсийн зан үйлийг ажиглаж тогтоож тодорхой зан үйлд дадах явдал түгээмэл байдаг. Гэмт зан үйлд суралцдаг, байгалиас заяагдмал өгөгдөлтэй холбоогүй⁶ гэж үзэж байсан нь хүчирхийлэл, хүчирхийллийг төрүүлдэг гэх үзэлтэй ойр бөгөөд хүүхэд хүчирхийлэлтэй, өөрийг нь үл хайхрах хандлага аажимдаа өөрт зан үйл болж хэвшин дараагийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх нөхцөлийг бий болгох сөрөг үр дагавартай байж болохыг анхааруулж буй юм.

Нийгмийг хамгаалах онолыг боловсруулсан Адолф Принсийн үзэл баримтлалаар гэмт хэрэг, зөрчлийг бууруулахын тулд ял шийтгэлийн тогтолцоог хөгжүүлэх бус харин ядуурал, зовлонд нэрвэгдсэн хүмүүсийг нийгмийн зүгээс анхааран халамжлах нь чухал, амьдрах гэр оронгүй, тогтсон гэр бүлгүй, эрхэлсэн ажилгүй, орлогогүй хүмүүс биеэ авч явах талаар тогтсон уламжлал болон хуульт ёсонд захирагддаггүй гэсэн дүгнэлтийг хийсэн нь гэмт хэрэг, зөрчил үйлдэж буй хүмүүсийн ихэнх нь эрхэлсэн ажилгүй, боловсролгүй, тогтсон гэр бүлгүй ямар нэг амьдралд нь асуудал байгаатай холбоотой гэж ойлгож болохоор байна. Нийгмийг хамгаалах онолын үзэл санаа нь дарамтын онолоор баталгаажихаар байна. Учир нь дарамтын онолоор нийгмийн тодорхой бүтцийн гажуудал нь хүмүүст дарамт болсноор нийгэмд тэр хэмжээгээр гэмт явдал ихэсдэг тиймээс гэмт хэрэгтэнтэйгээ ажиллахаас илүүтэй гажуудалтай тэмцэх нь үр дүнтэй гэж үздэг нь хөндсөн сэдвийн хүрээнд хүүхдийг эрхийг зөрчсөнтэй тэмцэхээс илүү зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, хохирогч, гэмт хэрэгтэн бий болгохоос өмнө арга хэмжээ авах нь зөв гэдгийг баталж байгаа юм.

Харилцан хамаарлын онолоор хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг шалтгааныг “хүүхдүүд насанд хүрэгчдээс сул дорой, өөрийгөө тэжээн тэтгэх чадваргүй, тухайн орчноос зугтах боломжгүй байдаг” нь хүчирхийлэгчээс хараат байх нөхцөлийг бүрдүүлдэг⁷ гэж үзсэн нь маргаангүй үнэн бөгөөд хүчирхийлэлд өртөж байгаагаа, хохирлоо барагдуулах, нөхөн сэргээх асуудлаа мэдэхгүй, мэдсэн ч барагдуулахгүй өнгөрч байгаа нь зөрчил, гэмт хэрэг үйлдэгчийг үйлдлээ давтах шалтгааны нэг болж байна. Дээрх онолуудын үзэл баримтлалаар хариуцлагын хэм хэмжээ ач холбогдолтой хэдий ч урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ түүнээс илүү чухал болохыг, гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн суурь хүчин зүйлийг судлан тогтоож суурь шалтгааныг нь бууруулах арга хэмжээ авах нь дан ганц хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт хэрэгт хамааралтай бус бүхий л гэмт хэрэг, зөрчил буурахад нөлөөлөх сайн талтай гэж дүгнэж болохоор

⁶ Д.Зүмбэрэллхам “Криминологийн онол” 2022 х. 105-109

⁷ Finkelhor D, Dziuba-Leatherman J. Victimization of children. Am Psychologist. 1994;49:173-183

байна. Учир нь ажилгүй, орлогогүйгээс гэр бүл ядууралд өртөж хамгийн том хохирогч нь хүүхэд болж байгаа тул зөвхөн ял шийтгэлээр энэ асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Хүүхэд үл хайхрах хүчирхийллийн тухай ойлголт авч үзэхийн өмнө хүчирхийллийн талаарх ойлголтыг товч авч үзэх нь зүйтэй юм. Хэн нэгэн этгээд төлөвлөн тодорхой зорилгод хүрэхийн тулд биенийхээ эсрэг албадлага, хүч хэрэглэх аргыг хүчирхийлэл гэнэ⁸. Хүчирхийллийг нь гэр бүлийн, бэлгийн хамтрагчийн эсрэг, олон нийтийн газар орчинд гарах хүчирхийлэл зэргээр ангилж болно. Гэр бүлийн хүчирхийлэл гэж эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээдийн сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг⁹ ойлгоно гэж хуульчилсан. Хүн хоорондын хүчирхийллийг:

- Хүүхэдтэй зүй бус харьцах хүчирхийлэл
- Залуучуудын эсрэг хүчирхийлэл
- Бэлгийн хамтрагчийн эсрэг хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Ахмад настантай зүй бус харьцах хүчирхийлэл
- Тусгай хэрэгцээт иргэний эсрэг хүчирхийлэл
- Өдөр тутмын хүчирхийлэл гэх мэт ангилж болно.

Хүчирхийллийн хэлбэрийг бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн, үл хайхрах, гачигдуулах¹⁰ гэж ангилсан бол Монгол Улсад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрийг¹¹ ихэвчлэн хуульчилсан. “Үл хайхрах” хүчирхийлэл гэж сэтгэцийн болон бие бялдрын чадваргүй байдал эсвэл биеэ даах чадваргүй хүн хоол, байр, хувцас, эмнэлгийн үйлчилгээ, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээ авах хэрэгцээг өөрөө хангаж чадахгүй тохиолдолд асран хамгаалагч нь үзүүлэхгүй байхыг ойлгодог¹² байна. Үл хайхрах, гачигдуулах хүчирхийлэлд илүүтэй бусдын асран хамгаалалтад

⁸ Schechter DS, Willheim E, McCaw J, Turner JB, Myers MM, Zeanah CH (2011). “The relationship of violent fathers, posttraumatically stressed mothers, and symptomatic children in a preschool-age inner-city pediatrics clinic sample”. *Journal of Interpersonal Violence*. 26 (18): 3699–3719.

⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 5 дугаар зүйл 5.1.1

¹⁰ World report on violence and health, World Health Organization, Geneva, 2002, page 6 https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/42495/9241545615_eng.pdf?sequence=1

¹¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 6 дугаар зүйл 6.1

¹² Richard J. Bonnie and Robert B. Wallace. Elder Mistreatment. Abuse, Neglect, and Exploitation in an Aging America. 2003. USA. https://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK98802/pdf/Bookshelf_NBK98802.pdf

байдаг хүүхэд, өндөр настан, хөдөлмөрийн чадвараа алдсан буюу хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүн илүүтэй өртөх эрсдэлтэй байдаг. Үл хайхрах, гачигдуулах хүчирхийлэл¹³ дээрх бүх хүчирхийллийн төрөлд байдаг ба хөгшин залуу, эрэгтэй, эмэгтэй, нас, хүйс ялгаагүй энэ төрлийн хүчирхийллээс ангид байх эрхтэй. Үл хайхрах хүчирхийлэл дангаараа болон бусад хүчирхийллийн хэлбэрүүдтэй хамт илэрдэг. Хүүхдийн эрхийн конвенцод “хүчирхийлэл” гэдэгт “гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр хэмээн тодорхойлжээ. Үүнээс үзэхэд “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэдэг нь хүүхдийн жам ёсны болон хуулиар тогтоосон боломж, хэрэгцээг хязгаарлаж, өөрийгөө буюу бусдыг хүндэтгэдэг бие хүн болон төлөвших, хөгжихөд саад болсон сэтгэл зүйн, биеийн хүчний, бэлгийн харилцааны болон үг хэл, үл хайхарч шоовдорлогдох замаар сэтгэл санаа, бие махбодод гэмтэл учруулж болохуйц, эсвэл учруулсан аливаа үйлдэл, эс үйлдлийг ойлгож болохоор байна. Хүүхэд үл хайхрах хүчирхийлэл хэлбэрийн хувьд:

- **Бие махбодын хувьд үл хайхрах¹⁴:** Хүүхдийн наад захын хэрэгцээ болох хоол хүнс, хувцас хунар, орон байраар дутаах, хүүхдэд согтууруулах ундаа, хор, мансууруулах бодис, муудсан хоол, зохисгүй зүйл санаатайгаар, хүчээр идүүлэх.
- **Эрүүл мэндийн хувьд үл хайхрах:** Хүүхдийг зайлшгүй хамрагдах эмнэлгийн үйлчилгээнд хамруулахгүй, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй, нас сэтгэхүйн хөгжлийн хоцрогдолд санаа тавихгүй байх, биеийн зовуурь шаналгааг тоохгүй, эмчлүүлэхгүй, урьдчилан сэргийлэхгүй байх.
- **Сэтгэл санааны хувьд үл хайхрах:** Хүүхэдтэй хол хөндий харилцах, эсхүл харилцахгүй байх, хайр халамжаар дутаах, хүн гэж тоохгүй байх, хүсэл сонирхлыг нь няцаах.
- **Боловсролын хувьд үл хайхрах:** Хүүхдийн сурч хөгжих боломжийг хаах, хязгаарлах, хичээлийн хэрэгслээр хангахгүй байх, хичээл таслуулах, сургууль завсардуулах, хөдөлмөр эрхлүүлэх.
- **Хүүхдийг эрсдэлд оруулах нөхцөл бүрдүүлэх:** Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхих, аюултай нөхцөл байдлыг мэдсээр байж, хүүхдийг хамгаалахаас зайлсхийх.

Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд хаягдах, орхигдох, толгой хорогдох орон гэргүй болох, эрүүл мэндийн үзлэгт хамрагдахгүй байх, хараа хяналтгүй байх, хүнсний зориулалтын бус элдэв хорт бодис, эм уух, цаг уурын байдалд үл тохирсон хувцас өмсөх, хувийн ариун цэвэр муу сахих, үүнээс болж

¹³ Монгол улсын хувьд бие даасан хүчирхийллийн төрөлд хамааруулаагүй боловч хууль тогтоомжуудад үл хайхрах гачигдуулах хүчирхийллийн үйлдэл хэлбэрийг тусгасан байдаг.

¹⁴ <https://abuseandneglectdefense.com/physical-neglect/>

бөөстөх, сайртах, арьсны өвчин тусах зэрэг шинжүүд илрэх, үе тэнгийн хүүхдүүдээсээ хөгжлөөрөө хоцрох, сургууль, олон нийтийг хамарсан арга хэмжээнд очихгүй байх гэх мэт шинжүүд түгээмэл илэрдэг байна. Хамгийн хүнд илрэх хэлбэр нь хүүхдийг үл хайхарснаар хүүхэд хэнд ч хэрэггүй гэж өөрийгөө хорлох, егүүтгэх гэж оролдох үйлдэл гаргадаг нь өсвөр насны дунд нэмэгдэх хандлагатай байгаа нь маш харамсалтай юм.

III. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”¹⁵ гэж заасны дагуу Улсын Их Хурлаас Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг тус тус баталсан. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Эх нялхасонцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой”¹⁶, Хүүхдийн эрхийн тухай хуульд “ Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй”¹⁷ гэж заасан байдаг. Үл хайхрах байдал гэдгийг “Хэн нэгэн этгээд хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, аюулгүй байдал, хайр халамжаар хангах зэрэг суурь хэрэгцээг гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахыг завдсан, энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байдлыг хэлнэ” хэмээн тодорхойлжээ. Хүүхдийн эрхийн тухай конвенцод “гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр”¹⁸ хэмээн тодорхойлсон байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд үл хайхрах хэмээх ойлголтыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ.

¹⁵ Монгол Улсын Үндсэн хууль, 16.11, 1992

¹⁶ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 25 дугаар зүйл 25.2, 1946

¹⁷ Хүүхдийн эрхийн тухай хууль, 7 долдугаар зүйл, 2016

¹⁸ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 19 дүгээр зүйл 19.1, 1989

- Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд¹⁹ хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архи дан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно гэж заасан. “Сэтгэл санааны хүчирхийлэл” гэдэгт хохирогчийн хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэсэн үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно²⁰ гэж заасан. Сэтгэл санааны хүчирхийлэл нь хамгийн түгээмэл үйлдэгддэг ч хохирогч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байна гэж таньдаггүй тул байнга давтагдаж байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн бусад хэлбэрүүдтэй хавсардаг, нүдэнд илт харагдаж мэдэгдэхгүй тул үр дагавар, хор уршгийг хэмжих, нотлоход төвөгтэй байдаг байна²¹. Сэтгэл санааны хүчирхийллийн үр дагавар нь хохирогчийг байнгын айдас, түгшүүр, ганцаардал, сэтгэл гутрал, сэтгэцийн хямрал, гэмтэл болон амиа хорлоход хүргэх аюултай байна. Учир нь бие махбодын хувьд нөхөн сэргээж болдог бол сэтгэл зүйн хохирлыг нөхөн сэргээх нь их цаг хугацаа шаарддаг төдийгүй хэмжиж хохирлыг барагдуулахад учир дутагдалтай байдаг.

Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудад заасан өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг гэр бүлийн хамаарал бүхий этгээд нь хүчирхийлэл үйлдэх, тодорхой эс үйлдэл хийх нь зөрчил болон гэмт хэрэг хэмээн үзэж хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Дээрх хуулиудад хүчирхийллийн зарим үйлдэл, эс үйлдлийг нэг бүрчлэн нэрлэн дурдаж, хууль бус гэж үзэж хориглосон байх ба хариуцлагыг Зөрчлийн болон Эүүгийн хуулиар хүлээлгэхээр заасан. Гэтэл Зөрчлийн болон Эрүүгийн хуульд тухайн үйлдэлд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт хангалтгүй, зарим тохиолдолд зохицуулалт дутмаг байна. Тухайлбал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2 дахь заалт гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх, мөн хуулийн; 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ гэж заасан боловч зөрчлийн хувьд тухайлсан зохицуулалт байхгүй байна.

¹⁹ 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд тусгагдсан этгээд.

²⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 6 дугаар зүйл 6.3, 2016

²¹ Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт, ХЭҮТ, 2019 он

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно заасан бөгөөд зарим зохицуулалт нь хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт, зарим нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хамаарахаар зохицуулжээ. Энэ нь субъектийн хувьд гэр бүлийн хамааралтай болон хамааралгүй субъектээс хүчирхийлэл үйлдэх гэсэн агуулга бүхий боловч зарим зохицуулалт нь тодорхой бус, зарим нь давхцалыг бий болгохоор байна. Эдгээрээс дүгнэхэд материаллаг хуулиудын уялдаа холбоо дутмаг, эрх зүйн зохицуулалт хийдэлтэй, давхардалтай байгаа нь хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл гарах, тухайн эрх зүйн харилцаанд оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдөх, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хууль хэрэглээний алдаа гарах эрсдэлийг бий болгож байна.

Зөрчлийн тухай хуульд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан, хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг хэрэглүүлсэн, хүүхдийг дархлаажуулалтад хамруулах үүргээ биелүүлээгүй, хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Мөн хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно²² гэсэн нь бусад асран хамгаалалт шаардлагатай, хүчирхийлэлд өртөх магадлал өндөр хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настантай харьцуулахад үл хайхрах хэлбэрт хариуцлага хүлээлгэхээр заасан нь сайшаалтай байна.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийг зөрчих 15 зөрчлийг хуульчилсан байдаг. Судалгаанаас харахад Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан “Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн” зөрчил нийт зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 2020 онд бүртгэгдсэн 3215 зөрчлийн 80.7 хувь нь, 2021 оны нэгдүгээр улиралд бүртгэгдсэн 1162 зөрчлийн 96.7 хувийг дээрх төрлийн зөрчлийн хэрэг эзэлж

²² Зөрчлийн тухай хууль, 6 дугаар зүйл 6.20, 2017

байна. Мөн шүүхийн шийтгэвэрт хийсэн дүн шинжилгээгээр 1207 тохиолдлын 14.3 хувь нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан “Шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг 3 сараас дээр хугацаанд төлөөгүй” зөрчил эзэлж, 1034 буюу 85.6 хувь нь “Хүүхдийн дэргэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн” зөрчил эзэлж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн дам хохирогч нь хүүхэд болж байгааг харуулж байна. Мөн шүүхээс хүүхдэд тэтгэлэг тогтоосон хэдий ч тэтгэлгийг төлөхгүй байгаа нь хүүхдээ үл хайхарч байгаа жишээний нэг юм.

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийн ихэнх нь зөрчлийн хуулиар шийдвэрлэгдэж хүчирхийлэл үйлдсэн этгээдэд баривчлах, албадан сургалтад хамрагдах хариуцлага хүлээлгэж байна. Баривчлагдах хугацаанд хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж маргааныг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, уур бухимдал, сэтгэл зүйгээ удирдах зэрэг зөв амьдралын дадал хэвшлийг суулгахад анхаарч сургалтыг зохион байгуулж байгаа хэдий ч хүчирхийлэл үйлдэгч үйлдлээ давтах, засарч сайжрахгүй байгаа нь цөөнгүй байна. Тиймээс Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэх хариуцлагын нэг төрөл болох зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарах, тэр дундаа хууль зүйн болон сэтгэл зүйн шинжлэх ухааныг хослуулан хөгжүүлэх хэрэгцээ гэр бүлийн харилцааны хүрээнд илүү шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхэд хохирлоо нэхэмжлэх, зөрчигдсөн эрхээ сэргээх асуудал нь хүүхэд бие даан холбогдох байгууллагад хандах эрх зүйн бүрэн чадамжгүй байх, эцэг, эх, гэр бүлийн харилцан хамааралтай хүн гэх талаас нь харж хохирлоо барагдуулахгүй байх, төлөөлөх эрх бүхий этгээд нь хуулийн дагуу хамгаалах хүчин чармайлтыг төдийлөн гаргадаггүйгээс хүүхэд бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн аль ч хэлбэрт өртсөн насаараа хохирогч байх, сэтгэлзүйн гэмтэл авах, айдас түгшүүртэй амьдрах шалтгааны нэг хэсэг болж байгаа нь харамсалтай байна. Тухайлбал Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо²³ны үйлчилгээг 2019-2020 онд авах шаардлагатай үйлчлүүлэгчийн 68-71 хувийг хохирогч, гэрч-хохирогч эзэлж байна, хохирогч хүүхдэд хууль зүйн тусламж үзүүлэх албан тушаалтнууд хангалтгүй ажиллаж байна²⁴ гэж тайланд дурдсан байгаа нь хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ хангалтгүй, хохирлоо барагдуулах асуудал орхигдож байгаа нь үндсэн хуульд заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх,

²³ Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) 4 дүгээр зүйл 4.3.1 гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг хэлнэ.

²⁴ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа, үнэлгээний тайлан 2021

эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна, гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална, Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” гэсэн зохицуулалт бодит байдалд биеллээ олохгүй байгааг илтгэнэ.

Эрүүгийн хуулийн 2015 оны шинэчилсэн найруулгын хувьд байнга²⁵ гэсэн шинжийг хангасан байж гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай байгаа нь цаг хугацааны хувьд давтамж хэдий хугацаанд үйлдэгдсэн байх тодорхой зохицуулалт байхгүйгээс хэрэглэхэд хүндрэл учруулдаг. Мөн харгис, хэрцгий догшин авирласан үйлдэл дээр ч байнга гэсэн шинжийг хангасан байх нь зохистой эсэхийг эргэн харах зүйтэй. Эрүүгийн хуульд хүчирхийллийн хэлбэр тус бүр уг хуулийн агуулгад тусгалаа олсон хэдий хууль хэрэглээнд бие махбодын хэлбэрт хариуцлага хүлээлгэх бусад хэлбэрийн хувьд нотлох баримт байхгүй, гэмт хэрэг үйлдсэн гэж тогтоогдохгүй байна гэх үндэслэлээр хэрэг үүсгэдэггүй нь хуулийг хэрэгжүүлэхэд нэг мөр ойлголтыг бий болгох, материаллаг хохирол шаарддаг, заавал гомдол гаргаснаар хүүхдийг хохирогчоор тогтоох, хохирлыг барагдуулах асуудал байгаа нь хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй байх, хүүхдийн эрх зөрчигдсөөр байх шалтгааны нэгээхэн хэсэг болж байна.

Өмнөх буюу 2002 оны Эрүүгийн хуульд хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгээр гэр бүлийн хүчирхийлэл болон насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, хүүхэд солих, хууль бусаар үрчлэх, хүүхэд хаях, төөрүүлэх, асран хамгаалах үүргээ урвуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах, эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх²⁶ зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохоор зохицуулж байсан. Одоогийн үйлчилж буй Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэг²⁷ тусдаа бүлэг болгон хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах, Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, Хүүхдээр гуйлга гуйлгах, Хүүхэд солих, Хүүхэд худалдах, Хүүхэдтэй хэрцгий харьцах, Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэхтэй холбогдсон үйлдэлд эрүүгийн

²⁵ Улсын дээд шүүхийн 2019.10.16-ны №506 тогтоол “Байнга гэдэг нь тоон илэрхийллийн хувьд гурав болон түүнээс дээш удаа үйлдэгдсэн байхыг авч үздэг хууль хэрэглээний ойлголт юм”.

²⁶ Эрүүгийн хууль, 17 дугаар бүлэг 114-122 дугаар зүйл, 2002

²⁷ Эрүүгийн хууль, 16 дугаар бүлэг, 16.1-16.11, 2015

хариуцлага хүлээлгэхээр заасан. Өмнөх хуультай харьцуулахад хүүхэдтэй хэрцгийн харьцах үйлдэл нэмэгдсэн бол өмнөх хуульд байсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх үйлдлийг эрүүгийн хуулиас авч зөрчлийн хуулиар²⁸ зохицуулсан.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн биед гэмтэл учирсан нь шүүх эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдсэн байсан ч Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгийн 11.1 дэх хэсэг (Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах), 11.4 дэх хэсэг (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах), 11.6 дахь хэсэг (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах) г.м зүйлүүдийн хүндрүүлэх нөхцөлд хамааруулан зүйлчилж шийдвэрлэдэг практик байна. Гэмтэл учруулахгүйгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хоригдох бол гэмтэл учруулж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх хөнгөн шийтгэл ногдуулахаар заасан нь хөнгөнөөс хүндрүүлэх зарчим алдагдаж ял завших боломжийг хууль тогтоогчийн зүгээс олгосон гэж үзэхээр байгаа тул эргэн харах нь зүйтэй юм.

Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран хийсэн судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртсөн, түүнээс 2 хүүхэд тутмын 1 нь бие махбодын хүчирхийлэлд, 4 хүүхэд тутмын 3 нь сэтгэл санааны хүчирхийлэлд, 3 хүүхэд тутмын 1 нь үл хайхрах хүчирхийлэлд, 8 хүүхэд тутмын 1 нь бэлгийн шинжтэй дарамт, халдлагад өртсөн²⁹ байна гэжээ. Давтамжийн хувьд хүүхдүүд бие махбодын хүчирхийлэлд хамгийн их өртдөг бөгөөд энэ нь ихэвчлэн гэр бүл, сургуулийн орчинд өртсөн байна.

Хүснэгт 1. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн судалгаа (2018-2020)³⁰

| № | Гэмт хэрэг | 2018 | 2019 | 2020 |
|---|---|------|------|-------|
| 1 | Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 16.1-16.11 | 21 | 31 | 17 |
| 2 | Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх 16.3 | 6 | 9 | 6 |
| 3 | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг | 1070 | 985 | 1138 |
| 4 | Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил | 7134 | 8962 | 10306 |
| 4 | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхэд | 93 | 90 | 141 |

²⁸ Зөрчлийн хууль 6 дугаар зүйл 6.20.1.4, 2017

²⁹ Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа, УБ, 2016

³⁰ <https://police.gov.mn/resource/information> статистик судалгаа болон Монгол Улсын шүүн таслах ажиллагааны тайлангаас авав.

Судалгаанд дурдсан тоог мөсөн уултай харьцуулбал зөвхөн ил харагдах орой хэсэг нь юм. Гэр бүлийн хүчирхийлэл хаалттай хаалганы цаана, нуугдмал хэлбэрээр оршиж байдаг нь бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс ялгаатай. Гэр бүл, өөрийн нэр хүнд, гэр бүлийн асуудал, бусдад хамаагүй, дотоод асуудал, хүүхэд өөрийн эсрэг хууль бус үйлдлийг хүлцэн тэвчих, мэдэхгүй байх зэрэг асуудлаас үүдэж хохирогч мэдээлэхгүй байх тохиолдол цөөнгүй. Энэ нь хүчирхийлэл үйлдэгчийг өөгшүүлж үйлдлээ ухаарахгүй давтсаар байгаад бусдын бие махбодод хохирол учруулах, сэтгэл санааны гутралтай болгох, улмаар амь нас нь хохирох хэмжээнд хүртэлх ноцтой үр дагаварт хүргэдэг. Ихэнх гэр бүлийн хүчирхийлэл давтамжтай, олон жил үргэлжилсэн шинжтэй байдгийг зохих судалгаанууд нийгэмд ил болгож асуудлыг хөндөн нөлөөллийн ажлыг хийж байгаа боловч гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй, хүүхдүүд хүчирхийллийн золиос болсоор л байна.

Судалгаанд дурдсанаар хүүхэд хохирсон бусад зөрчлийн хэргүүд гарахгүй байна уу гэвэл үгүй. Илрүүлэлт хангалтгүй байгаа учраас хяналт шийдвэрлэлтийн ажиллагаа явагдахгүй байгаа³¹-тай холбоотой гэж үзжээ. Зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлд согтууруулах ундааны хэрэглээ нөлөөлж байна. Учир нь нийт тохиолдлын 66.7 хувь нь зөрчил үйлдэх үедээ архи согтууруулах ундаа хэрэглэсэн байсан. Хүүхдийн эрхийн зөрчлийн 90 орчим хувь нь ахуйн хүрээнд буюу орон гэртээ үйлдэгдсэн бол 65.8 хувь нь хүүхдийн шууд хамаарал бүхий хүн буюу төрсөн эцэг нь хүүхдийнхээ эрхийг зөрчиж байгаа нь тогтоогдсон. Зөрчил үйлдэж байгаа хүмүүсийн 46.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 79.1 хувь нь 27-45 насны хүн байна. Ихэвчлэн оройн цагаар үйлдэгдэж байна. Эндээс харахад хүүхэд гудамжинд явж байгаад эрх нь зөрчигдөхөөс илүү хамгийн тайван, эрсдэлгүй, аюулгүй байх ёстой орчиндоо буюу орон гэртээ, гэр бүлийнхээ хүрээнд эрх нь зөрчигдөж байна гэж дүгнэж болохоор байна. Иймд өмнө нь дурдсан суурь шалтгааныг бууруулах нь хүүхэд гэр бүлдээ эрх нь зөрчигдөхгүй байхад нөлөөлөх гол хүчин зүйл болохыг баталж буй юм.

Улсын хэмжээнд 2018-2021 онд 12,461 хүн түр хамгаалах байраар үйлчлүүлсэн³². Үүнээс 2021 онд улсын хэмжээнд ажиллаж байгаа 35 ТХБ, НЦҮ-ний төвөөр 4275 хүн үйлчлүүлсэн байна. Үүний 67,8 хувийг хүүхэд эзэлсэн бөгөөд эдгээр хүүхдүүдийн 70 хувь нь гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүчирхийлэлд өртөж хохирсон. 47 хувь нь хоёроос дээш удаа түр хамгаалан байрлуулах үйлчилгээ авсан байгаа нь хүүхэд удаа дараа гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртөж

³¹ <https://www.arслан.mn/social/news/632926.shtml> Улсын ерөнхий прокурорын газар “Хүүхдийн эрхийн зөрчлийн өнөөгийн байдал” 2021 онд хийсэн судалгаанаас дэлгэрэнгүйг үзэх боломжтой.

³² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны статистик мэдээлэл, УБ,2021

байгааг харуулж байна. Хүчирхийллийн эсрэг үр нөлөөтэй тэмцэхэд эрх зүйн орчноос гадна хэрэгжүүлэх, хяналт тавих, хариуцлагын үр нөлөөтэй байдал, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой юм. Ялангуяа хариуцлагын үр нөлөөтэй байдал анхаарах, ямар хэлбэрээр хүүхдийг хүчирхийлсэн эсэх, үл хайхрах хүчирхийллийг үйлдлийн хор уршгийг таниулах, хэлбэрт бүрд тохирсон хариуцлагын механизмын бий болгоход чиглэх шаардлага байна.

Гэр бүлийн хүчирхийллийн загвар (НҮБ) хуульд хамгаалах байрны санхүүжилт, засвар үйлчилгээ, ажилтнуудын сургалт болон хүчирхийлэл үйлдэгчээс хамгаалах байрны журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудлыг тусгасан. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зориулсан санг байгуулах, уг сангийн хөрөнгийг гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг аврах, анхан шатны материаллаг туслалцаа болон нөхөн олговор, хохирогчийг хүлээн авах хоргодох байрны засвар үйлчилгээ, хоргодох байр, нөхөн сэргээх асуудалд холбогдох ажилтан этгээдүүдийн сургалт болон чадавхыг нэмэгдүүлэхэд зарцуулах³³ газар зүйн болон тээврийн бэрхшээл, зардал, айдас, ичгүүрээс хамааран хөдөө амьдарч байгаа эмэгтэйчүүдэд хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна. Хязгаарлалтад нөлөөлж байгаа хүчин зүйлсийг дурдвал: хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний талаарх мэдээлэл дутагдалтай, хүчирхийллээс ангид байх талаар олон нийтийн ойлголт дутмаг, эдгээр байрууд 24 цагаар ажиллаж чаддаггүй, хоол хүнс, нэн шаардлагатай зүйлс хангалтгүй, орон тооны ажилтангүй, эмч нар хүчирхийллийн хохирогчийг илрүүлэх арга мэддэггүй зэрэг байдал нөлөөлж байна³⁴ гэж үзсэн нь одоо ч бүрэн шийдвэрлэгдээгүй бөгөөд хамгаалах байр байхгүй, суурингаас алслагдмал амьдарч буй хүүхдүүд аюултай орчиндоо үлдэхээс өөр сонголтгүй, хүчирхийллийн дарамт, нөлөөг даван туулахгүй эрсдэх аюултай байгаа хэвээр буй юм. Хөдөө, суурин газраасаа алслагдмал хүүхдүүдийн хувьд илрүүлэх, арга хэмжээ авах асуудал орхигдох, уламжлалт хандлагаар биеэ даах, багаасаа өлчир даван туулах чадвартай болно гэх хандлага сэтгэлгээ нь олон хүүхдийг хуулийн зохицуулалтаас гадуур, хамгаалалтгүй үлдэх шалтгаан болж байна. Монгол Улсын хэмжээнд хамгаалах байр нийслэл болон аймгуудад³⁵ байрлан үйл ажиллагаа явуулж байна.

³³ НҮБ-ын загвар хуулийн 40 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг дэмжих сан

³⁴ Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан, НҮБ-ын Хүн амын сан, 2018

³⁵ Манай улсад нийт 35 түр хамгаалах байр ажиллаж байгаагийн 22 нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 6 цагдаагийн байгууллага, 4 эрүүл мэндийн байгууллага, 3 төрийн бус байгууллагыг түшиглэн ажиллаж байна. Түр хамгаалах байрыг хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан төрийн, төрийн бус байгууллагын харьяанд, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн харьяалаар байгуулан ажиллуулах бөгөөд ТХБ-ны үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг НХХЯ, ТХБ-ны үйлчилгээ үзүүлэх журмыг ХНХЯ-наас тус тус баталсан байна. Стандартчлал, хэмжил зүйн газрын 2019 оны С/07 дугаар тушаалаар “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2019 стандартыг баталж, улсын хэмжээнд мөрдүүлж байна.

Гадаадын зарим улсын зохицуулалтаас үзэхэд Сербии улсын Эрүүгийн хуульд гэр бүл, гэр бүлийн холбоотой гэмт хэрэг нь³⁶ 193 дугаар зүйлийн 193.1 дэх хэсэгт Насанд хүрээгүй хүүхдийг үл хайрах, гачигдуулах буюу насанд хүрээгүй хүнийг асран хүмүүжүүлэх үүргээ зохих ёсоор гүйцэтгэхгүй, гэр бүл, асран хамгаалагч, бусад асран хүмүүжүүлэх үүрэгтэй хүмүүс насанд хүрээгүй хүүхдээ гачигдуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Мөн хуулийн 193 дугаар зүйлийн 193.2 дахь хэсэгт Эцэг эх, үрчилж авагч, асран хамгаалагч эсвэл насанд хүрээгүй хүүхдийг үл хайхарсан эсвэл түүнийг насандаа тохирохгүй хэт их хөдөлмөр хийлгэсэн, эсхүл түүнийг хөгжүүлэхэд нь сөргөөр нөлөөлөх бусад үйл ажиллагаа эрхлэхийг өдөөсөн эцэг, эх, үрчлэгч, асран хамгаалагч, бусад этгээдэд гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Эрүүгийн хуулийн 194 дүгээр зүйл Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 194.1 Хүчирхийлэл, амь нас, бие мах бодийн эсрэг заналхийлэх, үл хайхрах, харгис хэрцгий зан үйл хийх замаар түүний гэр бүлийн гишүүний тайван байдал, бие махбодын бүрэн бүтэн байдал, сэтгэцийн байдалд аюул учруулсан бол гурван сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Сербийн эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь “Гэр бүл, гэр бүлийн холбоотой гэмт хэрэг” гэсэн бүлэгт хамаардаг бөгөөд бусад ойролцоо төрлийн гэмт хэргүүдийг бүлэглэн авч үзсэн байдаг. Ялангуяа үл хайхрах гачигдуулах хүчирхийллийг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг болон насанд хүрээгүй хүүхдийг үл хайрах, гачигдуулах, тэжээн тэтгэх үүргээ гүйцэтгэхгүй байх, гэр бүлийн үүргээ гүйцэтгэхгүй байх зэрэг хэдэн гэмт хэрэг дээр ялгамжтай зааглаж зохицуулсан байна.

Албани улс нь үл хайхрах, гачигдуулах хүчирхийллийг Албани улсын хувьд ёс суртахууны хүчирхийлэл (Moral) гэдэг хүрээнд авч үзсэн байна Гэр бүлийн харилцаан дахь хүчирхийллийн эсрэг авах хариуцлагын тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэр бүлийн гишүүд, ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн хуулийн арга хэрэгслээр дамжуулан хамгаалалтыг баталгаажуулах явдал” хэмээн хуулийн зорилгоо тодорхойлсон байна. Уг хуулийн нэгдүгээр зүйлд хүчирхийлэл (Violence) гэдэг нь нэг нь нөгөө хүнийхээ эсрэг бие махбод (physical), ёс суртахууны (moral), сэтгэл зүйн (psychological), бэлгийн (sexual), нийгэм, эдийн засгийн (social and economic) бүрэн бүтэн байдлыг зөрчих ямар нэгэн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Мөн хуулийн хоёрдугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн харилцаатай эсвэл урьд нь тийм

³⁶ Serbia: Criminal Code, 2005, available at: <https://www.refworld.org/docid/48ff404a2.html> [accessed 16 July 2021]

харилцаатай байсан хүмүүсийн хооронд нэгдүгээр зүйлд заасан хэлбэр, үйлдлийн аль нэгээр үйлдсэн аливаа хүчирхийллийг хэлнэ³⁷ гэж заажээ.

Бүгд Найрамдах Солонгос улсын гэр бүлийн хүчирхийллийн шийтгэлийн тухай³⁸ хуулиар гэр бүлийн хүчирхийллийг тодорхойлж хариуцлага хүлээлгэх асуудлыг эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг. Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйл төрөл садандаа гэмтэл учруулсан этгээдийг долоон жилээс дээшгүй хугацаагаар хорих, арван жилээс дээшгүй хугацаагаар мэргэшүүлэх эрхийг түдгэлзүүлэх, арван сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Уг гэмт хэргийг эхнэр, нөхрийнхөө удам угсаа залгамжлагчдын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг арван жилээс илүүгүй хугацаагаар ажил хийлгэх эсхүл арван таван сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Эрүүгийн хуулийн 260 зүйл зодох, байнга зодож хүний биед халдсан этгээдэд хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ял, таван сая воноос хэтрэхгүй торгууль, цагдан хорих, насанд хүрээгүй хүүхдийг шийтгэнэ. Эхнэр, нөхрийнхөө удам угсааны эсрэг уг гэмт хэргийг үйлдсэн этгээдийг таван жилээс илүүгүй хугацаагаар хорих эсвэл долоон сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Мөн хуулийн 261 дүгээр зүйл дээрх хэсэгт заасан гэмт хэргийг хэрцгийгээр зодох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг таван жилээс илүүгүй хугацаагаар хорих, арван сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Уг хэргийг давтан үйлдсэн бол гэмт хэрэгт оноосон ялыг хүртэл хүндрүүлэх³⁹-ээр хуульчилжээ.

Дээрх зохицуулалтуудаас харахад хүчирхийлэл үйлдэгчийг өргөн хүрээнд хамааруулан хуульчилсан нь ойролцоо байх бөгөөд үл хайхрах хүчирхийллийн хэлбэрийг Серби улс тодорхой заасан байна. Хүчирхийллийн суурь шалтгаан нь архидалт, ядуурал биш харин эрх мэдлийн тэнцвэргүй байдлаас үүдэлтэй гэж АНУ, Тайвань, Солонгос гэх мэт улсуудад үздэг байна. Үүнээс үзэхэд суурь шалтгаанд эрх мэдлийн тэнцвэр хамааралтай, үүнээс үүдэж бусад хүчин зүйлүүд бий болдгийг харж болохоор байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³⁷ ON MEASURES AGAINST VIOLENCE IN FAMILY RELATIONS No.9669 of 18.12.2006 <https://www.osce.org/files/f/documents/4/6/30436.pdf>

³⁸ Бүгд найрамдах Солонгос улсын гэр бүлийн хүчирхийллийн шийтгэлийн тухай хууль 2015 оны 07 сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

³⁹ Бүгд найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль 1953 онд батлагдсан. Үүнээс хойш 22 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хүүхдийг үл хайхрах хүчирхийллээс хамгаалахын тулд эрх зүйн орчныг бий болгох нь хангалтгүй юм. Хангалтгүй учраас ч өнөөгийн нийгэмд хүүхдийн эсрэг хүчирхийлэл чимээгүй, хариуцлагаас ангид хаалттай хаалганы цаана байсаар байна. Иймд Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтэндээ анхаарч хүрэлцэхүйц санхүүжилт, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх нь хамгийн чухал байна. Ингэснээр хэрэгжилт хангагдах, гэмт хэрэг, зөрчил буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлөх юм. Хууль байгаад түүнийг хэрэгжүүлэх, сахиулах хүн байхгүй бол бодит байдал дээр асуудал шийдэгдэхгүй гэдгийг бүх шатанд ойлгох, үүргээ хариуцлагатай, ухамсартайгаар гүйцэтгэх хэрэгцээ, шаардлага байна.

Үл хайхрах хүчирхийлэлд хүүхэд гэлтгүй гэр бүлийн бүхий л гишүүд өртөх боломжтой юм. Ялангуяа асрамж, хамгаалалт шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй гишүүн, хүүхэд илүүтэй өртөж байдаг. Одоогийн эрх зүйн зохицуулалтад энэ төрлийн хүчирхийллээс дээрх субъектүүдийг хэрхэн хамгаалах эрх зүйн зохицуулалт дутмаг, энэ төрлийн зөрчил нь ямар үйлдлүүдээр илрэх нь ойлгомжтой бус, гэр бүлийн хүчирхийллийн төрөл эсэх нь ч тодорхой бус зохицуулалттай байна. Эрүүгийн болон зөрчлийн хуульд дээрх үл хайхрах, гачигдуулсан үйлдлийг санаатайгаар хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол зөрчил болон улмаар гэмт хэрэгт тооцох, цаашлаад одоо байгаа зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал хүүхдийн эрхийг зөрчих зарим зөрчил нь гэр бүлийн хүчирхийллийн зөрчилд хамаарах эсэх, энэ төрлийн зөрчлийг үйлдвэл байнга эсвэл удаа дараа зөрчвөл Эрүүгийн хуулийн 11.7.2.1 дэх заалт эсвэл 16 бүлгийн хамаарах аль заалтаар зүйлчлэн хариуцлага хүлээлгэхийг тодорхой болгох шаардлага байна.

Хүн төвтэй нийгэм, хүн төвтэй хөгжил гэж бодлого, мөрийн хөтөлбөр, хуульдаа зохих байдлаар тусгалаа олсон хэдий ч хүүхдийг өөртэйгөө ижил тэгш эрхтэй хүн утгаар нь ойлгох, хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх хандлага төлөвшил гэр бүлийн хүрээнд ч хангалтгүй байгаа нь харамсалтай юм. Иймд хүүхдийг хамгийн аюулгүй, амар амгалан байх орчин болох гэр бүлийн орчноос эхлээд түүний хүрээлэлд байх гэр бүлийн харилцан хамаарал бүхий хүмүүсийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар мэдлэгтэй болгох, өөрийн хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, бусдын хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэргийн хажуугаар дуугай өнгөрдөггүй, зохих газарт нь мэдэгддэг болгож хэвшүүлэх чухал ач холбогдолтой юм. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үл хайхрах асуудал тулгамдсан асуудал боловч хамгаалах, таслан зогсоох, хариуцлага тооцох асуудал хангалтгүй орхигдож байгаа нь цаашид

үл орхиж болох анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай асуудал гэдгийг онцгойлон тэмдэглэх нь зүйтэй.

Хүүхдийг хамгаалах асуудал нь зөвхөн эрх бүхий байгууллага, албан тушаалтны анхаарч хийх ажил мэт ойлгох бус бүх байгууллага, хүн бүр үүрэг, хариуцлага хэмээн ойлгон тэмцэх, шаардлагатай арга хэмжээг авах, мэдээлэх, хамтарч ажиллахыг чухлыг олон нийтэд ойлгуулах, сурталчлах таниулах нь үр дүнтэй юм.

V. НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992
2. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль 2016
3. Хүүхдийн эрхийн тухай хууль 2016
4. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль 2016
5. Эрүүгийн хууль 2002
6. Эрүүгийн хууль 2015
7. Зөрчлийн тухай хууль 2017
8. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948
9. Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989

Монгол эх сурвалж:

1. Д. Зүмбэрэлхам “Криминологийн онол” 2022
2. Улсын ерөнхий прокурорын газар “Хүүхдийн эрхийн зөрчлийн өнөөгийн байдал” судалгаа 2021
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны статистик мэдээлэл, 2021
4. ҮСХ Нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа, 2020
5. Монгол Улс дахь хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээ, НҮБ-ын Хүүхдийн сан, 2019
6. Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан, НҮБ-ын Хүн амын сан, 2018
7. НҮБ-ын ХЭХ-оос Монгол Улсад ирүүлсэн 5-р дүгнэлт зөвлөмж 2017
8. Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа 2016
9. Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт, ХЭҮТ, 2019

10. Стандартчилал, хэмжил зүйн газрын 2019 оны С/07 дугаар тушаалаар “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2019
11. Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны тайлан 2018-2021
12. Цагдаагийн ерөнхий газар “Гэмт хэрэг, зөрчлийн мэдээ” 2018-2021

Гадаад эх сурвалж:

1. World report on violence and health, World Health Organization, Geneva, 2002
2. Richard J. Bonnie and Robert B. Wallace. Elder Mistreatment. Abuse, Neglect, and Exploitation in an Aging America. 2003. USA
3. ON MEASURES AGAINST VIOLENCE IN FAMILY RELATIONS No. 9669 of 18.12.2006
4. Serbia: Criminal Code, 2005
5. <https://www.refworld.org/docid/48ff404a2.html> [accessed 16 July 2021]
6. Richard J. Bonnie and Robert B. Wallace. Elder Mistreatment. Abuse, Neglect, and Exploitation in an Aging America. 2003. USA
7. Theoklitou D, Kabitsis N, Kabitsi A (2012). “Physical and emotional abuse of primary school children by teachers”. Child Abuse Negl. 36 (1): 64–70
8. Beccaria, C “On crimes and punishment”. New Brunswick, NJ Transaction Publishers 1764/2009
9. Бүгд найрамдах Солонгос улсын гэр бүлийн хүчирхийллийн шийтгэлийн тухай хууль 2015
10. Бүгд найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль 1953

Бусад эх сурвалж:

1. <https://www.arслан.mn/social/news/632926.shtml>
2. <https://mlsp.gov.mn/content/detail/1084>
3. <https://police.gov.mn/resource/information>
4. <https://www.arслан.mn/social/news/632926.shtml>
5. <https://www.osce.org/files/f/documents/4/6/30436.pdf>
6. https://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK98802/pdf/Bookshelf_NBK98802.pdf
7. <https://abuseandneglectdefense.com/physical-neglect/>



Л.НЯМДАВАА

ДХИС-ийн докторант, цагдаагийн хурандаа

ЦАГДААГИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙГ ТОДОРХОЙЛОХ ХҮЧИН ЗҮЙЛ, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ ELEMENTS AND UNIQUE FEATURES OF POLICE ETHICS

Хураангуй: Энэхүү өгүүлэлд цагдаагийн мэргэжлийн ёс зүйг тодорхойлох хүчин зүйл, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлалын талаар болон мэргэжлийн ёс зүйн бүрэлдэх тогтолцоо болох мэдлэг, бодол эргэцүүлэл, сэтгэхүй, хандлага, зан үйл, харилцаа, ёс зүй гэсэн эрдэмтийн санаан дээр үндэслэн “мэдээлэл” хэмээх ойлголтыг нэмэх талаар өөрийн саналыг дэвшүүлсэн болно.

Abstract: This article briefly discusses about the factors that determine professional ethics and attitudes, their interrelationships, the ideology of scientists and researchers, and based on scientific ideas such as knowledge, reflection, thinking, attitudes, behavior, communication, and ethics, which are the components of professional ethics suggested to add the concept of "information".

Түлхүүр үгс. Мэргэжлийн ёс зүй, хандлага, харилцаа, зан төлөв, мэргэжлийн үүрэг, мэргэжлийн хариуцлага.

Keywords: Professional ethics, Attitudes, Relationships, Behavior, Professional duties and Professional Responsibilities.

I. ҮНДСЭН ХЭСЭГ

Доктор Ц.Гомбосүрэн “Ёс зүй” сурах бичигтээ “Ёс зүй нь гүн ухааны нэгэн салбар бөгөөд ёс зүйн талаарх сайн эсвэл муу, зөв эсвэл буруу, сайн үйл эсвэл муу үйл, хууль дүрэм эсвэл гэмт хэрэг гэх мэт зүйлүүдийг судална. Ёс зүй хэмээх ойлголт нь эртний Грекийн “Ethos” буюу хамтран амьдрах, оршин амьдрах газар утгатайгаар илэрхийлэгддэг байсан. Хожим нь хөгжлийн явцад “ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг” гэсэн агуулгатай болж, тэдгээрийн шинж чанарыг илэрхийлэх болжээ¹.

Ёс зүй нь зарим тохиолдолд эрх зүйгээс ч ихээхэн хүчтэй байдаг нь хүмүүс түүнийг ямар нэгэн албадалгүйгээр өөрсдөө тогтоож, урт удаан хугацааны туршид зан үйлээрээ журамлан зохицуулж ирсэнд оршдог. Нийгмийн уур амьсгал бүрэлдэн тогтоход ёс зүй нь хоёр талт нөлөө үзүүлсээр ирсэн.

Мэргэжил гэдэг нь Профессия (лат. profectio; от profitor - «өөрийн үйл хэргийг тунхаглаж байна»²) гэсэн латин үгнээс гаралтай ба олон улсад “Profession” гэж нэрлэгддэг. Мэргэжил нь тусгай сургалт эсвэл тусгай боловсролын явцад олж авсан онолын мэдлэг, практик ур чадварыг эзэмшсэн байхыг хэлдэг.

Мэргэжлийн ёс зүй: Ёс зүй нь судлах зүйлээ онолын хийгээд практик талаас нь авч үзэж, шийдвэрлэж байдаг. Үүний учир шалтгаан нь ёс суртахууны шинжтэй асуудал хүний амьдралын бүхий л салбарт үүсэн бий болж байдаг оршдог. Ёс зүй нь нийгэм-хүмүүнлэгийн аль ч ухаанаас илүүтэйгээр нийгмийн амьдрал, хүний үйлдэл, үйл ажиллагаа, харилцаатай нягт холбогддог онцлогтой. Мэргэжлийн ёс зүйн талаар судалсан эрдэмтэн, доктор, гүн ухаантнуудаас дурдвал Аристотель³, Ж.Бентам⁴, Т.Гоббс, З.Китийский⁵, Ж.Локк⁶, Ж.Руссо⁷, Ф.Ницше⁸ гэх зэрэг төлөөллүүд байна.

АНУ-ын ёс зүй судлаач Ж.Свара “Ёс зүй нь үүрэг, зарчим, тодорхой зан чанар, нийгэмд ашиг тустай байх хүрээнд хүний юуг хийх ёстойг заадаг зөв болон бурууг ялгах хэм хэмжээ” гэж тодорхойлжээ. Тэрээр ёс зүйн эх сурвалжийн дөрвөн элементийг багтаасан бөгөөд нэг нь нийтийн албаны мөн чанартай холбоотой, гурав нь философийн агуулгатай. Үүнд:

¹ Бунхийхны Ц.Гомбосүрэн. Ёс зүй.2008., талб-8

² Прохоров А.М. (гл.ред.) Большой энциклопедический словарь. М.1993. с. 912.

³ Зубов В. П. Аристотель: Человек. Наука. Судьба наследия. («Научно-биографическая серия»). - М.: Изд-во АН. 1963. - 368 стр

⁴ Бентам Иеремия // Бари - Браслет. - М.: Советская энциклопедия, 1970. - (Большая советская энциклопедия : [в 30 т.]

⁵ Зенон из Кития / А. А. Столяров // Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. - 2-е изд., испр. и доп. - М. : Мысль, 2010. - 2816 с.

⁶ Локк / А. Л. Субботин // Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. - 2-е изд., испр. и доп. - М. : Мысль, 2010. - 2816 с.

⁷ Букер И. Свобода и фантазии Жан-Жака Руссо. // Правда.ру, 28.06.2012.

⁸ Dr. Large. "Nietzsche and Moral Nihilism". www.arasite.org. Retrieved 2019.

1. Үүрэг (duty): хүний эрхэлж буй ажил мэргэжил, албан тушаалтай холбогдон гарч ирэх ногдсон үүрэг хариуцлага, зан чанарын цогц;
2. Зан байдал, сайн чанар (virtue): “сайн хүн”-ийг тодорхойлох чанарууд;
3. Зарчим (principles): зан чанарын үндэс суурийг тодорхойлдог үнэн буюу зөв болон биелүүлэх ёстой үйлдлүүд;
4. Нийгэмд ашиг тустай байх (benefits to society): хамгийн олон хүнд хамгийн их сайныг авчрах үйлдэл гэж үзсэн байдаг⁹.

Мэргэжлийн ёс зүй нь нийгмийн хөгжлийг тодорхойлогч үндсэн хүчин зүйлд хүний хөгжлийн асуудалд гол байр суурийг эзэлдэг. Хүний хөгжилд мэдлэг, боловсрол голлох үүрэгтэй боловч хувь хүний ёс суртахууны ухамсар, төлөвшил чухал тул мэргэжлийн үйл ажиллагаанд ёс зүйн асуудал үргэлж нэн тэргүүнд тооцогдсоор ирсэн. Түүнчлэн мэргэжлийн ёс зүйн салбар бүр нийгмийн институтэд зайлшгүй хэрэгжүүлэх өөрийн ёс суртахууны зарчим, хэм хэмжээтэй.

Ихэвчлэн мэргэжлийн ёс зүйг өөрийн сонгосон мэргэжил, хариуцсан ажилдаа үнэнч байх, ажил үүргээ чанартай гүйцэтгэх, хувийн эрх ашгийг огоорох, мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалах, нийгмийн хариуцлагаа ухамсарлах, үүргээ чанд биелүүлэх журмын тогтолцоо гэж үздэг. АНУ-ын эрдэмтэн Деан Гюурас, Чарлиз Гарофало Нар мэргэжлийн ёс зүй хувийн ёс зүйгээс ялгаатай юу гэсэн асуултад “ёс зүй нь мэргэжлээс ангид оршдог ч мэргэжил нь ёс зүйгүйгээр оршдоггүй” хэмээн хариулсан байдаг¹⁰.

Мэргэжлийн ёс зүй нь төрийн албан хаагчийн, багшийн, сэтгүүлчийн, эмнэлгийн ажилтны, цагдаагийн, цэргийн, инженерийн, бизнесийн, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн гэх мэт мэргэжлийн онцлогоос хамаарсан олон төрөлтэй байдаг. Мэргэжил бүхэн өөр өөрийн онцлогтой бөгөөд ёс суртахууны нийтлэг зарчим, хэм хэмжээ тухайн мэргэжлийн хүмүүсийн хөдөлмөрийн явцад янз бүрээр хэрэгждэг. Судлаач Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл нар “Мэргэжлийн ёс суртахууны боловсролын ач холбогдол” илтгэлдээ “Нийгэм хөгжихийн хэрээр мэргэжилтэнд тавигдах ёс суртахууны шаардлага нэмэгдэж байна. Өнөөгийн монголын нийгэмд өндөр мэдлэг, ур чадвар бүхий иргэн шаардлагатай байгаагийн зэрэгцээ, үүрэг хариуцлагаа ухамсарласан, ёс суртахуунтай мэргэжилтэн түүнээс дутуугүй чухал юм¹¹” гэжээ.

⁹ James Svara “The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations” Jones and Bartlett Learning LLC, 2015, p.12.

¹⁰ Д.Тунгалаг “Ёс зүйн зангилаа асуудлууд”, УБ, 2015. 57-61 дахь тал.

¹¹ Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл. Мэргэжлийн ёс суртахууны боловсролын ач холбогдол-Монгол дахь ёс суртахууны боловсролын тулгамдсан асуудал. УБ, 2015. 28 дахь тал.

Мэргэжлийн ёс суртахууны үндсэн ойлголтод мэргэжлийн үүрэг, мэргэжлийн хариуцлага, мэргэжлийн нэр хүнд, мэргэжлийн үнэ цэнэ багтдаг. Өөрөөр хэлбэл, ёс зүйн шинжлэх ухааны үндсэн судлагдахуун нь ёс суртахуун билээ.

Мэргэжлийн ёс зүй бол мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны зарчим, хэм хэмжээний тогтолцоог судалдаг ёс зүйн нэг салбар билээ. Мэргэжлийн ёс зүй нь мэргэжилтэн бүр өөрсдийнхөө үйлдлийг ёс суртахууны шаардлагад нийцүүлж байх, тэрчлэн мэргэжлийн ёс суртахууны зөрчлийг илрүүлж, ёс суртахууны хувьд муу үйлдэлд хориг саад тавих зэрэг ёс суртахууны зарчим, хэм хэмжээг танин мэдэх, хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Мэргэжлийн ёс зүй бол мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны үндэслэлийг судлах ёс зүйн судалгааны чиглэл, аливаа мэргэжилтнийг бэлтгэх үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь мэргэжлийн ёс зүйд суралцах үйл ажиллагаа байдаг. Хувь хүний ёс суртахууны төлөвшлийг сайжруулах, мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх, нийгмийн харилцааг боловсронгуй болгох, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүн төрөлхтний түүхийн бүхий л цаг үед улс орнууд, эрдэмтэн мэргэд мэргэжлийн ёс зүйн асуудалд онцгой анхаарсаар ирсэн билээ.

Доктор С.Наранчимэг Мэргэжлийн ёс зүй бүрэлдэх үе шатыг доорх байдлаар авч үзсэн байна¹².

(График 1. Мэргэжлийн ёс зүй бүрэлдэх үе шат)



Үүнд:

1. Мэдлэг;
2. Бодол эрэгцүүлэл, сэтгэхүй;
3. Хандлага;
4. Зан үйл;
5. Харилцаа;
6. Ёс зүй.

¹² С.Нарантуяа. Хүн хэдийн ухаантай ч. УБ, 2010, 8-9 дэх тал.

Иймээс дээрх тогтолцооны хүрээнд цагдаагийн байгууллагын ёс зүйг авч үзье.

II. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙ

1. Мэдлэг. (Knowledge)

Мэдлэгийн тогтолцоонд мэргэжлийн ёс зүй томоохон байр суурь эзэлдэг. Орчин үед дэлхий дахинд мэргэжлийн ёс зүйн асуудлаар сургалт, судалгааны ажил улам өргөн цар хүрээтэй болж байна. ЮНЕСКО-ийн зүгээс ч мэргэжлийн ёс зүйн боловсрол бол зөвхөн хөдөлмөрийн зах зээлд орох бэлтгэл гэхээсээ илүү амьдралын үнэт зүйл, үнэ цэнийг авчирдаг¹³ билээ. Өөрөөр хэлбэл, танин мэдэх үйл ажиллагааны үр дүнд тодорхой мэргэжлээр сурч боловсрол эзэмшсэн түвшин, мэдэц ба боловсрол дадал зуршлаар ур чадвар олж авах тодорхой мэдээллийг сайн мэдэж байхыг хэлнэ.

Мэдлэгийн ёс суртахууны асуудал нь хувь хүний оршихуйн баталгааны асуудал төдийгүй нийгмийн өмнө тулгамдсан асуудлын нэг болж байна. Мэдлэгийг практик хэрэглэхэд эерэг ба сөрөг үр дагавартай. Эерэг үр дагавар нь техник, технологийн дэвшлийг бий болгож, нийгмийн хөгжлийг түргэсгэх гол хүчин зүйл болдог бол сөрөг үр дагавар нь оршихуйг устгах юм. Ёс суртахууны мэдлэг “эвдэн сүйтгэгч”, “хүчирхийлэл, дайсагнал”-ыг ч бий болгодог талаар дэлхийд түүхэнд гунигт цаг хугацаа ч бий.

Цагдаагийн албан хаагч нь сонсогч, оюутан байх үеэс хуульчийн ёс зүй, цагдаагийн ажилтны ёс хэмээх хичээлүүдийг үзэж, судлан өөрийн мэдлэгийг бүтээдэг. Харин /практикт/ ажил дээр гараад Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм гэх мэт эрх зүйн тогтоомжийг өөрийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Үүнээс гадна байгууллагын соёл буюу тухайн цагдаагийн байгууллагад тогтсон хэв маяг, соёлоос хамаарч алба хаагч суралцаж байдаг.

2. Бодол эргэцүүлэл, сэтгэхүй. (Thinking, Mentality)

Тунгаан бодох чадвар гэдэг нь тодорхой дарааллын дагуу асуудал дэвшүүлж сайтар эргэцүүлэн бодохыг хэлнэ. Мөн дүгнэлт, итгэл үнэмшилд хүрэхийн тулд үндэслэл болон логикийг бүтээлчээр ашиглахыг хэлж болно. Тунгаан бодох чадварт аливаа мэдээлэл болон итгэл үнэмшилд дүн шинжилгээ хийх, сонсож буй зүйлээ үнэн эсэхийг тогтоох чадвар багтана. Түүнчлэн ертөнцийн

¹³ <https://ru.unesco.org/themes/informacionnaya-etika> (хандалт: 2021.03.30)

олон янзын хэв маяг, өнгө төрх дундаас санаа бодлоо ургуулж түүнийгээ сургамж, туршлагатай холбон үзэх боломж олгодог. Үндэслэл сайтай шинэ онол боловсруулах, мөн бодитой, сайтар томьёологдсон нотолгоо гаргаж ирэхэд тунгаан бодох чадвар нь зайлшгүй шаардагдана.

Тунгаан бодох чадвар нь үндэслэл гаргаж, асуулт тавих чадварыг хөгжүүлдэг учраас хүний амьдралын бүхий л хүрээний мэдээлэл түүнд хамаардаг. Чухал шийдвэр гаргахын тулд шалтгааныг олох боломжийг хүнд олгодог учраас тунгаан бодох чадвар нь маш чухал билээ. Хүний амьдралын бүхий л хүрээний асуудалд түүний үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байдаг.

Тунгаан бодох үйл явцыг дотор нь:

1. *Шалтгаан ба дүгнэлт:* Энэ нь нотолгоог бүрдүүлэгч жижиг хэсгүүд юм. Нотолгоонд гарч буй дүгнэлт нь өгүүлэгчийн үнэн, бодит хэмээн дэвшүүлж буй мэдэгдэл, харин шалтгаан нь тэр мэдлэгийн дэмжих зорилгоор өгүүлэгчийн ашиглах санаа юм. Бүх нотолгоонд шалтгаан нь дүгнэлтээ үнэн гэдэгт бусдыг итгүүлэхэд чиглэсэн байдаг. Шалтгааны бие биетэйгээ болон дүгнэлттэйгээ хэрхэн холбогдож байгаа арга замыг нотолгооны бүтэц хэмээн ойлгодог.
2. *Дүн шинжилгээ:* Энэ нь ятган үнэмшүүлэх зорилготой шалтгаан болон дүгнэлт хоорондоо хэрхэн уялдаж байгааг шалгах үйл явц юм. Мөн дүн шинжилгээг нотолгооны бүтцийг тодорхойлох явц гэж хэлж болно. Холбоо үндэслэлийн хувьд шалтгаан нь тус тусдаа биш, бүгд нийлж дүгнэлтээ дэмждэг бөгөөд тэдгээр шалтгааныг салангид авч үзэж болдоггүй. Энэ үйл явц нь ихэвчлэн хэцүү, бэрхшээлтэй байдаг ч нотолгооны бүтэц янз бүр, нарийн төвөгтэй байхаас шалтгаалахаас гадна гаргасан үндэслэл тодорхой бус байх, эсвэл тэр үндэслэлээ гаргасан хүмүүс нь өөрсдөө ч сайн ойлгохгүй байх зэргээс шалтгаалдаг.
3. *Үнэлгээ:* Үнэлгээг дүн шинжилгээний дараа хийдэг ба үүнд дараах үйл ажиллагаа багтана. Үүнд:
 1. Шалтгааныг хүлээж авах боломжтой эсэхийг тодорхойлох;
 2. Шалтгаан нь дүгнэлтээ хэр сайн “дэмжиж” байгааг тодорхойлох;
 3. Гол дүгнэлт үнэн зөв эсэх талаар ерөнхий дүгнэлт гаргах.
4. *Тунгаан бодох бүдүүвч:* Нотолгоонд дүн шинжилгээ, үнэлгээ хийх нэг арга нь “Тунгаан бодох бүдүүвч” юм. Энэ нь суралцагчдаар илүү сайн үндэслэл гаргуулахад чиглэсэн асуултын удирдамж юм. Эдгээр нь янз бүрийн санал бодолд дүн шинжилгээ, үнэлгээ хийх, шалтгааныг хүлээж авах боломж болон эх сурвалжийн найдвартай байдлыг шүүн тунгаах гэсэн тус тусдаа зорилготой байдаг.

5. *Нотолгооны бүдүүвч*: нотолгоонд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах хоёр дахь арга нь “Нотолгооны бүдүүвч байгуулах” явдал юм. Нотолгооны бүтцийг дүрслэхдээ тунгаан бодох бүдүүвчид бичгэн тэмдэглэгээг ашигладаг бол нотолгооны бүдүүвчид график дүрслэлийг ашигладаг. Нотолгооны бүдүүвчийн өөр нэг ашигтай тал нь нотолгоо дахь янз бүрийн мэдэгдлийн аль нь гол дүгнэлтийг дэмжиж, эсвэл эсэргүүцэж байгаа тодорхой харуулах, мөн аль шалтгаан нь тус болох суурь ойлголт, эсвэл төсөөлөлтэй холбоотой вэ гэдгийг харуулдаг байна.

Цагдаагийн алба хаагч нь олж авсан ёс зүйн мэдлэгээ өөрийн болгон бодож, тунгаан боловсруулах үйл явц нь дээр дурдсанчлан сахилга, ёс зүйд нөлөөлж байдаг. Тунгаан бодох чадвараа хөгжүүлээгүй алба хаагч нь төрийн албаны үндсэн зарчим, цагдаагийн тангаргаа умартаж, бусад хүнийг залилан мэхлэх, ашиг хонжоо хайх, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчилд өртөх, мэргэжлийн алдаа дутагдал гаргах тохиолдол их байдаг.

Шүүмжит сэтгэлгээ /Critical thinking/: Аливаа зүйлийн сайн ба муугийн талаарх ойлголтыг танин мэдэх нь тухайн хувь хүн бие хүн болж буйн шинж. Болсон асуудлыг олон талаас нь нотлох баримтад тулгуурлан, олон ургач үзэл, шинжлэх ухаанчаар авч үзэх чадвар байдаг. Биеэ тоосон цагдаагийн алба хаагч нь ард түмнийг чирэгдүүлж, шалгаж буй гэмт хэрэг, зөрчлийн оролцогч нарын нэг талыг барих, дээрэнгүй харьцах зэрэг алдаа, дутагдал гаргах тохиолдол байна. Энэ нь өөрийгөө өмөөрөх буруу зуршил, шүүмжит сэтгэлгээтэй байж чадахгүй байгаагаас шалтгаалах тохиолдол бас байдаг билээ.

3. Хандлага (Attitudes)

Хандлага судлаач Карол Двик өөрийн амьдралын бүхий л хугацааг хандлага болоод гүйцэтгэлийн талаар судлахад зарцуулжээ. Тэрээр судалгаагаараа таны амжилтыг “IQ” биш хандлага тодорхойлдог гэдгийг баталсан байна. Тэрээр хүмүүсийн хандлага нь:

1. Тогтмол сэтгэлгээ (a fixed mindset);
2. Өсөлтийн сэтгэлгээ (a growth mindset)¹⁴ гэж хоёр хэсэгт хувааж болно хэмээсэн байна.

Тогтмол сэтгэлгээтэй хүн бол та өөрийгөө байгаа хүн гэдэгтээ итгэдэг тул та өөрчлөгдөж чадахгүй. Таны хийж чадахаас илүү юм шиг санагдах зүйл нь найдваргүй, цөхөрсөн мэдрэмж төрүүлэх нь мэдээжийн тул энэ нь таныг сорилтод ороход асуудал үүсгэдэг.

Өсөлтийн сэтгэлгээтэй хүмүүс өөрсдийгөө хүчин чармайлтаар сайжруулж чадна гэж итгэдэг. Тэд “IQ”-ийн түвшин доогуур байсан ч гэсэн тогтсон

¹⁴ Travis Bradberry, Why Attitude Is More Important Than IQ. Article. Talent smart. 2015. P.2.

сэтгэлгээтэй хүмүүсээс илүү сайн зүйл хийдэг, учир нь тэд бэрхшээлийг тэвчиж, шинэ зүйл сурах боломж гэж үздэг.

Орчин цагт олон төрлийн гадаад хэлтэй болох, гадаад улсад боловсрол эзэмших боломж бүрдэж хүн бүр л үр хүүхдээ харь оронд боловсрол эзэмшүүлэх хүсэл эрмэлзэлтэй болов. Чинхүү боловсрол эзэмшсэн зарим хүмүүс нь ёс зүйн мэдлэг дутмаг, ёс суртахууны ухамсаргүйгээс энэрэнгүй сэтгэл, хүн чанар, шударга ёсоо алдаж эд хөрөнгө, эрх мэдэл, мөнгөний төлөө юу ч хийхээс буцахгүй бологсод олшров.

Иймд цагдаагийн байгууллагаас алба хаагчдын хандлагыг өөрчлөх үүднээс богино, дунд хугацааны нөлөөллийн аяныг алба хаагч нартаа явуулж байна. Тухайлбал, “Өнгө нэмье” нөлөөллийн аяны хүрээнд “Хувь хүний төлөвшил” аян, “Нэг сэтгэл – нэг соёл” уриалга, алба хаагчдыг сахилга, ёс зүйн дутагдал гаргахгүй байхад анхаарч тэднийг аливаа хүний эрх, эрх чөлөөг зөрчих, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах болсон¹⁵.

4. Зан үйл (Behavior)

Зан үйл гэдэг нь хүний аж амьдралтай уялдан хэвшиж тогтсон заншил, түүнтэй холбоотой элдэв үйл хөдлөл¹⁶ гэж монгол хэлний их тайлбар тольд тайлбарласан байна.

Хүн төрөлхтөн үүсэж бий болсон цагаасаа байгалийн элдэв үзэгдлийг даван туулж, зохицон амьдрахын тулд аливаа зан үйлийг бий болгож түүндээ итгэсээр иржээ. Эртний хүмүүсийн үйлддэг зан үйл нь анх үг хэллэггүй, хөдөлгөөн төдий зүйл байсан бөгөөд хүний оюун ухаан, үйл хөдлөл хөгжин дэвжихийн хэрээр зан үйлийг дагалдах аман зохиол бий болсон байна. Аливаа зан үйлийн ёслол үйлдсэнээр байгалийн хүчийг тайтгаруулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх, өвчин эмгэг эдгээх, элдэв аюулыг зайлуулах, бусдад хор хүргэх зэрэг явдал биеллээ олох боломжтой, тийм чадал шингэсэн байдаг мэтээр ойлгож байв. Гэхдээ ард түмний ухамсар, танин мэдэхүй өсөж, шинжлэх ухааны мэдлэг дэлгэрэх болсноор өдөр тутмын амьдралд нь элдэв мухар сүсэг, шашин шүтлэгийн нөлөө суларч зан үйлийн аман зохиол нь үгийн шидэд итгэх хүмүүсийн гэнэн хандлага, сүсэг бишрэлийн илэрхийлэл байхаа бараг больж, харьцангуй уран сайхны зориулалттай түүх соёлын өв болж үлдэж байна¹⁷.

¹⁵ Өнгө нэмье аян. <https://police.gov.mn/p/3809>

¹⁶ Монгол хэлний их тайлбар толь. МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар. <https://mongoltoli.mn/>

¹⁷ Л.Навчаа. Зан үйл. Монгол утга соёл цуврал: IX боть.

Зан үйлийн нэг судлагдахуун нь зан суртахуун билээ. Гегель хүний ёс суртахуун, зан суртахуун хоёрыг зааглан тайлбарласан байдаг. Тэрээр үзэхдээ хүний тодорхой үйлдлийн субъектив талыг ёс суртахуун, объектив талыг зан суртахуун гэж тайлбар өгсөн түүхтэй улбаатай. Үүнтэй бид санал нэгдэж байна. Я.А.Коменский “Аливаа хүнд зан төлөвийн байдал нь ёс суртахууны үндэс мөн. Иймээс зан байдал, сэтгэл санааны талаар сайныг дуурайж биеэ авч явах нь чухал” гэж үзжээ.

Цагдаагийн байгууллагаас сэтгэл зүйчдийн ажлын байрыг нэмэгдүүлэн газар, хэлтэс бүрд ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна. Эдгээр алба хаагчид нь сэтгэл зүйн нарийн мэргэжлийн боловсролтой ба алба хаагчдын сэтгэл зүйд тулгарч буй асуудалд дүн шинжилгээ хийж, сэтгэл зүйн хямралтай алба хаагчдын зан үйлийг засах чиглэлээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран ажиллаж байна. Хувь хүний төлөвшил, ажил мэргэжлийн онцлог /хүнд гэмт хэрэгтэй тэмцэх/ зэргээс хамаарч алба хаагчид сэтгэл гутрал, ажлаас халшрах хам шинж илрэх тохиолдол байдаг.

Өөрөөр хэлбэл, алба хаагчдын сэтгэл зүйн сөрөг нөлөөнд өгч буй бие махбод, сэтгэл зүйн хариу урвалын түвшин өөрчлөгдөх тохиолдол гардаг. Сэтгэл түгшилт нь аливаа зүйлд яах бол гэж санаа зовних, айдас хүрмээр зүйлсээс шалтгаалан тайван биш болох, сандрах, хүйтэн хөлс гарах зэргээр илэрч, тэдгээр нь тухайн түгшүүрийг үүсгэж буй асуудлыг зохистой шийдвэрлэснээс дээрх шинжүүд арилж үгүй болдог. Гэхдээ зарим тохиолдолд эдгээр шинжүүд хэт хүчтэй илрэх, яльгүй зүйлд санаа зовних, түгших байдал нэлээдгүй илэрч гарах нь бий. Ингэснээр стрессийг даван туулах чадвар буурч, стрессээ бие даан өөрөө тайлах боломжгүй болох эрсдэл үүсдэг байна.

Мэдээж хүний зан үйлийг засна гэдэг нь урт хугацаанд явагдаж, маш их хүчин чармайлт шаардсан ажил. Тиймээс алба хаагчдыг буруу зан үйлд автуулахгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй.

5. Харилцаа (Relationships)

“Communication” буюу харилцаа нь Латин хэлний Communicare-аас “хуваалцах” гэсэн үгнээс гаралтай¹⁸. Харилцаа гэдэг нь нэг хүнээс нөгөө хүнд мэдээлэл, бодол санаа, мэдрэмжийг үгэн болон үгэн бус илэрхийллээр дамжуулж, түүнийг хүлээн авагч нь ямар нэгэн байдлаар хариу үйлдэл үзүүлэх хоёр талт үйл явцыг хэлнэ. Харилцаанд хоёроос доошгүй хүн оролцоно. Хүн өөрийн бодол, санаа, хандлага эсвэл мэдрэмжийг бусадтайгаа хуваалцаж байгаа тохиолдол бүр харилцааны төрөл юм.

¹⁸ Harper, Douglas. "communication". Online Etymology Dictionary. Retrieved 2021.

Харилцааны чадвар гэдэг нь бусад хүнийг ойлгох, өөрийгөө бусдад ойлгуулахад хэрэгтэй чадварыг хэлнэ. Үүнд үгэн буюу ярих, сонсох үндсэн чадвараас гадна үгэн бус харилцааны чадвар болох хүний нүүрний хувирал, дууны өнгө, гарын хөдөлгөөн, дохио зангаа, үйл хөдлөл гэх мэт хүний бүхий л мэдрэмж, хандлагыг илэрхийлдэг далд утгатай, хэлсэн үгний утгаас санааг гүнзгийрүүлдэг дохио багтаадаг. Үгэн ба үгэн бус харилцааг нэгэн зэрэг ашиглаж байгаа тохиолдолд үгэн бус харилцаа нь илүү үнэн бодитой байдаг.

Харилцааны чадвар эзэмших гэдэг нь өөрийн санаа, бодол, мэдрэмжээр өөртөө итгэлтэйгээр хэзээ, хэрхэн илэрхийлэхээ мэддэг, хэрэгжүүлж чаддаг болоход суралцахыг хэлнэ. Өнөөгийн нийгэмд харилцаа улам бүр өргөжсөөр байна. Тухайлбал, гар утас, интернэт, электрон шуудан гэх зэрэг цахим харилцаа хүрээгээ тэлсээр байна. Хүмүүс хамтдаа байгаа бүх тохиолдолд харилаа үүсгэдэг учраас харилцааны чадвар нь хүний амьдралын нэгээхэн хэсэг болно. Энэ нь тухайн хүний гэр бүлийнхэн, найз нөхөд, хамт ажиллагсадтайгаа тогтоосон харилцаа холбоонд шууд нөлөөлдөг.

Харилцааны чадвараа хөгжүүлж чадвал үл ойлголцол, ганцаардалд орохгүйгээр, сэтгэл хангалуун, аз жаргалтай амьдарна гэж үздэг билээ. Энэ чадварыг л эзэмшиж байж гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, ажлын хамт олонтойгоо нийцтэй амьдарна. Хүний сэтгэл санааны байдлаас хамаарч ажлын бүтээмж дээшилдэг.

(График №2 Харилцааны чадвар)



Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл: Харилцаа гэдэг нь юуны өмнө санаа бодлого, мэдлэг туршлага, соёлын солилцоо буюу хүмүүсийн хоорондын үйлдлийн тодорхой илрэл юм. Харилцааны соёл нь хүмүүс хоорондын дээр үеэс уламжлагдан ирсэн бие биетэйгээ ойлголцох үндсэн хэрэглэгдэхүүний боловсронгуй хэлбэр болдог ажээ.

Гавьяат хуульч Н.Гаравсүрэн “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл гэдэг нь алба хаагч нэг бүр бусадтай зөв боловсон, хүндэтгэлтэй харилцах чадвартай болсон байхыг хэлэх ба Монголчууд эртнээс эвгүй харилцаанаас ажил бүтдэггүй, залруулж үл болох алдаа ч гардаг гэж үзсээр иржээ. Энэ

талаар Монголын нууц товчоонд: «Тос шиг сэтгэлийг царцааж, сүү шиг санааг ээдүүлэв» гэж өгүүлсэн байдаг... «Хүний сэтгэлийн ямар ч эгзэг ээдрээтэй өнгө аясыг гаргахад монгол үг дутагдана гэж байхгүй бөгөөд босоо хүн суухаар морьтой хүн буухаар ярьж бичиж болно...» Цагдаагийн алба хаагч аядуу зөөлөн мэндчилж, «Та» гэж, хэн хүнд хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ албаны цөөн үгээр зарчмын дагуу ярьж байвал зохистой¹⁹.

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа нь эцсийн үр дүндээ ард иргэдтэй хэрхэн харилцаж, яаж үйлчилснээс хамаардаг. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагч нь харилцааны хувьд маш мэдрэмжтэй, гэмт хэрэгтэн болон хохирогчтой хуулийн хүрээнд харилцаж чаддаг байхыг шаарддаг ба мэргэжлийн ур чадварын салшгүй нэг хэсэг нь харилцааны соёл билээ.

С.Наранчимэг докторын гаргасан энэхүү гурвалжин дээр нэмэх нэг санаа бол **“Мэдээлэл”** юм. Мэдээлэл гэдэг нь Латин хэлний “Informātiō” аливаа зүйлийн талаар тодруулга, танилцуулга, тайлбар, ойлголт” гэсэн утгатай үг ба “informare” хэлбэр, заах, бодох, төсөөлөх гэсэн утгыг илэрхийлдэг байна²⁰.

Мэдээлэл нь өгөгдөл болон мэдлэгтэй холбогддог. Өгөгдөл нь параметрт ашиглагдсан үнэлэлтийг илэрхийлдэг бол мэдлэг нь бодит зүйл болон хийсвэр зүйлсийг илэрхийлдэг. Хамгийн чухал нь мэдээлэл бол системд учирч буй шалтгаан болон нөлөөллийн тархалт юм. Мэдээлэл нь бүх зүйлийн шууд болон шууд бус ажиглалтаар эсвэл мэдээллийн контент болж илэрдэг. Ингэж ойлгогдсон нь өөрийн зөвийн дагуу мэдээгээр байгуулагдаж болох ба эндээс хараад үзвэл мэдээлэл нь үргэлж мэдээний контент болж илэрдэг. Мэдээлэл нь дамжуулалт болон тайлбар зэрэг олон төрлийн хэлбэрт шифрлэгддэг (жишээлбэл, мэдээлэл нь тэмдгийн дараалалд шифрлэгдэж эсвэл дохионы дарааллаар дамжуулагддаг)²¹.

Эрдэмтэд “Мэдээлэл” гэдэг бол оюун ухаан, сэтгэлгээний хоол гэж үзсэн байдаг. Сэтгэлгээ эерэг эсвэл сөрөг байх эсэх нь тухайн хүмүүсийн эхийнхээ хэвлийд байхаас эхлээд өнөөг хүртэл авсан мэдээллийн чанараас хамаардаг. Өөрөөр хэлбэл эргэн тойронд чинь сөрөг мэдээлэл, сөрөг хандлагатай хүмүүс байх тусам сөрөг мэдээллээр алсуур идэх болно. Бид аав ээжээ, найз нөхөд, эргэн тойрны хүмүүсээсээ 50% сөрөг мэдээлэл авдаг ба дунджаар амьдралаас сонсож, мэдэж авч байгаа мэдээ, мэдээллийн 70% нь сөрөг байдаг байна. Харин бие махбодыг хоол тэжээдэг бол хүний оюун ухаан, сэтгэлгээг “мэдээлэл” тэжээдэг талаар эрдэмтэд авч үзсэн байна.

¹⁹ Н.Гаравсүрэн. Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн уламжлал шинэчлэл. <https://police.gov.mn/a/742>

²⁰ Когаловский М. Р. и др. Глоссарий по информационному обществу / Под общ. ред. Ю. Е. Хохлова. - М.: Институт развития информационного общества, 2009. - 160 с.

²¹ "Information - Definition of Information by Merriam-Webster". Merriam-webster.com. Retrieved 1 May 2017.

Улмаар ёс зүйн шинжлэх ухааны нэг зорилго нь аливаа мэргэжлийг соёл тус бүрийн параметр эсвэл нийгмийн хэм хэмжээний дагуу сайн сайхны замд хөтлөх явдал юм. Ёс суртахууны тэгш байдал гэдэг нь бусадтай болон өөртэйгөө зэрэгцэн оршихуйг хөнгөвчлөх ухамсартай, уялдаа холбоотой амьдрах, үйлдэх арга хэлбэрийг хэлнэ. Мэргэжлийн ёс зүй бол мэргэжил тус бүрийн зорилго, зарчмуудын тусгал юм.

Цагдаагийн байгууллага дахь ёс суртахууны тэгш байдал нь бусдыг хүндэлдэг байдал, харилцаа, хандлага, хариуцлагатай, үнэнч байх, цаг баримталдаг байдал гэх мэт хэд хэдэн үнэт зүйл буюу үүргээ биелүүлэхийг хэлдэг. Эдгээр элементүүд нь бүх нийтийн үнэт зүйл боловч мэргэжил тус бүрд тодорхой үүрэг шаардагдаж магадгүй юм.

III. ЦАГДААГИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ:

Харин цагдаагийн байгууллага нь эрхэм зорилгоо *“Найдвартай баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг”* хэмээн тодорхойлсон. Хамгийн сүүлд авсан цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг Нээлттэй нийгэм форумоос 2012 -2017 онд хийсэн байдаг. 2017 онд Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар Дотоод хэргийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуулийн судлаачдын баг *“Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ”²²* судалгааг хийсэн. Өөрөөр хэлбэл, энэ судалгаа нь ард иргэдээс цагдаагийн байгууллагад өгч буй үнэлгээ юм.

Иргэдийн сэтгэл ханамж:

Уг судалгаагаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг 5 бүлэгт багтах 32 асуултаар үнэлсэн бөгөөд нийт 5.0 үнэлгээ авахаас 3.25 авсан нь дундаж үзүүлэлт юм. Нийтдээ 8 аймаг, 6 дүүрэг улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 13 аймаг дунджаас доогуур үнэлгээ авчээ. Тухайлбал, Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн өндөр үнэлгээг Сүхбаатар дүүрэг, орон нутгаас Хэнтий аймаг авсан бол Баянзүрх дүүрэг, Булган аймаг хамгийн бага үнэлгээг авчээ. Улсын хэмжээнд сайнаас (4.0) дээш үнэлгээ авсан цагдаагийн газар, нэгж байхгүй байгаа нь төдийлөн сайн үзүүлэлт биш юм.

1. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ: Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг иргэд дунд зэрэг (3.4) гэж үнэлжээ. Иргэдийн зүгээс цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журам сахиулах, олон

²² “Цагдаагийн байгууллага хэрэглэгчийн үнэлгээ 2017” ННФ,УБ,2018 https://www.forum.mn/index.php?sel=project&menu_id=554&obj_id=5478 (хандалт: 2020.01.10)

нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ сайн биелүүлдэг (3.4-3.8) гэж үзсэн бол, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд дунджаас доогуур үнэлгээ өгчээ. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, баривчлах ажилд төдийлөн сэтгэл ханамжгүй (2.99-3.1) байна.

2. Хууль ёсны зарчмын хэрэгжилт: Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим бөгөөд иргэд уг зарчмын хэрэгжилтийг дунд зэрэг (3.11) гэж үнэлжээ. Тодруулбал, гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд түргэн шуурхай тусламж үзүүлдэг боловч асуудлыг хуулийн дагуу шуурхай шийддэггүй, мөн авилгаас ангид, шударга ажиллаж чаддаггүй, хүний эрхийн талаарх мэдлэг хангалтгүй гэжээ.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, эргэлзээгүй байдалд иргэд сэтгэл ханамжгүй (2.99) байдаг нь анхаарал татсан байна.

Мөн цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журмыг сахиулах үүргээ гүйцэтгэх явцдаа 180 мянга гаруй өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгаж байна. Үүний 460 гаруй нь цагдаагийн алба хаагч үүргээ гүйцэтгэхдээ хууль зөрчсөн талаарх иргэдийн гомдол байгааг авч шалгасан. Эдгээрээс харахад 245 нь буюу 57.5 хувьд нь хууль зөрчсөн нь тогтоогдоогүй, 23 хувьд нь ямар нэгэн байдлаар хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдож, сахилгын арга хэмжээ авсан²³ байна. Албан үүргээ гүйцэтгэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангаж, хуулийн хүрээнд ажиллах нь цагдаагийн алба хаагчийн үүрэг билээ.

Үүнээс харахад цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйг сайжруулж, харилцаа, хандлагыг эерэгжүүлэх нь байгууллагын, албаны нэр хүндэд шууд нөлөөлж, ард иргэдийн төрд итгэх итгэл нэмэгддэг билээ.

Иймээс алба хаагчдын гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчил гаргахад нөлөөлдөг суурь хүчин зүйл нь авч үзэх нь чухал билээ. Тэдгээр хүчин зүйл нь хувь хүний төлөвшил, харилцаа, хандлагын түвшин, ажлын ачаалал, нийгмийн баталгаа, цалин, хөлс, ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинж байдаг. Эдгээр суурь шалтгаанаас цагдаагийн алба хаагчийн төрөл мэргэшлийн онцлогоос шалтгаалах ажлын байран дахь стресс, мөн стресс нь удаан үргэлжилснээс үүдэн “Ажлаас халшрах хам шинжээр илэрч байдаг.

Сүүлийн үед нийгэм асуудал болоод байгаа стресс нь гэр бүлийн орчин, гадаад орчинд ч оршсоор байгаа бөгөөд түүний эерэг, сөрөг нөлөө нь хүн

²³ Цагдаагийн алба хаагчтай холбоотой гомдол, мэдээлэл. (2020 оны байдлаар) <https://ikon.mn/n/1viv>

бүрийн хувийн амьдрал болон ажил, тэр дундаа ажлын бүтээмжид хамгийн их нөлөөлж, цаашлаад ажил эрхэлж буй хүмүүсийн ажлаасаа авах сэтгэл ханамжийг бууруулдаг гэдгийг сэтгэл судлаачид тэмдэглэж байгаа юм. Ажлын байран дахь стресс нь удаан үргэлжлэн ядаргаа болон ажилдаа дур сонирхол нь буурч “Ажлаас халшрах хам шинж” үүсгэж байна.

Ажлаас халшрах шинжийн түвшин нь бие бялдрын, сэтгэлийн хөдөлгөөний, бүтээмжийн бууралт гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Уг судалгаанаас гарсан оноо нь алба хаагчийн мэргэжлийн хам шинжид орсон эсэхийг мэдэх, чиглүүлэх зорилготой. Үүнийг өөрийнхөө амьдралыг хянах шалгуур гэж ойлгож болно. Хэрэв оноо өндөр байвал гэр бүл, сэтгэл судлаач, сэтгэл зүйчээс зөвлөгөө авах замаар хэд хэдэн алхмуудыг хийж болно. Эхний алхам нь өөрт чинь ямар нэгэн асуудал байгаа эсэхийг л мэдэх, юунд анхаарах гэдэг чухал юм.

Үүнээс дүгнэн хэлэхэд цагдаагийн байгууллагад алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх ёс зүйтэй, сахилга батыг сахих ажлын хүрээд “Цагдаагийн алба хаагчдын сэтгэл зүйн нэгдсэн бодлого, хөтөлбөр” хийх хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ингэснээр ард иргэдийн хувьд цагдаагийн байгууллагын үнэлэмжийг бууруулахгүй байж, хүний эрх, эрх чөлөөг ханган ажиллахад онцгой ач холбогдолтой билээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

IV. ДҮГНЭЛТ

Дээрх өгүүлснийг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Мэргэжлийн ёс зүй бол мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны зарчим, хэм хэмжээний тогтолцоог судалдаг ёс зүйн нэг салбар тул цагдаагийн байгууллага алба хаагчдын сахилга, ёс зүйг сайжруулах чиглэлээр тогтмол алба хаагчдыг сургаж, мэдлэгжүүлэх;
2. Алба хаагчдын гаргасан ёс зүйн болон сахилгын алдаа дутагдлыг өөрөөр нь ухамсарлуулж, дахин тийм төрлийн зөрчил гаргуулахгүй байхад анхаарч, сэтгэл зүйчдийг нэмэгдүүлэн ажиллах;
3. Мэргэжлийн ёс зүйн пирамид нь мэдлэг, бодол эргэцүүлэл, хандлага, зан үйл, харилцаагаар дамжиж илэрдэг. Бид эдгээр суурь ойлголтууд дээр нэмж “мэдээлэл” гэх ойлголтыг нэмж авч үзсэн. Техник, технологийн хурдацтай хөгжлийн энэ үед мэдээллийн ач тус бүхнээс чухал билээ. Үнэн зөв, мэдээллийг авч түүнийгээ боловсруулж, шинжлэх ухаанчаар түүнд хандаж, үйлдэл болгон үр дүнд хүрнэ.

V. САНАЛ

1. Цагдаагийн байгууллагад алба хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчлийг бууруулахын тулд алба хаагчдын ёс суртахуун, харилцаа, хандлагыг нэмэгдүүлж, байгууллагын соёлыг дэлгэрүүлэх;
2. Мэргэжлийн ёс зүйн бүрэлдэх хэсэгт “Мэдээлэл” хэмээх ойлголтыг нэмснээр бид мэдээллийн жигд бус байдлаас болж хөгжлийн түвшин ялгагддаг тул дээрх гурвалжин дээр нэмж оруулах;
3. Цагдаагийн байгууллага мэргэжлийн ёс зүйн сургалтыг өөрсдийн гаргасан ёс зүйн болон сахилгын алдаа дутагдлыг өөрөөр нь ухамсарлуулж, дахин тийм төрлийн зөрчил гаргуулахгүй байх чиглэлээр сургалтын модуль гаргах;
4. Цагдаагийн байгууллагын хэмжээнд нөлөөллийн аянаар дамжуулж ёс суртахууны боловсролыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйчдийг нэмэгдүүлэн ажиллах.

VI. НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

1. Ц.Гомбосүрэн. Ёс зүй. УБ, 2008
2. С.Нарантуяа. Хүн хэдийн ухаантай ч. УБ, 2010
3. Л.Навчаа. Зан үйл. Монгол утга соёл цуврал: IX боть.
4. Д.Тунгалаг. Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. УБ, 2014
5. Д.Тунгалаг “Ёс зүйн зангилаа асуудлууд”, УБ, 2015.
6. Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл. Мэргэжлийн ёс суртахууны боловсролын ач холбогдол-Монгол дахь ёс суртахууны боловсролын тулгамдсан асуудал. УБ, 2015
7. Р.Дарьхүү. Ёс зүйн асуудлууд. УБ, 2016

Гадаад эх сурвалж:

1. Прохоров А.М. (гл.ред.) Большой энциклопедический словарь. М.1993
2. Girard, John P.; Girard, JoAnn L. "Defining knowledge management: Toward an applied compendium" (PDF). Online Journal of Applied Knowledge Management. 2015
3. Travis Bradberry, Why Attitude Is More Important Than IQ. Article. Talent smart. 2015
4. Bloom, Benjamin S. Taxonomy of Educational Objectives. 1956
5. Harper, Douglas. "communication". Online Etymology Dictionary. Retrieved 2021.
6. Зубов В. П. Аристотель: Человек. Наука. Судьба наследия. («Научно-биографическая серия»). - М.: Изд-во АН. 1963
7. Бентам Иеремия // Бари - Браслет. - М. : Советская энциклопедия, 1970.
8. Зенон из Кития / А. А. Столяров // Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. - 2-е изд., испр. и доп. - М. : Мысль, 2010
9. Локк /А. Л. Субботин// Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. 2-е изд., испр. и доп. - М. : Мысль, 2010.
10. Букер И. Свобода и фантазии Жан-Жака Руссо. // Правда.ру, 28.06.2012.
11. Dr. Large. "Nietzsche and Moral Nihilism". www.arasite.org. Retrieved 2019.
12. James Svava "The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations" Jones and Bartlett Learning LLC, 2015,

13. Когаловский М. Р. и др. Глоссарий по информационному обществу / Под общ. ред. Ю. Е. Хохлова. - М.: Институт развития информационного общества, 2009
14. "Information - Definition of Information by Merriam-Webster". Merriam-webster.com. Retrieved 1 May 2017.

Бусад эх сурвалж:

1. <https://ru.unesco.org>
3. <https://www.uky.edu>
4. <https://ikon.mn/n/1viv>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



З.ЖАРГАЛМАА

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын
Хуулийн хэлтсийн тэргүүлэх хуульч, докторант

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ЗОХИЦУУЛАЛТ, УЛАМЖЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF LAWS AND CONVENTIONS ON WOMEN'S LABOUR RIGHTS IN MONGOLIA

Хурангуй: Ардын төр үүсэн байгуулагдсанаас хойшхи 100 жилийн хугацаанд Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг хангах олон талын арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын эмэгтэйчүүд нийгмийн бүх салбарт эрх тэгш байх, чөлөөтэй хөдөлмөрлөх эрхтэй болж энэ нь төрийн хуульд баталгаажин хэрэгжих болов. Үүнийг 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хууль, 1921 оны 3 дугаар сарын 18-наас хойш үйлчилж ирсэн 1925, 1930, 1933, 1934, 1941, 1973, 1991, 1999, 2021 оны хөдөлмөрийн хууль тогтоомж, бусад актаар тодорхойлж болно.

Abstract: As a result of the multilateral measures that have been taken to ensure the rights of Mongolian women to work in the 100 years since the People's Revolution. Mongolian women have had the equalities and labor rights in all spheres of society, which are guaranteed by state law. It could be determined by Constitution of 1924, 1940, 1960, 1992, the labor laws of 1925, 1930, 1933,

1934, 1941, 1973, 1991, 1999 and 2021, as well as other acts that came into force after March 18, 1921.

Түлхүүр үгс: Монгол эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх, эмэгтэйчүүдийн хөдөлмөр, жирэмсэн, амаржсан эхийн хөдөлмөр зохицуулалт, хүүхэд хөхүүлэх завсарлага

Keywords: Mongolian women's labour rights, women's labour, labour regulation of pregnant and women who gave birth recently, breast feeding breaks

I. ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улс түүхэндээ хүний эрх, эрх чөлөө, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрх, хөдөлмөрлөх эрхийг нийгмийн хөгжлийн онцлогтой уялдуулан үе үеийн Үндсэн хуулиар баталгаажуулсан. Тухайлбал: 1924 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд “Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”¹ хэмээн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг анх удаа тунхагласан бол 1940 оны Үндсэн хуулийн 73 дугаар зүйлд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нэгэн адил сонгох, сонгогдох бүрэн эрхтэй болохыг баталгаажуулжээ. Мөн 1940 оны Үндсэн хуульд ажлын найман цагийн үргэлжлэлийг тогтоож, ээлжийн амралт эдлэх, амарч сувилуулах, нийгмийн тусламж дэмжлэг авах эрхийг анх удаа хуульчилсан. Улмаар 1960 оны Үндсэн хуульд ажилтны цалин хөлс хөдөлмөрийн хэмжээ, чанар, гүйцэтгэсэн ажилд тохирох ёстой гэсэн зарчмыг шинээр тусгажээ. 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” хэмээн тунхагласан. Мөн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт хөдөлмөрлөх эрхийн талаар “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан бөгөөд “хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт үүрэг” хэмээн хуульчлав.

1925 оны 2 дугаар сарын 14-ний өдөр “Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм”-ийг Ардын Засгийн газрын тогтоолоор баталсан нь хөдөлмөрийн харилцааны асуудлаар төрөөс тогтоосон анхны хэм хэмжээ байсан юм. Улмаар 1930 оны БНМАУ-ын хүчнээн үнэлэгчдийн хууль, 1933, 1934 оны Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1941, 1973, 1991 оны Хөдөлмөрийн хууль, 1999 оны Хөдөлмөрийн

¹ С.Батаа, Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). УБ, 5 дахь тал

тухай хууль тухайн цаг үеийнхээ хөдөлмөрийн харилцааг зохицуулах түүхэн үүргийг гүйцэтгэсэн. Монгол Улсын 1925-1999 оны хөдөлмөрийн хуулиудыг хууль зүйн шинжлэх ухааны доктор Л.Баасан, хууль зүйн доктор С.Болормаа нар 2003 онд эмхэтгэн гаргасан нь судлаач, хуульч, сонирхсон хэн бүхэнд харьцуулсан судалгаа хийхэд дөхөмтэй болсон. Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүтэц, харьцуулсан дүгнэлтийг Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Л.Баасан “Хөдөлмөрийн эрх зүй” сурах бичгийн наймдугаар бүлэгт тусгажээ.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хуульд өнөөгийн нийгэмд шинээр бий болсон харилцааг зохицуулах, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, нийгмийн түншлэлийг хангах суурь зарчмыг тусгаснаараа шинэлэг болсон. Мөн энэхүү хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт ажил олгогч нь ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах зэрэг ажилтны хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх тухай заалт нь хөдөлмөр эрхлэлтийн харилцаа эх, хүүхэд, гэр бүлд ээлтэй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Гэсэн хэдий ч жирэмсэн эмэгтэйчүүдийн ажлын байрны баталгаа, бага насны хүүхэдтэй эхийн шөнийн, илүү цагаар, томилолтоор ажиллах асуудал, насанд хүрээгүй хүний хөдөлмөрлөх насны доод хязгаар зэрэг өмнөх хөдөлмөрийн хууль тогтоомжоос дордуулсан нөхцөл, амьдралд гарч байгаа зарим зөрчил нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн баталгааны асуудлыг цаашид нарийвчлан судлах шаардлагыг бий болгож байна.

Монгол Улс хөдөлмөрийн харилцааг зохицуулсан нэгдмэл актуудыг 1925 онд Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм, 1930 онд БНМАУ-ын хүчнээн үнэлэгчдийн хууль, 1933 онд Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1934 онд Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1941 онд БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль, 1973 онд БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль, 1991 онд Хөдөлмөрийн хууль, 1999 онд Хөдөлмөрийн тухай хууль нэртэйгээр баталж, хэрэгжүүлж ирсэн. 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын чуулганаар баталж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж байна.

Харин 1921 оны 3 дугаар сараас 1925 оны 2 дугаар сарын 14 хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцааг зохицуулсан нэгдмэл акт Монголд байсангүй. Энэ үед шинээр байгуулагдсан төрийн яамд, улсын болон бусад албан газар,

байгууллагад ажиллагчдын хөдөлмөрийн үйл ажиллагааг Ардын Засгийн газраас батлан гаргасан тогтоол, жич дүрмүүдээр зохицуулж байв. Жишээ нь: Ажилчин, албан хаагчдын цалин хэрэглэлийн тухай дүрэм (Ардын Түр Засгийн Газрын 1921 оны 4 дүгээр сарын 23, 1921 оны 5 дугаар сарын 13-ны тогтоол), ажлын цагийг тогтоох тухай (Ардын Түр Засгийн Газрын 1921 оны 5 дугаар сарын 20-ны тогтоол) болон бусад асуудлаар тусгайлан тогтоол гарч байжээ. 1921 оны 5 дугаар сарын 20-нд гаргасан Ардын Түр Засгийн Газрын тогтоолд “Засгийн олон яам, албан газруудын алба хийх цагийг ба бие амрах өдрийг тогтоохыг хэлэлцээд ням гаригт алба хийхгүй, бие амрах ба бусад өдрүүдэд өглөөний есөн цагаас эхлэн дөрвөн цаг хүртэл алба хийх явдлыг зохих газруудад мэдэгдэхээр” шийдвэрлэсэн байна. Энэ нь Монгол Улсад ажил, амралтын цагийг зохицуулсан анхны акт байсан ба энэ үед тогтоосон ням гаргийн амралт өнөөг хүртэл үйлчилж иржээ. 1921-1925 оны үед хөдөлмөрийн харилцааны асуудлыг “Засгийн газрын төлөөлөгчийн дүрэм”, “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”, “Ардын засгийн уул уурхайн дүрэм” 1922 он, “Хоршоо байгуулах тухай бичиг” 1921 он гэх мэтийн тусгайлан гарсан дүрмүүдээр зохицуулж байв².

Эдгээр тогтоол, тусгайлсан дүрмүүд тус тусын чиглэлд үйлчлэх нэгдмэл актыг аяндаа шаардах болов. 1925 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Ардын Засгийн тогтоолоор баталсан “Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм” буюу Монгол Улсад хөдөлмөрийн үйл ажиллагааг нэгдмэлээр зохицуулагч анхны актаар энэ шаардлагыг хангажээ. Аливаа хүчин үнэлэгчдийн дүрмийн нэгдүгээр зүйлд “Аливаа олон яамны газар, жич хот, суурин газрын албан, амины хоршоо, олны ба энгийн худалдаа, үйлдвэрийн газрууд дагаж явахаас гадна мөн хөдөөгийн тариалангийн пүүс нэгэн адил журамлан дагаваас зохино” гэжээ. Энэ дүрмийг ажилтнуудын хөдөлмөрийн үйл ажиллагааг нэгдмэлээр зохицуулах Монгол Улсын хөдөлмөрийн анхны хууль гэж үзэж болох бөгөөд энэ нь ажилтнуудыг хөдөлмөрлүүлэх нэгдмэл журам тогтоож, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл бий болгосноор тайлбарлагдана³.

II. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН АСУУДАЛ

Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэмд “Аливаа хүчин үнэлэгчдэд өвчний зэрэг зовлон тохиолдоход арчлан хамгаалахын учир тусламжийн тухай” асуудлыг тусгаж хэрэгжүүлж байсан ба ажилчин албан хаагч өвдөх, хөдөлмөрийн чадвараа түр алдвал нэг сар хүртэл, жирэмсэн болох, хүүхэд төрүүлэхэд гурван сарын хугацаанд цалинг олгож байхаар тусгажээ. Энэ нь Монгол Улсад эмэгтэйчүүдэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж, чөлөөг олгохоор

² Л.Баасан, Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүй. 2010, УБ, 116 дахь тал

³ Л.Баасан, С.Болормаа, Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиуд.УБ, 2003, 3 дахь тал

төрөөс тогтоосон анхны хэм хэмжээ байсан юм. Монгол Улсын дараа дараачийн нэгдмэл акт буюу хөдөлмөрийн хуульд энэ нь улам өргөсөн хуульчлагдсан байна. Түүнчлэн 16 зүйл бүхий “Хүчин үнэлэгчдийн дүрмийг тайлбарлан гаргасан заавар”-ыг Монгол Ард Улсын Дотоод Явдлын Яамнаас тухайн оны 2 дугаар сарын 14-ний өдөр гаргаж, зарим заалтуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй тайлбарласан байна.

1930 онд баталсан БНМАУ-ын хүчнээн үнэлэгчдийн хуулийн 18 дугаар зүйлийн долдугаар хэсэгт жирэмсэн ажилтан түүнд олгосон төрөхийн өмнө болон дараах гурван сарын чөлөөнөөс хойш хоёр сар өнгөрвөл хөдөлмөрийн гэрээг цуцалж болох тухай заажээ. Харин 86 дугаар зүйлд “Аливаа бичгийн албан хаах жирэмсэн бүсгүйчүүдэд төрүүлэхийн урд хожид тус тус хоёр сарын чөлөө олгохоос гадна цалин хөлсийг хувиар олговоос зохино”⁴ гэж заасан нь оюуны хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдэд нэг сарын цалинтай чөлөө илүү олгож байсныг харуулж байна.

Мөн хуулийн 36 дугаар зүйлд “Хүүхдээ хөхүүлэн тэжээж буй эмэгтэйчүүдэд хүүхдээ тэжээхийн тулд дээр заасан амралтын цагаас гадна тусгай түр чөлөө олговол зохино. Тайлбарлах нь, энэхүү зүйлд заасан түр чөлөөний хэмжээг зохих ажил үйлдвэрийн газруудын эрх баригчдаас харьяат үйлдвэрчний эвлэл ба уул эмэгтэйчүүдийн харилцан хэлэлцэж тогтоохууд тэрхүү чөлөөг гурван цаг хагас тутамд нэг удаа 30 минутаас доош бусаар олгож байхаас гадна түүний жинхэнэ албан ажил гүйцэтгэх цагт оролцуулан тооцвоос зохино” гэжээ. Түүнчлэн уг хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу үдийн завсарлагын цаг нь ажлын дөрвөн цагийн дараа 30 минутаас хоёр цаг хүртэл байх зохицуулалттай байсан бөгөөд үүнээс гадна хүүхдээ хөхүүлэхэд нь зориулж гурван цаг хагас тутамд 30 минутаас багагүй чөлөөг нэмж олгож цалин хөлсийг ажилласнаар тооцон олгох зохицуулалтыг анх удаа хуульчилжээ. Түүнчлэн жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг тогтоосон ажлын цагаас илүү ажиллуулахыг хориглосон байна.

1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуулиар ажлын цагийн үргэлжлэлийг найман цаг байхаар тогтоосон бөгөөд оюун ухааны ажил, бичиг дансны ажил эрхэлдэг хүмүүс, 16 насанд хүрээгүй хүмүүс өдөрт зургаан цаг ажиллахаар тусгажээ.

Хүүхэд хөхүүлэх завсарлагын талаар 1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуулийн 16 дугаар зүйлд “Нялхсыг хөхөө хөхүүлэн тэжээж буй эмэгтэйчүүдэд нярайлсан өдрөөс хойш есөн сарын дотор уул нялхсыг тэжээхийн тулд өдөр тутамд хагас цагийн хэмжээний завсралтыг нэг удаа олгож байваас зохих бөгөөд энэ завсралтыг ажил хийсэнд тооцож ажлын цагт оруулмой”⁵ гэжээ.

⁴ Л.Баасан, С.Болормаа, Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиуд. УБ, 2003, 28 дахь тал

⁵ Л.Баасан, С.Болормаа, Монгол Улсын хөдөлмөрийн хуулиуд. УБ, 2003, 28 дахь тал

Өмнөх хуулийн дагуу гурван цаг хагас тутам ажиллахад 30 минутаас багагүй завсарлагыг хүүхдээ хөхүүлэхэд нь зориулж олгох зохицуулалт нь ажлын нэг өдөрт нийлбэр нь нэг цагаас багагүй байсан бол 1933 оны хуулиар өдөрт 30 минутаас багагүй буюу нэг цагаас 30 минут болж багасчээ. Мөн өмнө нь үйлчилж байсан 1930 оны хуульд хүүхдээ хөхүүлэх завсарлага олгоход хүүхдийн насыг заагаагүй байсан бол энэхүү хуулиар хөхүүл эх хүүхдээ есөн сар хүртэл нь хүүхэд хөхүүлэх цалинтай завсарлага авах боломжийг олгожээ. 1930 оны БНМАУ-ын хүчнээн үнэлэгчдийн хуулиар Мартын 8-ны өдрийг нийтээр амрах баярын өдөрт тооцож байсан бол 1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуульд заасан баяр ёслолын өдрүүдээс Мартын 8 хасагдсан байна. Түүнчлэн жирэмсэн болон амаржсан эхчүүдэд олгох цалинтай чөлөөг зургаан цагийн ажлын өдөртэй бол амаржихын өмнө, хойно тус бүр нэг сар буюу нийт хоёр сар, найман цагийн ажлын өдөртэй бол амаржихын өмнө хойно нийтдээ нэг сар хагас байхаар тус тус ялгавартай тогтоосноос гадна 1930 оны хуульд зааснаас зургаан цагийн ажлын өдөртэй ажилтны цалинтай чөлөө амаржихын өмнө хойно тус бүр нэг сараар, нийлбэр дүнгээрээ хоёр сараар багасчээ. 1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуулийн дагуу ажилтны ээлжийн амралтыг 15 хоног байхаар анх удаа хуульчилсан бөгөөд харин 16 насанд хүрээгүй ажилтанд нэг сарын амралт олгох тухай заажээ.

1934 оны Хүчин үнэлэхүйн тухай хууль 10 бүлэг 70 зүйлтэй. Уг хуулийн тавдугаар зүйлд 12 насанд хүрээгүй хүрээгүй багачуудыг хөлсөн зарах явдлыг цаазална гэжээ. Эндээс хөдөлмөрийн насны доод хязгаарыг өмнөх 1933 оны хуультай ижил 12 насаар тогтоосныг харж болно. Мөн 16 насанд хүрээгүй этгээдийн ажлын цагийн үргэлжлэл зургаан цаг байх, тэднийг шөнийн цагаар ажиллуулахыг хориглох тухай заалтууд нь өмнөх 1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуультай ижил байна. Харин 16 насанд хүрээгүй хүмүүсийг хоногт гурван цагаас илүүгүй хугацаагаар илүү цагаар ажиллуулах, өөртэй нь тохиролцсон тохиолдолд гурван цагаас дээш илүү цагаар ажиллуулж болох тухай заалтыг шинээр оруулсан байна.

Энэхүү хуулийн 27 дугаар зүйлд хүүхдээ хөхүүлэх цалинтай завсарлагыг өдөрт нэг удаа 30 минутаар, нярайлсан өдрөөс хойш зургаан сарын дотор олгохоор заасан нь 1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуульд заасан хугацаанаас даруй гурван сараар багассан байна. Мөн жирэмсэн болон амаржсан эхчүүдэд олгох цалинтай чөлөөг зургаан цагийн ажлын өдөртэй бол амаржихын өмнө, хойно тус бүр нэг сар, найман цагийн ажлын өдөртэй бол амаржихын өмнө хойно нэг сар хагас байх тухай 1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуулийн заалт хэвээр хадгалагджээ.

1941 оны БНМАУ-ын Хөдөлмөрийн хуульд заасны дагуу Ардын Сайд нарын зөвлөлийн 1942 оны 5 сарын 5-ны өдрийн 17 дугаар хурлаас тогтоол гаргаж,

эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг ажиллуулахыг хориглосон 17 нэр төрлийн албан тушаалын жагсаалтыг анх баталж мөрдүүлжээ.

Энэхүү хуулийн 81 дүгээр зүйлд жирэмсэн гэх шалтгаанаар жирэмсэн ажилтны цалинг нь хорогдуулахыг хориглосон. Мөн хуулийн 45 дугаар зүйлд эмэгтэйчүүдийг зөвхөн жирэмсний эхний зургаан сард, харин хүүхдээ хөхүүлж байгаа эмэгтэйчүүдийг зургаан сар өнгөрсний дараа илүү цагаар буюу шөнийн цагаар ажиллуулж болох тухай заасан байна. Түүнчлэн 93 дугаар зүйлд долоон сараас доошгүй хугацаагаар ажилласан жирэмсэн эмэгтэйчүүдэд төрөхийн өмнө нэг сар хагас ба төрсний дараа нэг сар хагас 45 хоногийн цалинтай чөлөө (амралт) олгох тухай хуульчилжээ. Харин долоон сар хүрэхгүй ажилласан эмэгтэйчүүдийг дээрх хугацаанд ажлаас чөлөөлөх боловч цалин олгохгүй гэж дурдсан байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийг эмчийн дүгнэлтээр хөнгөн ажилд шилжүүлсэн тохиолдолд сүүлийн зургаан сарын дунджаар цалинг тооцож олгохоор тусгажээ. Энэхүү хуулиар ажилтнуудын үдийн хооллож, амрах завсарлагын үргэлжлэх хугацаа нь хагас цаг буюу 30 минут байсан бөгөөд хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хүүхдээ хөхүүлэхэд нь зориулж төрснөөс хойш долоон сарын хугацаанд хооллох завсарлагааны цаг дээр хагас цагаас доошгүй завсарлагыг нэмж олгох, үүнийг ажилласан цагт оролцуулан тооцож байхаар тусгасан нь өмнөх 1934 оны Хүчин үнэлэхүйн тухай хуульд зааснаас нэг сараар нэмэгджээ. 1941 оны Хөдөлмөрийн хуулийн арван хоёрдугаар бүлэгт гал түймэр, ус үер, цас шуурга гэх зэрэг онцын аюул тохиолдох, байлдааны үед улс орныг батлан хамгаалах, улсын чухал даалгавруудыг биелүүлэхэд ажилчин хүрэлцэхгүй тохиолдолд бүх иргэдийг Сайд нарын Зөвлөлийн тусгай тогтоолоор хөдөлмөрийн буюу тээврийн албанд татах (дайчлах) тухай тусгасан. Ийнхүү хөдөлмөрийн дайчилгаанаас 18 насанд хүрээгүй хүмүүс, 45-аас дээш насны эмэгтэйчүүд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, долоогоос доош насны хүүхэдтэй бөгөөд асран хамгаалах өөр хүнгүй эмэгтэйчүүдийг чөлөөлж байсан байна.

1973 оны 7 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан БНМАУ-ын Хөдөлмөрийн хуульд иргэдийг ажилд авахдаа аливаа ялгаварлал, давуу байдлыг бий болгохыг хориглосон заалт анх удаа оруулснаараа онцлогтой. Тодруулбал, хуулийн 12 дугаар зүйлд “Иргэдийг ажилд авахаас үндэсгүйгээр татгалзахыг хориглоно. БНМАУ-ын Үндсэн хуульд зааснаар иргэдийг ажилд авахад эрэгтэй, эмэгтэй, арьс, үндэс, шашин шүтлэгийн байдлаар ялгаварлах зэргээр шууд буюу шууд бусаар аливаа хязгаар, давуу тал тогтоохыг хориглоно” гэж заажээ. Мөн 78 дугаар зүйлд анх удаа адил хөдөлмөрт адил цалин хөлс олгох зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор эрэгтэй, эмэгтэй, нас, яс, үндэс, арьс өнгөөр ялгаварлахгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний цалин хөлс олгох тухай заасан нь олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцсэн байна.

Түүнчлэн уг хуулийн 149 дүгээр зүйлд эмэгтэйчүүдийг жирэмсэн буюу хүүхэдтэй гэсэн шалтгаанаар ажилд авахаас татгалзах, цалинг бууруулах, ажлаас халах, жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл ба нэг нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүдийг илүү цагаар ажиллуулахыг тус тус хориглосон байна. 1973 оны Хөдөлмөрийн хуулийн 150 дугаар зүйлд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хөдөлмөрийн хүнд буюу хортой нөхцөл бүхий ажил, түүнчлэн эмэгтэйчүүдэд зориулж тогтоосон дээд хэмжээнээс илүү хүнд ачаа тээшийг өргүүлэх буюу зөөлгөхийг хориглох тухай заалтыг оруулжээ. Мөн хөхүүл хүүхэдтэй, нэг нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүд урьд эрхэлж байсан ажлаа хийх боломжгүй бол тэднийг өөр ажилд шилжүүлж, хөхүүл хүүхдээ нэг нас хүртэлх хугацаанд урьд авч байсан дундаж цалинг олгохоор заасан байна. Жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, нэг нас хүрээгүй хүүхэдтэй эмэгтэйчүүдийг захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглосон заалтыг 1973 оны хуульд тусгажээ. Харин байгууллага бүрмөсөн татан буугдаж байгаа тохиолдолд жирэмсэн, нэг хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд заавал ажил олж өгснөөр ажлаас халж болно гэж заасан нь эх, хүүхдийн эрүүл мэнд, эдийн засгийн баталгааг хангасан зохицуулалт болжээ. Түүнчлэн жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл буюу нэг нас хүрээгүй хүүхэдтэй эмэгтэйчүүдийг шөнийн буюу илүү цагаар ажиллуулах, албан томилолтоор явуулахыг хориглов.

1941 оны Хөдөлмөрийн хуульд хүүхдээ хөхүүлэхэд нь зориулж хүүхдийг долоон сар хүртэл нь хагас цагийн завсарлага олгож байсан бол 1973 онд баталсан Хөдөлмөрийн хуулийн 155 дугаар зүйлд дээрх хугацааг нэмэгдүүлж, зургаа хүртэл сартай хүүхэдтэй эхчүүдэд хоёр цагийн, 6-12 хүртэл сартай хүүхэдтэй эхчүүдэд нэг цагийн завсарлага олгож, хүүхэд хөхүүлэх завсарлагыг ажилласан цагт оруулан тооцохоор тусгасан нь өнөөдрийг хүртэл мөрдөгдөж байна. Жирэмсэн буюу амаржсан эхчүүдэд хүүхдээ төрүүлэхээс өмнө 45 хоног, амаржсаны дараа 56 хоног амралт эдлүүлэхээр болсон нь амаржсаны дараах амралтын хугацааг 1941 оны Хөдөлмөрийн хуулиас 11 хоногоор нэмэгдүүлжээ. Харин хүүхдээ хүндрэлтэй төрүүлсэн эсхүл хоёр буюу түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлсэн бол амаржсаны дараах амралтыг 70 хоногоор олгох тухай заалтыг шинээр оруулсан байна. Түүнчлэн жирэмсний амралтаа бүрэн эдлээгүй эхчүүдэд олговол зохих амралтын дутууг амаржсаны дараах амралт дээр нэмж олгох тухай зохицуулалтыг шинээр бий болгожээ. Энэхүү хуульд хүүхэд үрчлэн авсан эмэгтэйчүүдийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шинээр тусгасан байна. Тухайлбал, үрчилж авсан хүүхдийг нь 56 хоногтой болтол хугацаанд амралт олгож, улсын нийгмийн даатгалын хөрөнгөнөөс тэтгэмж олгох, хүүхдийг нь зургаан сар хүртэл цалингүй чөлөө олгох тухай заалтуудыг дурдаж болно. 1973 оны Хөдөлмөрийн хуулиар хүүхдээ төрүүлсэн эх 101 хоногийн цалинтай амралт

дууссаны дараа ээлжийн амралтаа эдэлсэн эх өөрөө хүсэлт гаргавал зургаан сар хүртэл хугацаанд цалингүй чөлөө олгож, эрхэлсэн албан ажлыг нь хэвээр байлгах тухай заалтыг шинээр тусгажээ. Ийнхүү олгосон цалингүй чөлөөг ажилтны нийт ажилласан болон тасралтгүй ажилласан хугацаа, түүнчлэн тодорхой мэргэжлээр ажилласан хугацаанд тус тус оруулан тооцох болсноор эмэгтэйчүүдийн хувьд ажилласан жил тасрахгүй байхад чухал ач холбогдолтой заалт болжээ.

Мөн хуулийн 160 дугаар зүйлд “Хүүхдээ 196 өдрөөс дээш тээгээд дутуу гаргасан буюу эмнэлгийн тодорхойлолтоор үр хөндүүлсэн эмэгтэйчүүдэд амаржсаны амралт олгоно. Хүүхдээ 196 өдөр хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу эмнэлгийн тодорхойлолтоор үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийг ажлаас чөлөөлөхдөө өвчний учир чөлөөлөх ердийн журмыг баримтална” гэж заасан байна.

1973 оны Хөдөлмөрийн хуулийн 161 дүгээр зүйлд эмэгтэй ажилчин олонтой үйлдвэр, албан газар, байгууллагад хүүхэд саатуулах газар, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд хөхүүлэх тасалгаа, эмэгтэйчүүдийн ариун цэврийн тасалгаа байгуулах тухай тусгасан нь хүүхдийн цэцэрлэг, яслийн хүрэлцээг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Түүнчлэн энэхүү хуулийн 162 дугаар зүйлд Үйлдвэрчний эвлэлийн байгууллага болон үйлдвэр, албан газар, байгууллага нь шаардлагатай үед нийгмийн даатгалын болон үйлдвэр, албан газар, байгууллагын зардлаар жирэмсэн эмэгтэйчүүд, ганц бие болон бага насны олон хүүхэдтэй эхчүүдэд амралт сувиллын газарт амрах эрхийн бичиг үнэгүй буюу хөнгөлттэйгээр олгож болох бөгөөд мөн тэдэнд материалын тусламж үзүүлж болно гэж заажээ.

1991 онд баталсан Хөдөлмөрийн хуулийн 77 дугаар зүйлд эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар баталж мөрдүүлэхээр тусгажээ. Хуулийн 78 дугаар зүйлд жирэмсэн эмэгтэйчүүд, хоёр (ихэр бол гурван) нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүдийг захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглосон ба нэг нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүдийг шөнийн буюу илүү цагаар ажиллуулах, албан томилолтоор явуулахыг хориглосон. Харин жирэмсэн эхчүүд, найм хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд, 16 хүртэл насны хүүхэдтэй ганц бие эцэг, эхийг зөвхөн өөрийнх нь зөвшөөрснөөр шөнийн болон илүү цагаар ажиллуулах буюу албан томилолтоор явуулж болох тухай заасан байна. Мөн амрах, хооллох, нийтийн завсарлагаанаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад нь зориулан зургаан сар хүрээгүй буюу ихэр бол нэг нас хүрээгүй ихэр хүүхэдтэй эхчүүдэд хоёр цагийн завсарлага, зургаан сараас нэг хүртэл насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмчийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах

хүүхэдтэй эх, ганц бие эцэгт нэг цагийн завсарлага олгохоор заасан. 1973 оны Хөдөлмөрийн хуулиар энэ завсарлагыг зөвхөн хүүхдээ хөхүүлэхэд зориулж хөхүүл эхчүүдэд олгож байсан бол 1991 оны Хөдөлмөрийн хуулиар хүүхдээ хөхүүлэхээс гадна асрахад нь зориулж эмчийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эх, ганц бие эцэгт мөн уг завсарлагыг олгож ажилласан цагт оруулан тооцох болсноороо дэвшилттэй болжээ. Харин хүүхэд асрах чөлөө дууссан эсхүл дуусаагүй боловч эх өөрөө хүсвэл түүнийг ажил албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүргийг захиргаанд хүлээлгэж, орон тоо хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн тохиолдолд түүнд өөр ажил олж өгөх тухай шинээр заалт оруулсан нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн баталгааг хангаж өгсөн байна. Мөн эдгээр заалт нь ганц бие эцэг, хүүхэд үрчлэн авсан хүмүүст нэгэн адил хамаарах тухай хуульчилжээ.

1991 оны Хөдөлмөрийн хуульд жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн эхийн хөдөлмөрийн талаар дараах байдлаар тусгасан байна. Жишээлбэл, хуулийн 84 дүгээр зүйлд хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөх тухай эмнэлгийн дүгнэлт гарсан бол жирэмсэн эмэгтэйчүүдийн ажлын цагийг хорогдуулах буюу тэдний эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно. Энэ тохиолдолд урьд авч байсан дундаж хөлсийг хэвээр олгоно. Нэг нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүд эрхэлж байгаа ажлаа хийх боломжгүй бол хүүхдийг нь нэг нас хүртэлх хугацаанд тэднийг өөр ажилд шилжүүлж, хэрэв энэ хугацаанд хөдөлмөрийн хөлс нь буурахаар байвал урьд авч байсан дундаж хөлсийг олгоно хэмээн заажээ.

Харин Хөдөлмөрийн тухай 1999 оны хуулиар⁶ жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эхийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан болон хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан тохиолдолд ажлаас халахыг ажил олгогчид зөвшөөрсөн байна. 1999 оны Хөдөлмөрийн тухай хуульд эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлах тухай хуульчилсан. Хуулийн 102 дугаар зүйлд заасны дагуу жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томиллолтоор ажиллуулахыг хориглох тухай заасан нь 1991 оны Хөдөлмөрийн хуулийн заалттай ижил байна.

Мөн хуулийн 104 дүгээр зүйлд эхэд жирэмсний болон амаржсаны 120 хоногийн амралт олгох тухай заасан нь өмнөх 1973, 1991 оны Хөдөлмөрийн хуулиудаас 19 хоногоор нэмэгджээ. 1973, 1991 оны Хөдөлмөрийн хуулийн дагуу нярай хүүхэд үрчлэн авсан эхэд хүүхдийг нь 56 хоногтой болтол нь амаржсан эхийн адил чөлөө олгох зохицуулалттай байсан бол 1999 оны

⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл, № 25, УБ, 1999

хуулиар нэмэгдүүлэн 60 хоног болгожээ. Мөн хүүхэд асрах чөлөөг гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэгт хүсэлтээр нь олгохоор болсон байна. 1973, 1991 оны Хөдөлмөрийн хуулиар уг чөлөөг зөвхөн хоёр нас хүртэл хүүхэдтэй эх, харин ихэр бол гурван нас хүртэл хүүхэдтэй эх эдлэх эрхтэй байв. Хуулийн 108 дугаар зүйлд хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан хэмжээнээс илүү хүнд ачааг эмэгтэй хүнээр өргүүлэх, зөөлгөхийг хориглох тухай заажээ.

2021 оны Хөдөлмөрийн тухай хуульд эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх таатай боломж нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн цөөнгүй заалтыг тусгасан. Тухайлбал, 43 дугаар зүйлийн 43.3-т ажил олгогч нь ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх тухай заасан. Мөн тавдугаар зүйлд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, нийгмийн түншлэлийг хангах зэрэг ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны суурь зарчмуудыг анх удаа тусгаж өгснөөрөө шинэлэг болсон бөгөөд ОУХБ-ын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцсэн байна.

Хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой харилцан тохиролцож болох тухай заалт, бүтэн бус цагаар ажиллуулах, гэрээсээ ажиллах зохицуулалт нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой болсон.

Харин жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтныг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулахыг хориглох тухай 141 дүгээр зүйлд, өөрөө зөвшөөрөөгүй бол шөнийн цагаар ажиллуулахыг хориглох тухай 88 дугаар зүйлийн 88.5 дахь хэсэгт заажээ. Энэ нь 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн дагуу жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулахыг хориглож байсан зохицуулалтаас дордож, хүүхдийн насны хязгаар найм, харин ганц бие эхийн хувьд хүүхдийн нас 16 нас байсныг өөрчилж, зөвхөн гурав хүртэлх насны хүүхэдтэй эхэд хамааруулах болсон байна. Үүнийг эх, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүмүүжилд сөрөг нөлөөтэй, 1991, 1999 оны Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас дордуулсан гэж үзэхээр байна.

Мөн 2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 98 дугаар зүйлийн 98.2 дахь хэсэг жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй, эсхүл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй

ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулахыг хориглох тухай заалт шинээр орсон. Гэвч НҮБ-ын байгууллагаас баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар “хүүхэд” гэдэг ойлголтод 18 нас хүртэлх хүнийг хамааруулдаг учраас 98 дугаар зүйлийн 98.2 дахь хэсгийн “16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй” гэснийг “...18 хүртэлх насны” гэж тусгасан бол хүүхдийн талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид илүү нийцэх байв.

Эх, нялхсын хамгаалалтыг эрчимжүүлэх шаардлага байна. Практикт эзгүй, ажлын байр нь хадгалагдаж байгаа (жишээ нь, хүүхэд асрах чөлөөтэй байгаа) ажилтны оронд түр, хугацаатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтан жирэмсэн болсон тохиолдолд гэрээний хугацаа дуусмагц Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.3 дахь заалтын дагуу түр ажилтны хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгодог. Энэ нь нэг талаасаа хуульд нийцсэн, хугацаатай хөдөлмөрийн гэрээний зохицуулалт боловч нөгөө талаасаа хөдөлмөрийн гэрээний хугацаа нь дуусгавар болсноор жирэмсэн ажилтан ажилгүй, жирэмсний болон амаржсаны тэтгэмжгүй хохирч үлдэх тохиолдол гарсаар байна. Эдгээр тохиолдол Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэсэн заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлд заасан жирэмсэн эмэгтэйн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахыг хориглох тухай заалттай зөрчилдөж байна.

2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалтад жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтны ажлын байр хэвээр хадгалагдах боловч чөлөөний хугацаа дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор ажилтан ажилдаа ороогүй, эсхүл уг хугацааг сунгах хүндэтгэн үзэх шалтгаан бүхий хүсэлт гаргаагүй бол ажлын байрыг нь хадгалах ажил олгогчийн үүрэг дуусгавар болгох талаарх заалтыг шинээр оруулжээ. 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд аж ахуйн нэгж, байгууллага бүхэлдээ татан буугдсан, хөдөлмөрийн сахилгын ноцтой, давтан зөрчил гаргаснаас бусад тохиолдолд жирэмсэн, гурав хүртэлх насны хүүхэдтэй эхийг ажлаас халахыг хориглосон. 2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх (ганц бие эцэг)-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлах тохиолдлыг нэмэгдүүлж, эд хөрөнгө хариуцсан этгээд ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэл гаргасан, ажилтан ажилд орох үедээ боловсрол, мэргэжил, мэргэшлийн түвшнийг нотлох баримт бичгээ хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдвол ажлаас халах тухай заасан байна.

Хүүхэд хөхүүлэх, асрах, нэмэлт завсарлага олгох хугацааны хувьд 2021 оны Хөдөлмөрийн тухай хуульд өмнөх 1999 оны хуулиас өөрчлөлт ороогүй боловч ажилтны хүсэлтээр хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажлын цагийг богиносгох хэлбэрээр олгож болох тухай заалтыг шинээр нэмсэн нь уян хатан зохицуулалт болсон байна. Мөн ажил олгогч ажилтныг хүүхдээ хөхүүлэх өрөөгөөр хангах арга хэмжээг өөрийн боломжоор авах тухай 136 дугаар зүйлийн 136.3 дахь хэсэгт хөхүүл хүүхэдтэй эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой болжээ.

Хүснэгт 1. Жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөө, хүүхэд хөхүүлэх хооллох завсарлага (1925-2021 он)

| № | Огноо | Хуулийн нэр | Жирэмсний амралт | Амаржсаны амралт | Хүүхэд асрах чөлөө | Хүүхэд хөхүүлэх, хооллох завсарлага |
|---|-------|------------------------------------|--|---|---------------------------------------|--|
| 1 | 1925 | Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм | | 3 сар | - | - |
| 2 | 1930 | БНМАУ-ын хүчнээн үнэлэгчдийн дүрэм | | 3 сар | - | 3 цаг хагас тутамд 30 минутаас доош бусаар |
| 3 | 1933 | Хүчин үнэлэхүйн тухай хууль | 6 цагийн ажлын өдөртэй бол тус бүр 1 сар, 8 цагийн ажлын өдөртэй бол тус бүр 1.5 сар | | - | Нярайлнаас хойш 9 сарын дотор 30 минут |
| 4 | 1934 | Хүчин үнэлэхүйн тухай хууль | 6 цагийн ажлын өдөртэй бол тус бүр 1 сар, 8 цагийн ажлын өдөртэй бол тус бүр 1.5 сар | | - | Нярайлнаас хойш 6 сарын дотор өдөрт 1 удаа 30 минут |
| 5 | 1941 | БНМАУ-ын Хөдөлмөрийн тухай хууль | 7 сараас доошгүй хугацаагаар ажилласан бол төрөхийн өмнө 1 сар төрсний дараа 1 сар | | - | Нярайлнаас хойш 7 сарын хугацаанд 30 минутаас доошгүй |
| 6 | 1973 | БНМАУ-ын Хөдөлмөрийн тухай хууль | 45 хоног | 56 хоног Хүүхдээ хүндрэлтэй төрүүлсэн бол 70 хоног | Эх хүсвэл 6 сар хүртэл цалингүй чөлөө | 6 хүртэл сартай хүүхэдтэй эхчүүдэд 2 цаг, 6-12 сар хүртэл хүүхэдтэй эхчүүдэд 1 цаг |

| | | | | | | |
|---|------|-------------------------|----------|---|---------------------------------|---|
| 7 | 1991 | Хөдөлмөрийн хууль | 45 хоног | 56 хоног Хүүхдээ хүндрэлтэй төрүүлсэн бол 70 хоног | 2 жил, ихэр хүүхэдтэй бол 3 жил | 6 хүртэл сартай хүүхэдтэй эхчүүдэд 2 цаг, 6-12 сар хүртэл хүүхэдтэй эхчүүдэд 1 цаг |
| 8 | 1999 | Хөдөлмөрийн тухай хууль | 60 хоног | 60 хоног | 3 жил | 2 цаг |
| 9 | 2021 | Хөдөлмөрийн тухай хууль | 60 хоног | 60 хоног ихэр хүүхэдтэй бол 80 хоног | 3 жил | 6 хүртэл сартай хүүхэдтэй эхчүүдэд 2 цаг, 6-12 сар хүртэл хүүхэдтэй эхчүүдэд 1 цаг / ажилтны хүсэлтээр уг завсарлагыг ажлын цагийг богиносгон олгож болно./ |

Жирэмсэн эхчүүдийн жирэмсний болон амаржсаны амралтын хоногийг 120 хоногоор тооцох хугацаанд өөрчлөлт ороогүй боловч харин ихэр хүүхэдтэй тохиолдолд 20 хоногоор нэмэгдүүлэн 140 болгон өөрчилсөн байна. Ажилтанд хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд тэтгэмж олгох асуудлыг нээлттэй үлдээж, холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулах тухай заалтыг хуулийн 139 дүгээр зүйлд шинээр тусгасан нь амаржсан эхчүүдэд байгууллагын зүгээс “цалинтай ээж” хөтөлбөртэй дүйцэхүйц, эдийн засгийн нэмэлт эх үүсвэр бий болгох таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ.

2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлд “эцгийн чөлөө” гэсэн нэр томъёог шинээр бий болгосон бөгөөд 137.5 дахь хэсэгт заасны дагуу эцэгт шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10-аас доошгүй өдрийн чөлөөг олгохыг ажил олгогчид даалгаж, тухайн хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгохоор тусгасан нь эрэгтэйчүүдэд шууд хамааралтай боловч эх, хүүхдийн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй, ОУХБ-ын баталсан хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцсэн заалт болсон гэж дүгнэж байна.

1960 оны Үндсэн хуулийн 84 дүгээр зүйл хүүхдийн ясли, цэцэрлэгийг өргөтгөх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг хангах тухай, 1973 оны Хөдөлмөрийн хуулийн 161 дүгээр зүйлд заасан эмэгтэй ажилчин олонтой үйлдвэр, албан газар, байгууллага дэргэдээ хүүхэд саатуулах газар, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд хөхүүлэх тасалгаа байгуулах тухай зохицуулалт нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Эдгээр нь одоо ч ач холбогдлоо алдаагүй зохицуулалт бөгөөд 2021 оны Хөдөлмөрийн тухай хуульд аж ахуйн нэгж, албан байгууллага хүүхэд хөхүүлэх өрөөтэй болох асуудлыг сэргээн оруулсан байна.

Бүхэлд нь авч үзэхэд Ардын төр үүсэн байгуулагдсанаас хойшхи 100 жилийн хугацаанд Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулах олон талын арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын эмэгтэйчүүд нийгмийн бүх салбарт эрх тэгш байх, чөлөөтэй хөдөлмөрлөх эрхтэй болж энэ нь төрийн хуульд баталгаажин, улмаар олон улсын стандартын дагуу баталгаатай хэрэгжих болов. Үүнийг 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хууль, 1921 оны 3 дугаар сарын 18-наас хойш үйлчилж ирсэн хөдөлмөрийн хууль тогтоомж, бусад актаар тодорхойлж болно. 2021 оны Хөдөлмөрийн тухай хуульд эх, нялхсыг хамгаалах, гэр бүл, хүүхдэд ээлтэй олон шинэ зохицуулалтыг тусгаснаараа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд өмнөх хууль тогтоомжоос илүү дэвшилттэй болсон байна.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсад үйлчилж байсан Хөдөлмөрийн тухай хуулиудад тусгагдсан эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн зохицуулалтыг 1925 оноос судлан үзэж зохих харьцуулалт хийсний үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрэв.

1. Монгол Улсад эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх, эрх чөлөө үүсэж, нийгмийн хөгжлийн дагуу улам өргөжин хөгжсөн;
2. Энэхүү хөгжил эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөний талаарх олон улсын стандарт жишигт нийцүүлэх чиглэлийг тууштай баримтлах болсон;
3. Хүний эрх, эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн хүрээнд монголын төрөөс тууштай бодлого, хууль зүйн зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна.
4. Цаашид эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөрийг бий болгох, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг ОУХБ-ын хэм хэмжээтэй нийцүүлэх шаардлагатай байна.

IV. НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1924
2. Монгол Улсын Үндсэн хууль, 1940
3. Монгол Улсын Үндсэн хууль, 1960
4. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
5. Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм, 1925
6. БНМАУ-ын Хүчнээн үнэлэгчдийн хууль, 1930
7. БНМАУ-ын Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1933
8. БНМАУ-ын Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1934
9. БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль, 1941
10. Хөдөлмөрийн хууль, 1973
11. Хөдөлмөрийн хууль, 1991
12. Хөдөлмөрийн тухай хууль, 1999
13. Хөдөлмөрийн тухай хууль, 2021
14. Л.Баасан. С.Болормаа. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиуд Хууль тогтоомжийн эмхэтгэл, 2003
15. С.Батаа. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд 1924-1992 , 1998

Монгол эх сурвалж:

1. Л.Баасан. Хөдөлмөрийн эрх зүй сурах бичиг, 2010
2. Л.Баасан. Д.Баянбилэг. Хөдөлмөрийн харилцаа, 2014





Д.СҮНЖИД

ХЭҮК-ын гишүүн, Хуль зүйн ухааны доктор

ЕВРОПЫН ХҮНИЙ ЭРХИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН АГУУЛГА¹

STRUCTURES OF THE EUROPEAN COURT HUMAN RIGHTS JUDGEMENTS

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын (цаашид ХБНГУ гэх) эсрэг хувь хүний гаргасан гомдлоор 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Европын хүний эрхийн конвенцыг зөрчсөн эсэхийг шийдвэрлэсэн хэрэг (Nr. 45216/07)²

I. УДИРТГАЛ

ХБНГУ-ын Берлин муж улсын хууль тогтоох байгууллагаас³ 2004 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуульд 2006 оны 03 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дараах томъёоллыг нэмжээ. “Ёс зүйн хичээл нь нийтийн (төрийн өмчийн сургууль гэх утгатай

¹ https://www.bmj.de/SharedDocs/EGMR/DE/20091006_45216_07.html;jsessionid=C70EEED01CAD6124473C19D103941F96.1_cid324?nn=6966392

² https://www.bmj.de/SharedDocs/EGMR/DE/20091006_45216_07.html;jsessionid=C70EEED01CAD6124473C19D103941F96.1_cid324?nn=6966392

³ ХБНГУ нь холбооны байгууламжтай улс бөгөөд 16 муж улсаас бүрдэнэ. Холбооны Үндсэн хууль, холбооны хуульд нийцүүлэн муж улсууд Үндсэн хууль, бусад хууль батлах эрхтэй байдаг.

дүйнэ орчуулагчийн тайлбар) сургуулийн 7-10 дугаар ангийн нийт сурагчдын заавал үзэх хичээлийн хөтөлбөрт хамаарна. Ёс зүйн хичээлийн зорилго нь сурагчдаас хувь хүний соёл, угсаа, шашин шүтлэг болон ертөнцийг үзэх үзлээс хамааралгүйгээр, хувь хүний хувьд ч, соёлын ба ёс зүйн хувьд тулгардаг бэрхшээлтэй асуудлыг нийгмийн хамтын амьдрал дахь олон янзын үнэт зүйл, цаад утгыг ойлгож, бүтээлчээр харилцах ур чадвар, боловсролыг дэмжинэ. Ингэснээр сурагчид хариуцлагыг ухамсарлаж, бие дааж амьдрах болон нийгмийн харилцааны чадавх эзэмших, соёл хоорондын хэлэлцүүлэг өрнүүлэх, ёс зүйн хувьд шийдвэр гаргах ур чадварыг эзэмших болно. Энэ зорилгоор гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл, шашны ёс зүй мөн олон янзын соёл, аж төрөх арга хэлбэр, дэлхийн томоохон шашны урсгалууд болон амьдралын хэв маягтай танилцахад хэрэгцээтэй мэдлэгийг дамжуулна. Энэхүү ёс зүйн хичээл нь ёс зүйн үндсэн зарчмыг таниулах, Холбооны Үндсэн хууль, Берлин муж улсын Үндсэн хууль болон Берлин муж улсын Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан боловсрол ба хүмүүжлийн үүргийг биелүүлэхэд чиглэх бөгөөд тус хичээлийн агуулгын хүрээнд ертөнцийг үзэх үзэл ба шашны хувьд төвийг сахисан байдлаар хичээлийг заана. Ёс зүйн хичээл нь тодорхой сэдвийн хүрээнд шашны болон ертөнцийг үзэх үзлийн талаарх үйл ажиллагааг дагнан эрхэлдэг нийгэмлэг, байгууллагатай хамтарвал зохих ба тухайн сургууль шашны нийгэмлэг, байгууллагуудтай ямар байдлаар хэрхэн хамтарч ажиллах талаар шийдвэрлэнэ. Хүүхэд хүмүүжүүлэх үүрэг хүлээгч нарт сургуулиас ёс зүйн хичээлийн зорилго, агуулга, хэлбэрийг тухай бүр, тохиромжтой байдлаар мэдээлнэ.” гэсэн байна.

II. ГОМДЛЫН АГУУЛГА

1. Ерөнхий үйл баримт

Евангали шашны урсгалыг шүтдэг хоёр сурагчийн эцэг, эхчүүдээс ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргасан байна. Тус шүүхээс 2006 оны 07 дугаар сарын 14-ний өдөр гомдлыг үндэсний хэмжээнд хүний эрх сэргээх, хамгаалах байгууллагад хандаж, шийдвэрлүүлээгүй болохыг тэмдэглээд, Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 1 дэх өгүүлбэрт заасны дагуу эхлээд энэхүү хичээлээс чөлөөлүүлэх тухай хүсэлтээ гаргах, дараа нь нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу Захиргааны хэргийн шүүхэд хандах боломжтой болохыг гомдол гаргагчдад мэдэгджээ. Ийнхүү гомдол гаргагчид хүүхэд нь суралцдаг сургуульд хандаж ёс зүйн хичээлээс чөлөөлүүлэх тухай хүсэлтээ гаргасан бөгөөд 2006 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Берлин муж улсын Захиргааны хэргийн шүүхэд хандаж, тус нэхэмжлэлийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх

хугацаанд хуулийн заалтын үйлчлэлийг түдгэлзүүлж, хичээлээс хүүхдийг түр чөлөөлүүлэх хүсэлт гаргажээ.

2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр

Берлин муж улсын Захиргааны хэргийн шүүх 2006 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн шийдвэрээр гомдол гаргагч нарын дээрх хүсэлтийг дараах үндэслэлээр татгалзаж шийдвэрлэсэн байна. Берлин муж улсын Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 1 дэх өгүүлбэрт заасны дагуу хичээлээс сурагчийг ерөнхийд нь чөлөөлөх шийдвэр гаргах асуудал хэвээр үйлчилнэ, харин гомдол гаргагчаас чухал, хойшлуулшгүй ямар үндэслэлээр хүүхдээ хичээлд суулгахыг түдгэлзүүлэх буюу хичээлээс түр чөлөөлүүлэх хүсэлт гаргаж байгаа үндэслэл нотлогдохгүй байна. Берлин муж улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан нийт сургуулийн сурагчдад хариуцлага ухамсарлах, үнэт зүйлийг түгээх зан байдал, хүмүүжлийн төлөвийг тус хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан нөхцөлийн дагуу олгоход Ёс зүйн хичээлийн зорилго оршиж байна. Иймээс тус хичээлийн зорилго нь зөвхөн мэдлэгийг дамжуулаад зогсохгүй, түүний зэрэгцээ тодорхой агуулга, нийгмийн бие даасан гишүүний хувьд бодитой ур чадварыг хөгжүүлэх, төлөвшүүлэх асуудлыг хамардаг тул Захиргааны хэргийн шүүхээс тухайн хичээлийн агуулга төвийг сахисан, ямар нэг ертөнцийг үзэх үзэл эсхүл шашин шүтлэгийн суурь, итгэл үнэмшлийг илүүд үзээгүй болохыг тогтоожээ.

Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт ёс зүйн ерөнхий ойлголт, үндсэн зарчмыг нийгэм дэх бүлгийн олон янз байдлыг агуулсан байхаар тодорхойлсон байдаг. Ямар нэг тодорхой ёс зүйн стандартыг заахгүй, харин ертөнцийг үзэх үзэл-шашин шүтлэгийн олон янз байдал нь хүний эрхэм чанар, хувь хүний өөрийгөө тодорхойлох, хөгжүүлэх, түүнчлэн өөрийн хариуцлагыг ухамсарлахад зориулагдсан байх нь Холбооны Үндсэн хуулийн зарчимд ч нийцнэ. Захиргааны хэргийн шүүхээс шашны болон ертөнцийг үзэх үзлийн талаар заахдаа сургуулиас төвийг сахих нь сургуулийн практикт бодитой хэрэгжүүлэхэд тухайлан нарийвчилсан хэмжүүр байхгүй болохыг тэмдэглээд, ёс зүйн хичээлийг заах үйл явц нь энэ маргааны зүйл биш болохыг дүгнэжээ.

Түүнчлэн 2006 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Берлин муж улсын Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс энэхүү анхан шатны шүүхийн шийдвэрийг баталгаажуулжээ. Тэрээр ёс зүйн хичээл нь төвийг сахисан, аль нэг талыг баримтлаагүй байх ёстой бөгөөд хичээлийн гол агуулга нь хүнлэг байх, ардчилал, эрх чөлөө мөн түүнчлэн толеранц (олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, зэрэгцэн орших), бусдын итгэл үнэмшлийг хүндэтгэх, амьдралын

жам ёсны суурь бүтцийг хадгалах, хариуцлага ухамсарлах, ингэснээр хүч хэрэглэсэн зөрчилдөөнөөс зайлсхийхэд суралцахад оршиж байна. Энэхүү агуулга нь Холбооны үндсэн хуульд заасан ёс зүйн стандартад нийцэж байх тул үндсэн хуулийн эрх зүйн хувьд зөрчилгүй. Ёс зүйн хичээлийн агуулга нь практикт хэрэгжүүлж буй сургалтын ерөнхий хөтөлбөртэй зөрчилдөхгүй байна.

Гомдол гаргагчид Холбооны үндсэн хуулийн шүүхэд хандахдаа нийтийн сургуулийн хичээллэх танхимд загалмай байрлуулахыг хориглосон Холбооны Үндсэн хуулийн өмнөх шийдвэрийн үндэслэлийг дурдсан байх бөгөөд гаргасан гомдлын агуулгыг түүнтэй харьцуулах боломжгүй хэмээн давж заалдах шатны шүүхээс дүгнэжээ. Мөн гомдол гаргагч нар шашингүйн буюу үл итгэгчийн хичээлд суух нь албадлага юм хэмээн гомдолд дурдсан. Энэ нь өөрийнх нь хувийн итгэл үнэмшилд халдаж буй хэрэг биш, сургуульд заадаг шашны хичээлээр үндсэндээ зөвхөн христийн шашны ёс зүйн үнэт зүйлийг дамжуулдаг билээ. Гомдол гаргагч нарын таамаглаж буй ёс зүйн хичээл нь сүмд, эсхүл шашинд дайсагнасан байдлаар биш үндсэн суурь агуулгыг хамаарч байна. “Чөлөөт сэтгэлгээний номлол”-ын үүднээс итгэл үнэмшилд суурилсан ертөнцийг үзэх үзлийн талаар хичээл болох “хүнлэг нийгэм судлал”-ын сонгон үздэг хичээлтэй ёс зүйн хичээлийг гомдол гаргагч нар хольж тайлбарласан байх тул хооронд нь харьцуулах боломжгүй юм. Ёс зүйн хичээл нь сонгон судалдаг хичээл биш болохыг хуулиар баталгаажуулсан тул сурагчийг хичээлээс чөлөөлүүлэх боломжгүй. Үндсэн хуулийн эрх зүйд нийцсэн байдлаар шашны хичээлд оролцохгүйгээр ёс зүйн хичээлд сууж болох хувилбараар энэхүү хичээл нь нэмэлт хичээл байх боломжтой хэдий ч Берлин муж улсын хууль тогтоогчид ёс зүйн хичээлийг заавал үзэх хичээл хэмээн хуульчилсан байна.

3. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр

Холбооны Үндсэн хуулийн шүүхээс 2007 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрээр Захиргааны хэргийн шүүхээс гомдол гаргагч нарын гомдолд дурдсан эрх зүйн асуудлыг өргөн хүрээнд тайлбарлаж, шийдвэрлэсэн бөгөөд цаашид тодорхойгүй үлдсэн, тайлбарлах шаардлагатай эрх зүйн асуудал үлдээгүй тул нэмэлт дүгнэлт хийх шаардлагагүй гэжээ.

Холбооны Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шашин шүтэх эрх чөлөө, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан өөрийн шашин, ертөнцийг үзэх үзэх итгэл үнэмшлээр хүүхдийг хүмүүжүүлэх тухай заасан заалтыг ёс зүйн хичээлийн агуулга зөрчөөгүй гэж үзсэн байна. Ёс зүйн хичээлийг заавал үзэхээр хуульчилсаны улмаас гомдол гаргагч нарын дээрх эрх ямар нэг байдлаар зөрчигдөөгүй. Ёс зүйн хичээлийг үзсэнээр сурагчид болон эцэг эхэд

нь шашны хичээл үзэхээс татгалзахад хүргэх зохисгүй байдлаар нөлөөлж болзошгүй гэж тайлбарлах боломжгүй. Шашны хичээлд суудаг сурагчдын тоо энэ хичээлд суудаггүйгээс харьцангуй их олон тоотой байдаг. Сурагчдаас сайн дураар хичээл сонгож, үндсэн хөтөлбөр дээр нэмэлтээр суралцдаг нь нэгэнт тогтсон бодит практик юм. Холбооны үндсэн хуулийн шүүхээс гомдол гаргагч нарыг хувийн ямар нэг итгэл үнэмшлийн эсрэг агуулгатай хичээлд заавал суухыг албадаагүй учир гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.

Холбооны Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт баталгаажуулсан заалт нь хуулиар зөвхөн хатуу зохицуулагдах заалтад хамаарахгүй, тиймээс энэхүү эрхийг хязгаарлах боломжтой бөгөөд Холбооны Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан төрийн боловсрол, хүмүүжүүлэх үүрэгт хамаарна. Энэхүү үүргийн дагуу эцэг, эхчүүдийн хувийн зорилгоос үл хамааран төвийг сахисан байдал, толеранцын талаар сурагчдад хүмүүжил, төлөвшлийг заах боломжтой юм. Захиргааны байгууллагын зүгээс шашин хоорондын энх тайванд аюул занал учруулахаар тодорхой нэг итгэл үнэмшил эсхүл өөрийгөө адилтгаж, ижилсүүлэхэд нөлөөлөх, эсхүл эцэг, эх ба хүүхдийн хоорондын шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөний зөрчилдөөнийг шийдвэрлэхээр ил далд ямар нэг байдлаар нөлөөлөх ёсгүй. Хууль тогтоогчийн үүрэг бол нийтийн сургуульд олон янзын ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшлийн урсгал чиглэлд хамаарах хүүхдүүдийг хүмүүжүүлэхэд толеранцыг тэнцвэртэйгээр сургаж түгээхээс зайлсхийх ёсгүй юм. Тиймээс нэг талаас зөвхөн тодорхой шүтлэгт итгэх итгэл үнэмшлийг бэхжүүлэхэд чиглэсэн ёс зүйн хичээлийн агуулга нийгэмд оршин буй ёс суртахуун, ёс зүй, эсхүл шашны байр суурины үүднээс хууль ёсных байх боломжгүй билээ. Нөгөө талаас үзэл бодол, байр суурийн олон янз байдалд нээлттэй хандах нь эрх чөлөөт, ардчилсан төрийн нийтийн сургуульд байх ёстой шалгуур болно. Төрөөс нийтийн сургуульд шашны болон ертөнцийг үзэх үзлийн хувьд зэрэгцсэн сүүдрийн нийгэм бий болохоос зайлсхийхэд нөлөөлөх, аливаа цөөнхийн оролцоог дэмжих эрхтэй.

Энэхүү үзэл баримтлалд тулгуурлан Холбооны Үндсэн хуулийн шүүхээс утга учиртай оролцоо /интеграци/ гэдэг нь зөвхөн шашны эсхүл ертөнцийг үзэх үзлийн олонхийг дэмжих төдийгүй олонхоос өөрөөр боддог, өөр зүйлд итгэж үнэмшдэг хэсгийг хааж, хязгаарлахгүй байхад оршино гэж тайлбарлажээ. Энэ талаар нийтийн сургуулийн хүлээх үүрэг бол толеранцыг хэрэгжүүлэх, практикт бодитой амьдруулах ажил болно. Толеранц болон хэлэлцүүлэг хийх чадвар нь ардчилсан процессын оролцооны үндсэн шалгуур бөгөөд харилцан ялгаатай шүтлэгийн итгэл үнэмшил, ертөнцийг үзэх үзлийг харилцан хүндэтгэж, хамтран амьдрах суурь нөхцөл юм. Сурагчид болон эцэг эхчүүд хүүхдээ өөрийнхөөс нь өөр шүтлэг, чиглэлийн талаарх ойлголт бүхий хичээлээс чөлөөлөх, оролцуулахгүй байх тухай шаардаж болохгүй.

Харилцан адилгүй ялгаатай шүтлэг, итгэл үнэмшил бүхий нийгэмд Холбооны Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалтын зохицуулалт ч ийм байдлаар эрхийг баталгаажуулдаггүй. Тухайлбал: биологийн хичээлд эволюцын онолыг заах, шашны хичээл дээр хүн анх үүссэн түүхийг заахыг хязгаарлах, эсхүл нөхөн үржихүйн хичээл дээр бэлгийн замаар халддаг өвчний талаар юмуу жирэмснээс хамгаалах арга хэрэгслийн талаар заахыг хязгаарладаггүй. Гэтэл жирэмснээс хамгаалах арга хэрэгслийн тухайд зарим шашны үндсэн зарчимтай зөрчилддөг асуудал байдаг. Берлин муж улсын хууль тогтоогчоос нийгмийн хамтын амьдрал дахь үндсэн үнэт зүйл, ялгамжтай үнэт зүйл бүхий шашин, шүтлэг, ертөнцийг үзэх үзлийг тайлбарлаж, нэг хичээлийн хүрээнд заахаар хуульчилсан байна.

Ёс зүйн хичээлийн агуулгыг олгохдоо төрийн хувьд зөвхөн төвийг сахих зарчмыг сахиагүй, хэлбийсэн тохиолдолд л суралцагч, эцэг, эхийн эрхийг хөндөх боломжтой. Тиймээс ёс зүйн хичээлээс сурагч чөлөөлөгдөх боломжгүй байгааг эрхийн тэнцвэртэй байх зарчмыг зөрчсөн гэж гомдол гаргагчаас үзэж буйг Холбооны Үндсэн хуулийн шүүхээс үндэслэлгүй хэмээн үзсэн бөгөөд Берлин муж улсын хууль тогтоогчоос хүүхэд сургах, хүмүүжүүлэх үүргийн хүрээнд шашин, ертөнцийг үзэх ямар нэг үзэлд хамаардаг, эсхүл үл хамаардагаас ялгалгүйгээр хамтын үнэт зүйлийн суурийг сурагчдад хичээлээр дамжуулан олгох, ингэхдээ бусад шашин, гүн ухааны үзлийн талаар тайлбарлах эрхтэй болохыг тайлбарлажээ.

Шашнаар ялгаж салангид бүлгээр тусдаа хичээл орох, эсхүл хамтын үнэт зүйлийн талаар өөр хичээлийн агуулгаар заах, эсхүл энэ хичээлээс сурагчийг чөлөөлөх замаар биш харин заавал үзэх ёс зүйн хичээлээр бүх сурагчдад адил агуулгаар нийгэм дэх шашны урсгал, бодит байдлын онцлогийг харгалзан тайлбарлах нь Берлин муж улсын хууль тогтоогчийн нийгмийн хамтын амьдралд сурагчийн утга учиртай оролцоо, бусдын итгэл үнэмшил, ялгаатай байдлыг бодитойгоор дэмжих хууль ёсны зорилгыг зөвтгөх үндэслэл юм.

Холбооны Үндсэн хуулийн шүүхээс ёс зүйн хичээл төвийг сахихгүй байна гэсэн гомдлын үндэслэл нотлогдохгүй, үндэслэлгүй байгааг тэмдэглэжээ. Берлин муж улсын Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6 дахь өгүүлбэрт шашны ёс зүй, ертөнцийг үзэх үзлийн хувьд төвийг сахисан байдлаар хичээлийн агуулгыг заахаар тодорхой зохицуулжээ.

Түүнчлэн хичээлийн ерөнхий хөтөлбөрийн шаардлага болгож хичээл заадаг багш өөрийн харьяалдаг урсгал, төлөөлдөг ёс зүйн асуудлаар байр сууриа илэрхийлэх байдлаар сурагчдад нөлөөлөхийг хориглодог. Тиймээс ёс зүйн хичээлийн агуулга нь ёс суртахууны үндсэн хэм хэмжээтэй шууд уялдаатай

байна. Холбооны Үндсэн хуульд, Берлин муж улсын үндсэн хуульд заасан үндсэн эрхийг сурагчид мэдээд зогсохгүй, нийгмийн гишүүн иргэний хувьд амьдралд хэрэгцээтэй суурь хэм хэмжээг төлөвшүүлэхэд суралцах учиртай. Эцэст нь ёс зүйн хичээлээр зөвхөн христийн шашны соёл шингэсэн үзэл бодол, үнэт зүйлийн тайлбараас гадна, ялангуяа хүмүүнлэг байдлын ойлголтыг дамжуулан хүргэхэд чухал үүрэгтэй юм. Энэ хичээлийн зорилго нь сурагчдад сэдэвчилсэн юмуу тодорхой бэрхшээлтэй асуудлаар дамжуулан аливаа зөрчилдөөн, хэлэлцүүлэг хийхэд гүн ухаан, урлаг, шашин, ертөнцийг үзэх үзлээр дамжуулан нөлөөлөх үзэл номлолын суурийг төлөвшүүлэхэд чиглэнэ. Ёс зүйн хичээлийн агуулга нь төрийн хувьд шашны, ертөнцийг үзэх үзлийн олон янзын байдалд төвийг сахих, нээлттэй байх үүргийг анхаарч, нийцсэн байдлаар агуулгыг тодорхойлсон байна. Берлин муж улсын Ерөнхий боловсролын тухай хуульд заасан ёс зүйн хичээлийн талаарх зохицуулалтыг хэрэгжүүлж буй байдал болон хичээлийн хөтөлбөрөөс үзэхэд хуультай нийцэхгүй, эсхүл зөрчилдсөн асуудал байхгүй байна.

Холбооны Үндсэн хуулийн шүүхээс талууд эвлэрэх боломжтой болохыг дурдсаныг тэмдэглэж, энэхүү эвлэрэх саналыг талууд хүлээн авсанаар гомдлын бусад үндэслэлээр шийдвэр гаргах шаардлагагүй болохыг давж заалдах шатны шүүхээс сануулсан байна.

2009 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр шашны хичээлийг заавал үзэх ёс зүйн хичээлтэй адилхан болгох эсэх талаар бүх нийтийн санал, асуулгыг муж улсын хэмжээнд явуулжээ. Санал асуулгад оролцох эрхтэй иргэдийн 29 хувь нь оролцсон бөгөөд оролцогчдын 48.4 хувь нь санал, асуулгыг дэмжсэн үр дүн гарсан байна. Гэвч хуульд заасан санал өгөх эрхтэй иргэдийн оролцооны босго хувьд санал өгсөн иргэдийн тоо хүрээгүй тул хуулийн төслийн саналыг хүлээж авах боломжгүй болжээ. Энэхүү санал асуулгын үеэр Берлин муж улсын сенатаас олон нийтэд түгээсэн мэдээлэлд дурдсанаар энэ мужид 3,4 сая оршин суугчид байдаг бөгөөд 250 гаруй шашны, эсхүл ертөнцийг үзэх үзлийн нийгэмлэгт хамаардаг бөгөөд Берлин муж-хотын бүх сурагчдын тал нь шилжин суурьшигчдын (өөр улсаас шилжин ирсэн) хүүхэд байдаг гэжээ.

III. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ХОЛБОГДОХ ПРАКТИК

1. Холбооны Үндсэн хууль

Холбооны Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт итгэл, үнэмшилтэй байх ба шүтлэгийн эрх чөлөө, шашны болон ертөнцийг үзэх үзлийн эрх чөлөөг баталгаажуулсан байдаг. Холбооны Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүүхдийг халамжлах, хүмүүжүүлэх нь эцэг эхийн жам ёсны эрх

болохыг заасан. Холбооны Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ерөнхий боловсролын сургуулийн асуудал нь төрийн хяналтанд байна, мөн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүүхдийг халамжлах, хүмүүжүүлэх эрх бүхий этгээд нь хүүхдийн шашны хичээлд оролцох эсэхийг шийдэх эрхтэй болохыг тус тус заажээ.

2. Берлин муж улсын Ерөнхий боловсролын тухай хууль

Тус хуулийн 13 дахь зүйлд (2004 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан) шашны болон ертөнцийг үзэх үзлийн талаарх сонгож үзэх хичээлээр агуулгыг хүргэхэд хуульд нийцсэн байдлаар байнга тогтвортой үргэлжлэх ёстой бөгөөд энэхүү агуулгыг шашин буюу ертөнцийг үзэх үзлийн нийгэмлэгээс тодорхойлно. Эдгээр нийгэмлэг нь шашин, ертөнцийг үзэх үзлийн талаар хичээлийг явуулахдаа сургуулийн бусад хичээлд тавигдах шаардлага, журмын дагуу зохион байгуулна. Хүүхдийг асран хамгаалах бүхий этгээд нь 14 насанд бүрэн хүрээгүй хүүхдийг энэ хичээлд суулгах эсэхийг шийдвэрлэнэ. Сургуулиас хөтөлбөрийн дагуу бүртгүүлсэн хүүхдүүдэд долоо хоногт хоёр удаа сургуулийн хичээлийн хөтөлбөрт цагийг оруулж, анги танхимыг бэлтгэнэ. Шашны хичээлд суухаар бүртгүүлээгүй хүүхдүүд нөхөж өөр хичээлд суух үүрэггүй.

Тус хуулийн 46 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар сурагчийг хичээлд оролцох, сургуулийн арга хэмжээнд оролцохоос бүхэлд нь буюу хэсэгчлэн чөлөөлж болох хүндэтгэн үзэх үндэслэлийг зохицуулсан байдаг.

3. Сургалтын ерөнхий хөтөлбөр

Сургалтын ерөнхий хөтөлбөрт “ёс зүй” хичээлийн 2 дахь шатлалыг 7-10 дугаар ангид заахаар Берлин муж улсын сенатын Боловсрол, залуучууд, спорт хариуцсан захиргаанаас 2006/2007 оны хичээлийн жилд зохицуулжээ. Ёс зүйн хичээл нь шашны болон ертөнцийг үзэх үзлийн хувьд төвийг сахисан агуулгын хүрээнд хичээллэнэ. Энэ хичээлийн хүрээнд тодорхой тогтсон номлол сургаалыг өрөөсгөл байдлаар тайлбарлахыг хориглоно. Хичээлийн үнэт зүйлийн хувьд бол төвийг сахисан агуулгатай байх албагүй. Залуучууд хүн төрөлхтөний оюун ухаан, ардчилал, эрх чөлөөнд дасгалжиж, төлөвшин хүмүүжих ёстой. Үүнд толеранц, өөр бусдын итгэл үнэмшлийг хүндэтгэх, амьдралын жам ёсны суурь нөхцөлийг хамгаалах, хариуцлага хүлээх, хүчирхийллийн арга замаар зөрчилдөөнийг шийдэхээс ангид байж сурах зэрэг нь хамаарна. Бодит байдал дээр зөрчилдөөнтэй байдаг асуудлыг хичээл дээр ч зөрчилдөөнтэй байдлаар тайлбарлах нь зүйтэй. Хичээл заах багш тухайн сэдвээр асуулт, үнэт зүйлийн зөрчилдөөний тухай тодорхой байр суурийг илэрхийлэхдээ үндэслэл бүхий тайлбарлах ёстой бөгөөд сурагчдад зүй бусаар нөлөөлөхгүй байх үүрэг хүлээнэ.

Сургалтын ерөнхий хөтөлбөрийн 5 дахь бүлэгт “Ёс зүйн” хичээлийн хүрээнд үзэх зургаан сэдвийг дараах байдлаар жагсаасан байна. Үүнд: “Адилсал, нөхөрлөл ба аз жаргал”, “Эрх чөлөө”, “Хариуцлага ба хамтач байдал”, “Ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл ба толеранц”, “Тэгш эрх, эрх ба шударга ёс”, “Гэм буруу, үүрэг, ухамсар”, “Мэдлэг, найдвар ба итгэл үнэмшил” гэжээ. Сэдэв бүрийн хүрээнд гурван өөр төрлийн өнцгөөс буюу хувийн, нийгмийн, түүнчлэн үзэл санааны түүхэн төлөвийг авч үзэхээр сургалтын ерөнхий хөтөлбөрт тусгажээ. Тухайлбал, эхний сэдвийн хүрээнд Аристотелесийн найзын гурван төрөл, ахан дүүсийн үзэл санаа, үзэл санааны нийгэмлэг гэсэн дэд сэдвийг хөндөнө. Хоёр дахь сэдвийн хүрээнд ухамсартай байх, хариуцлага хүлээх ёс зүй, бие даасан байдал, эрх зүйн чадамж гэсэн дэд сэдвийг авч үзнэ. Гурав дахь сэдвийн хүрээнд социал дарвинизм, соёлын онцлог, дэлхийн шашны түүхэнд ёс зүйн талаарх “дайснаа ч хайрлах” хэлбэрүүд, толоренц, платоны нөхөрлөл гэх сэдвийг хөндөх бол дөрөв дэх сэдвийн хүрээнд тэгш байдал, тэгш бус байдлын тухайд антропологийн буюу ёс зүйн үндсэн суурь, эрх зүй ба ёс суртахуун, шударга ёсны онол ба зарчмыг тайлбарлана. Тав дахь сэдвийн хүрээнд христийн сургаал ба нүгэл, хамтын гэм буруу, негатив болон позитив үүрэг, ухамсрын эх үндэс болон мэдлэг “тэр”, “би”, болон “надаас дээгүүр” (хувь хүн шууд хянаж захирдаггүй ойлголт) зэрэг ойлголтыг авч үзнэ. Хамгийн сүүлийн сэдвийн хүрээнд плато, сэргэн мандалт, эмпиризм, рационализм, утопи, шинжлэх ухааны уран зөгнөл, романтик, өсөлт ба хөгжилт, мухар сүсэг ба итгэл үнэмшил, шашин ба номлол, монотэйзм ба политэйзм, шашин, сүм ба төр, шашингүйн үзэл, ламын наманчлал зөвлөгөө ба шашны нийгэмлэг зэрэг сэдвийг заахаар тусгасан байна.

4. Европын хүний эрхийн шүүхэд гаргасан гомдол

Гомдол гаргагчаас хүүхдийг ёс зүйн хичээлд заавал суухаар үүрэгжүүлсэн нь төрөөс төвийг сахих үүргийг зөрчиж байна гэж үндэслэлдээ дурдаж, энэхүү хичээлийг үзсэнээр өөрийн шашны итгэл үнэмшилтэй нийцэхгүй өөр үзэл бодлыг хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ. Мөн Холбооны үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт ба Европын хүний эрхийн конвенцын⁴ 9 дүгээр зүйлийн 2 дахь заалтад заасан нийтийн (төрийн) үүрэг хүлээгч нь сургаж хүмүүжүүлэх үүргээ зөрчиж байна гэж тайлбарласан байна. Ийнхүү гомдол гаргагч Европын хүний эрхийн конвенцын 9 дүгээр зүйл, 1 дүгээр протоколын 2 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрт тулгуурлаж гомдлоо гаргасан байна.

⁴ https://www.echr.coe.int/documents/convention_eng.pdf

IV. ГОМДОЛД ХАМААРАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Европын хүний эрхийн конвенцын 9 дүгээр зүйл.

“(1) Хүн бүр үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтэх эрх чөлөөг эдлэх эрхтэй; энэхүү эрх нь шашин, ертөнцийг үзэх итгэл үнэмшлээ өөрчлөх эрх чөлөө, ганцаараа болон бусадтай хамт нийтийн болон хувийн байдлаар шашин шүтлэг, ертөнцийг үзэх итгэл үнэмшлээ илэрхийлж сүм хийдээр үйлчлүүлэх, шүтлэгийн зан заншил, зан үйлийг хэрэгжүүлэх, бусдад зааж сургах эрх чөлөөг агуулна.

(2) Шашин шүтэх, ертөнцийг үзэх итгэл үнэмшлийг сонгох эрх чөлөөг ардчилсан нийгэмд нийтийн аюулгүй байдал, нийтийн дэг журам, нийтийн эрүүл мэнд, эсхүл нийтийн ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.”

Европын хүний эрхийн конвенцын 1 дүгээр протоколын 2 дугаар зүйл:

“Хэн ч сурч боловсрох эрхийг хязгаарлаж болохгүй. Төрөөс боловсрол олгох, сурган хүмүүжүүлэх чиглэлээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ эцэг, эхчүүдээс өөрсдийн хувийн шашин, ертөнцийг үзэх итгэл үнэмшилд нийцүүлэн хүмүүжүүлж, сургах эрхийг хүндэтгэх ёстой.”

Гомдол гаргагч гомдолоо дараах үндэслэлүүдийг дурджээ. Тухайлбал: ёс зүйн хичээлийг заавал үзэх хичээлд оруулсанаар төрийн төвийг сахих үүргээ зөрчиж, хичээлийн агуулгад “ёс зүй” ба “суурь үнэт зүйл” гэх ойлголтыг оруулж, хичээл зааснаар төрөөс сурагчдад үлэмж нөлөөлж байна. Ёс зүйн хичээлээр зааж буй агуулга нь шашны хувийн итгэл үнэмшилтэй нийцэхгүй байна. Энэ хичээлээр түгээж буй ертөнцийг үзэх үзэл номлол нь үндсэндээ христийн ёс зүйтэй олон салбарын асуудлаар зөрчилдөж байна. Энэ хичээл нь бурхан оршин байдгийг үгүйсгэж, шашингүйн үзэл, атейст үзэл, шашинд дайсагнасан хандлагыг Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт тайлбарласанчлан хүмүүнлэг үзлийг төлөвшүүлэх нэрийн доор дэлгэрүүлж байна. Шашны нийгэмлэгийн төлөөлөгчдийг оролцуулалгүйгээр боловсруулсан сургалтын ерөнхий хөтөлбөрт лалын шашинтай харьцуулахад шашны дийлэнх хувийг эзэлдэг христийн шашны талаар бага цаг, хязгаарлагдмал хүрээнд оруулсан байна гэжээ.

Мөн гомдол гаргагчийн зүгээс ёс зүйн хичээлийн дэд сэдэв болгон зааж буй шашингүйн үзэлийн талаарх хичээлд сурагчдыг идэвхитэй оролцохыг шаардаж байгаа нь сургуулийн танхимын хананд загалмай зүүх нь Үндсэн хуульд харшилна гэж Холбооны Үндсэн хуулийн шүүхээс өмнө шийдвэрлэсэн хэрэгээс ч илүү урт хугацаандаа ихээхэн нөлөө үзүүлж, шашны эрх чөлөөнд харшаар нөлөөлөх боломжтой. Ингэснээр Холбооны Үндсэн хуулийн шүүхийн

7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Европын хүний эрхийн конвенцын 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчиж байгаа бөгөөд үүнийг зөвтгөх хууль зүйн үндэслэл байхгүй. Энэхүү хичээлээс сурагчийг чөлөөлөгдөх боломж олговол сурагчийг итгэл үнэмшлийн эсрэг хууль бусаар албадах шаардлагагүй болно гэдгийг онцолжээ.

Холбооны Үндсэн хуулийн шүүхээс санал болгосон эвлэрэх нөхцөлийг гомдол гаргагчид хүлээн аваагүй бөгөөд дээд шүүхийн шийдвэрийг маргаантай гэж үзсэн. Евангали болон католик сүмийн хэвлэлд 2006 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр мэдээлсэнээр шашны хичээлд суудаг сурагчдын тоо ёс зүйн хичээлийг оруулж эхлэснээс хойш 25 хувиар буурсан байна гэжээ.

Европын хүний эрхийн шүүхээс уг гомдлыг үндэсний шүүхээр хянан шийдвэрлэсэн бөгөөд Холбооны Үндсэн хуулийн шүүх дүгнэхдээ Захиргааны хэргийн шүүх нь эрх зүйн үндэслэлийг өргөн хүрээнд авч үнэлсэн тул бодит нөхцөл байдлыг тодруулах, буюу үндсэн маргааны асуудлын талаар өөр дүгнэлт нэмж хийх шаардлагагүй гэж үзсэн болохыг тэмдэглэж байна.

Европын хүний эрхийн шүүхээс гомдол гаргагч нарын үндэслэлийг Европын хүний эрхийн конвенцын 1 дүгээр протоколын 2 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрийн зохицуулалтад нийцэх эсэхийг шалгах ёстой. Үүний тулд тус конвенцын 8, 9, 10 дугаар зүйлтэй нийцэж байгаа эсэхийг шалгаж асуудлыг уялдаатай тайлбарлах ёстой бөгөөд энэ талаар сүүлд шийдвэрлэсэн хоёр хэрэгт дээрх конвенцын зүйлийн агуулгын талаар тоймлосон байдаг. (Лалын шашны асуудлаар болон Норвеги улсын иргэний гаргасан гомдлын талаар шийдвэрлэсэн гомдол)⁵. Энэ үүднээс сургалтын хөтөлбөрийн агуулга, нэр томьёо нь конвенцтой нийцсэн байх ёстой бөгөөд сургалтын төлөвлөгөөнд тусгасан мэдээлэл, мэдлэг нь олон ургальч үзэлд суурилсан, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх байдлаар мэдлэгийг дамжуулах, зохисгүй байдлаас ангид, тэнцвэртэй уур амьсгалыг бүрдүүлэх байдлаар боловсруулсан байх нь зүйтэй. Төрөөс ялангуяа хүүхдээ хүмүүжүүлэх, сургах үндсэн үүрэг хүлээдэг эцэг эхчүүдийн шашин, ертөнцийг үзэх итгэл, үнэмшлийг үл тоомсорлох буюу суртал, ухуулгын зорилгоор хичээлийн агуулгыг заахыг хориглоно. Энэ бол давж болохгүй хатуу хязгаар юм. Европын хүний эрхийн шүүх ёс зүйн хичээл төвийг сахихгүй, шашингүйн үзлийг тайлбарлах нь шашны итгэл үнэмшилтэй зөрчилдөнө гэсэн гомдол гаргагчийн үндэслэлийг хамгийн гол үндэслэл болгожээ. Берлин муж улсын Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 12 дугаар зүйл 6 дахь хэсэгт зааснаар ёс зүйн хичээл нь гимназийн сурагчдад өөрсдийн ёс зүй, урлаг, шашны болон ертөнцийг үзэх үзлээс үл хамааран хувийн амьдрал, нийгмийн хамтын амьдралыг дэмжих,

⁵ Zengin ./ Turkey (Nr. 1448/04, CEDH 2007-XI), Folgerow u.a. ./ Norway [GK], Nr. 15472/02, Rdnr. 84, CEDH 2007-VIII)

соёл хоорондын хэлэлцүүлэг хийх, нийгмийн харилцааны ур чадварыг олгох, ёс зүйн үүднээс шийдвэр гаргах чадамжийг олгоход чиглэнэ. Чухам энэ зорилгоор дээрх хичээлийн хүрээнд философи, шашин, ертөнцийг үзэх үзлийн ёс зүй, олон янзын соёл ба амьдралын хэв маягийн талаар, түүнчлэн дэлхийн томоохон шашнуудын талаарх мэдлэгийг дамжуулах юм. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн дүгнэснээр үзэл бодол, илэрхийллийн олон янз байдалд нээлттэй хандах нь эрх чөлөөт, ардчилсан улсын нийтийн сургуулийн үндсэн нэг нөхцөл шалгуур байна. Ингэснээр нийгэмд оршин буй олон янзын ертөнцийг үзэх үзэл, шашны тухайд зэрэгцээ сүүдрийн нийгэм үүсэхээс сэргийлэх, цөөнхийг дэмжих, ялгаварлахын эсрэг сэдэл болно. Суралцагчдад толеранцтай байх, хэлэлцүүлэг хийх ур чадварыг эзэмшүүлэх нь ардчилсан процесст оролцох үндсэн суурь нөхцөл билээ. Ингэж байж олон янзын шүтлэгийн итгэл үнэмшил, ертөнцийг үзэх үзлийн тусгал болдог нийгэмд харилцан хүндэтгэлтэйгээр хамтдаа амьдарч чадах юм. Европын хүний эрхийн шүүхийн дүгнэснээр Европын хүний эрхийн конвенцын 1 дүгээр протоколын 2 дахь заалтад заасан агуулга, олон ургальч байдлын үндсэн зарчим, болон Европын зөвлөлийн парламентын хуралдааны зөвлөмжид тусгасан агуулгад энэхүү ёс зүйн хичээлийн зорилго бүрэн нийцэж байна гэжээ.

Ийнхүү нөхцөл байдлыг дүгнэхдээ Европын хүний эрхийн конвенцын 1 дүгээр протоколын 2 дахь заалтыг зөрчсөн гэж тус шүүхээс өмнө шийдвэрлэж байсан Европын хүний эрхийн конвенцын ижил заалтыг хэрэглэсэн Зэнгин, Фолгэрэ (Zengin, Folgerш) нарын шийдвэрийн үндэслэлийг авч үзсэн байна. Зэнгин, Фолгэрэ нарын тохиолдолд гомдол гаргагчдын нэг нь олонхийн шүтдэг шашнаас ялгаатай лалын шашинтай, харин нэг нь огт шашингүйн үзэлтэй атал шашны хичээлд албадан суулгасан байсан тул дээрх гомдол гаргагчаас эрх зүйн өөр үндэслэл бүхий нөхцөл байдал байсан.

Берлин муж улсын сургуулийн ёс зүйн хичээлийн тухайд төвийг сахисан агуулга бүхий хичээлд суух тухай асуудал байх бөгөөд ямар нэг тодорхой шашин, итгэл үнэмшилд илүү жин, давуу тал өгөөгүй, харин нийгмийн ерөнхий хамтын үнэт зүйлсийн суурийг дамжуулах, өөр итгэл үнэмшилтэй бусад хүмүүст нээлттэй байх чадварыг төлөвшүүлэхэд чиглэжээ.

Европын хүний эрхийн шүүх шийдвэртээ ХБНГУ-ын Холбооны үндсэн хуулийн шүүхийн тайлбарт тулгуурлан хичээлийн ерөнхий хөтөлбөрийн зохицуулалтад ёс зүйн тодорхой асуудлын талаар тус хичээлийг зааж байгаа багш байр сууриа илэрхийлэхдээ бусад сурагчдын итгэл үнэмшлийг төлөөлөхгүй байх, сурагчдад зүй бусаар нөлөөлж болохгүй болохыг дурджээ. 2006-2007 оны хичээлийн жилд сургуульд заасан энэхүү хичээлийн хүрээнд шашны итгэл үнэмшлийг үл тоомсорлосон, эсхүл суртал, ухуулгын шинжтэй мэдлэгийг

түгээсэн тухай гомдол гаргагч гомдолдоо дурдаагүй. Мөн Захиргааны хэргийн шүүхээс энэхүү хичээлийг заах процесс, хичээлийг бодитоор заах асуудал нь маргааны асуудал биш гэдгийг тодорхойлсон байна.

Гомдол гаргагчийн гомдолд дурдсан “Христийн шашны уламжлалтай Герман улс хичээлийн хөтөлбөртөө христийн шашны сэдвийг хангалтай оруулаагүй, Европын хүний эрхийн конвенцод нэгдэн орсон орнууд хичээлийн хөтөлбөр боловсруулахдаа өөрийн уламжлал, түүхийг харгалзаж тодорхой нэг шашны мэдлэг олгох, өргөн хүрээний мэдлэгийн агуулгыг багтааж болдог” гэх асуудалд сургуулийн хичээлийн хөтөлбөрийн цаад агуулга нь олон ургальч үзэл ба бодит байдалд нийцсэн байх үндсэн зарчимтай зөрчилдөхгүй бөгөөд тодорхой суртал, ухуулга хийгээгүй тул тус конвенцод нийцэж байна гэжээ.

Берлин муж улсын сургуулиуд нь итгэл үнэмшлийн хувьд төвийг сахисан агуулгатай ёс зүйн хичээлийн хүрээнд тодорхой шүтлэгийн урсгал, итгэл үнэмшлийг багтаасан боловсрол олгохыг дэмжиж байгаа нь Европын хүний эрхийн конвенцтой зөрчилдөхгүй юм. Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Берлин муж улсад байгаа шашны урсгалууд, бодит нөхцөл байдлын онцлогийг тусгасан сонголт болохыг баталгаажуулжээ.

Берлин муж улсын хууль тогтоогчийн үнэлсэнээр шашин, ертөнцийг үзэх үзлээр нь ялгаж салангид байдлаар тусгаарлаж хичээл заахаас илүү нийт хамт олонд дундын хичээл заах нь үнэт зүйлийг дамжуулах, тайлбарлах зорилгод үр дүнтэйгээр хүрэх боломжтой юм. Энэ асуудал нь төрийн өөрийн шийдвэр гаргах сонгох боломжийн хүрээнд хамаарах асуудал бөгөөд шүүхээс шалгах ёстой үндсэн зарчим, эрх зүйн үндэслэлд хамаарахгүй юм.

Ёс зүйн хичээлийг өөрийнх нь хувийн шашны итгэл үнэмшилтэй зөрчилдөж байна гэсэн гомдол гаргагчийн үндэслэлийн тухайд Европын хүний эрхийн шүүхээс Берлин муж улсын Ерөнхий боловсролын сургуулийн тухай хууль эсхүл ерөнхий сургалтын хөтөлбөр аль алинд ч яг тодорхой ганц шашны урсгалыг, ялангуяа христийн шашинг сонгож илүүд үздэггүй, эсхүл аль нэг шашныг бүр үзэхгүй, орхидоггүй, эсхүл ямар нэг шашны урсгалын төлөө тэмцэхийг уриалдаггүй болохыг дүгнэсэн байна.

Энэхүү уялдаа холбооны дунд тухайн “ёс зүйн” хичээлийн хөтөлбөр нь ёс зүйн олон сэдвийг авч үздэг бөгөөд “хажуу хүнийг хайрлах шашны зарчим”, “дайсныг хайрлах”, христийн нүглийн тухай сургааль ба бусад шашны ерөнхий монотейзм, политэйзм, сүм ба төр, шашны нийгэмлэг гэх мэт агуулгыг хамардаг болохыг шүүхээс тодорхойлсон байна. Мөн Берлин муж улсын Ерөнхий боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар хичээлийн сэдвүүдийг шашны болон ертөнцийг үзэх үзлийн тодорхой нийгэмлэгүүдтэй хамтран заахаар тусгажээ. Гомдол гаргагч нарын

дурдсан ёс зүйн хичээлд христийн уламжлалтай зөрчилдөх шүүмжлэлт санаа, таамаглалыг дэлгэрүүлж байна гэсэн үндэслэлийн тухайд конвенцод зааснаар хувь хүний өөрт нь нийцэхгүй бусад итгэл үнэмшил, үзэл бодолтой нүүр тулгарч чадахгүй байхыг эрхийн зөрчил гэж үзэх боломжгүй.

Гомдол гаргагч нь евангалийн шашны тухай хичээлд хүүхдээ оролцуулахаар сонгож болох бөгөөд энэ талаар хүүхдэдээ зөвлөж, тайлбарлах нь асран хүмүүжүүлэгчийн хувьд хэрэгжүүлэх жам ёсны үүрэг бөгөөд хүүхэд өөрийн шашны итгэл үнэмшлийн чиг баримжааг хөгжүүлж болно.

Европын хүний эрхийн шүүхээс гомдол гаргагч нарын гомдлын нэг үндэслэл болох шашны хичээлийн заах нөхцөлийг улам хүндрүүлж, суралцагчдын тоог цөөлсөн гэх асуудлыг үндэсний шүүхээс шийдвэрлэхдээ нотлогдоогүй болохыг тэмдэглэжээ. Энэхүү үндэслэлийг нотлоход зөвхөн евангали ба католик сүмийн хэвлэлийн мэдээнд тулгуурлах нь нотлох баримтын хувьд хангалтгүй юм. Европын хүний эрхийн шүүх хэргийн үйл баримтын хувьд тухайн улсын захиргааны байгууллагаас ёс зүйн заавал үзэх хичээлийг хуульчилсан нь өөрсдийн эрх хэмжээний хүрээнд сонголт хийж, шийдвэр гаргах эрх хэмжээний хүрээг хэтрүүлээгүй бөгөөд төрөөс хүүхдэд сурч боловсрох боломж олгох үүргийг хариуцах Европын хүний эрхийн конвенцын 1 дүгээр протоколын 2 дахь заалтыг зөрчөөгүй.⁶ гэсэн байна.

Түүнчлэн Берлин муж улсын захиргааны байгууллагууд ёс зүйн хичээлийн агуулгыг ерөнхий хөтөлбөрийн дагуу тодорхойлох боломжтой гэж дүгнэжээ. Тухайн улсын өөр нэг муж улс тус асуудлыг өөрөөр журамлаж зохицуулсан байх нь маргааны нөхцөл байдлыг өөрчлөхгүй ба энэхүү шийдвэрийг өөрчлөх үндэслэл болохгүй. Мөн Конвенцын 9 дүгээр заалтын хүрээнд тусгай асуултыг авч үзэх шаардлагагүй гэжээ. Ийнхүү дээрх үндэслэлүүдээр гомдол гаргагчийн гомдлыг үндэслэлгүй хэмээн Европын хүний эрхийн конвенцын 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэг ба 4 дэх хэсэгт заасны дагуу шүүхээс гомдлыг хэрэгсэхгүй болгосон байна.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

⁶ (Costello-Roberts ./ Vereinigtes Кцnigreich, 25. Мдрz1993, Rdnr. 27, Serie A, Bd. 247-C, und Martins Casimiro und Cerveira Ferreira ./ Luxemburg (Entsch.), Nr. 44888/98,27. April 1999).



Н.ОДОНТУУЛ

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны
шүүхийн Ерөнхий шүүгч, докторант

ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН БАЙДАЛ

A BRIEF ACCOUNT OF INTERNATIONAL LEGAL NORMS CONCERNING COMPULSORY MEDICAL MEASURES

Хураангуй: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл болохын хувьд хүний эрхийг хязгаарладаг төрийн албадлагын өвөрмөц төрөл юм. Уг арга хэмжээг гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн өвчтэй эсхүл оюун ухааны хомсдолтой хүнд шүүхийн шийдвэрээр хэрэглэдэг онцлогоос шалтгаалан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад, эсхүл оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүний эрхийн онцлог зарчим, хэм хэмжээ шаардагддаг. Энэ нөхцөл байдлыг харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллага болон бүс нутгийн байгууллагуудаас энэ харилцааг зохицуулсан баримт бичгийг батлан мөрдүүлж, дотоодын хууль тогтоомждоо тусгахыг гишүүн орнуудад уриалж байгаа билээ. Энэхүү өгүүлэлд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал, Сэтгэцийн эмгэгтэй

хүнийг хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх тухай зарчмууд болон Европын Зөвлөлөөс батлан гаргасан Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах зөвлөмжийг харьцуулан судалсан болно.

Abstract: *Involuntary treatment, as a criminal penalty, is a peculiar form of state coercions that restrict human rights. As this measure is specific for being used through verdicts of judiciary on mental illness or mental disability, specific human rights norms are required during the criminal proceedings and implementation of involuntary mental health treatment measure. Taking account of this circumstance, the United Nations and regional organisations have adopted instruments that regulate this relation and urged the countries to integrate its norms into their domestic laws. This article makes comparative analysis into International Covenant on Civil and Political Rights, Declaration on the Rights of Mentally Retarded Persons, Principles for the Protection of Persons with Mental Illness and the Improvement of Mental Health Care, and Recommendation Rec. (2004)10 of the Committee of Ministers to Member States concerning the protection of the human rights and dignity of persons with mental disorder and its explanatory memorandum Strasbourg: Council of Europe.*

Түлхүүр үг: Хүний эрх, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, Оюуны хоцрогдолтой хүн, хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн эмгэг.

Keywords: *Human rights, Involuntary mental health treatment, Mentally retarded persons, disability, mental illness*

I. ОРШИЛ

Сэтгэцийн хувьд биеэ хянах чадваргүй хүний эрх зүйн байдал нь хууль зүй, ёс зүйн нарийн төвөгтэй асуудал бөгөөд дэлхийн улс орнууд энэ төрлийн судлагдахуунд сүүлийн зуу гаруй жил дотооддоо болон олон улсын түвшинд нэлээдгүй судалгаа хийж, тодорхой үр дүнд хүрч, чиг хандлагыг тодорхойлсоор иржээ. Тухайлбал, 19-20 дугаар зуунуудад дэлхий нийтэд улс орон бүр өөрсдийн соёл, ёс заншил, үндэстний оюун сэтгэлгээ (менталитет) зэрэгт тулгуурлан албадан эмчилгээний зохистой арга замыг эрэлхийлсээр ирсэн ба энэ нь эцсийн дүнд хүний эрх, олон нийтийн аюулгүй байдал, сэтгэцийн хувьд биеэ хянах чадваргүй этгээдийг эмчлэх гэсэн гурван тулгуур ойлголтын огтлолцол болсон юм¹.

¹ Hans Joachim Salize, Harald Dressing, Monika Peitz, Compulsory Admission and Involuntary Treatment of Mentally ill Patients – Legislation and Practice in EU-Member States (Final report), Mannheim, Germany, 2, 2002.
https://ec.europa.eu/health/ph_projects/2000/promotion/fp_promotion_2000_frep_08_en.pdf

1950-1960-аад онуудад Европт хүний эрхийн хөдөлгөөнүүд өрнөхийн сацуу сэтгэцийн эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц, дэвшил гарч байх ахуйд сэтгэцийн хувьд эрүүл бус хүнийг эмчлэх хууль, эрх зүйн орчин шинэ түвшинд гарсан гэж үзэх үндэслэлтэй. Гэсэн хэдий ч зарим улс орнуудад дээрх хүмүүсийг эмчлэх гэхээс илүүтэй эсрэгээр нийгмийг тэднээс хамгаалах, дахин хохирол учруулахгүй байх тал дээр анхаарч, нийгэмд буй аюултай цөөнх гэх ойлголт давамгайлж байсан тухай тэмдэглэсэн нь бий.

Энэ ч утгаар орчин үед эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй дэлхийн улс орнуудын туршлага харилцан адилгүй байх ба албадан эмчилгээнд холбогдох албан ёсны тоо баримтыг улс орнууд олон улсын хэмжээнд тэр бүр хэвлэн нийтэлдэггүй, нийтэлсэн ч энэ нь сонгон авсан тодорхой орныг хамардаг зэрэг асуудалд Европын Зөвлөлийн Ассамблей шүүмжлэлтэй хандаж байна².

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн зохицуулалт олон улсын хэмжээнд тодорхой баримт бичгүүдэд тусгалаа олж, энэ нь тухайлсан улс орны эрх зүйн хэм хэмжээнд зарчим, үзэл баримтлалын жишиг болохоос гадна шууд тусган хэрэглэж болох загвар хэм хэмжээ гэж үзэж болох юм. Нөгөөтээгүүр, энэ нь тодорхой процессын хэм хэмжээг агуулахаас гадна нэр томъёоны тайлбар болох тул улсуудын түвшинд суурь эрхийн хамгаалалт болдгоороо дотоодын органик хуулиудаас ялгаатай.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, түүнийг хэрэглэх зөвлөмж, анхаарах асуудлын талаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Зөвлөлөөс батлан гаргасан эрх зүйн баримт бичигт тодорхойлон тусгаж, улс орнууд жишиг хэм хэмжээ болгож, эсхүл заавал дагаж мөрдөх шинжтэйгээр хэрэглэж байна.

Энэхүү өгүүлэлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хүний эрхийн асуудал болохыг тодорхойлж, уг арга хэмжээг хэрэглэх үндэслэл, хэрэг хариуцах чадваргүй болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийг хамгаалах зарчим, хэм хэмжээг олон улсын болон бүс нутгийн эрх зүйн баримт бичигт хэрхэн тусгагдсан байдалд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

II. ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ОЙЛГОЛТ

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлагын хүрээнд шүүхээс хэрэглэдэг Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Энэ арга хэмжээг дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэглэдэг бөгөөд Монгол Улсын

² Мөн тэнд, 3.

1926, 1929, 1942 оны Эрүүгийн хуулиудад гагцхүү эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох талаас тодорхойлж ирсэн бол 1961 оны Эрүүгийн хуульд ухаан санаа нь эрүүл бус этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй, мөн эмнэлгийн чанартай арга хэмжээг хэрэглэх үндэслэл, арга, өөрчлөх, зогсоох, хэргийг сэргээх үндэслэл, хэргийн хугацаа тоолох талаар тодорхой бүлэг, зүйл, хэсэгт тусгайлан авч үзсэн нь хүний эрхийг хангаж, хамгаалахад олон талын ач холбогдолтой зохицуулалт болсон. Өөрөөр хэлбэл, ял ба албадлагын арга хэмжээг тусгайлан салгаж, эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл, хэдийд хэрхэн аль үе шатанд хэрэглэх талаар оновчтой тодорхойлох боломжтой болсон³. Харин 2002 оны Эрүүгийн хуульд энэ арга хэмжээг эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнд хамааруулаад энэ арга хэмжээний ойлголт төрөл, түүнийг оногдуулах, өөрчлөх зогсоох, хугацааг тоолох журмыг нарийвчлан хуульчилсан.

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”⁴, “Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно.”⁵ гэж тус тус заасан. Мөн энэ хуульд гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд ял оногдуулахгүйгээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр⁶, мөн гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүх түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний дараа ял оногдуулахаар⁷ тус тус хуульчилсан. Түүнчлэн Эрүүгийн хуульд⁸ зааснаар согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн *согтуурах, мансуурах донтох эмгэгтэй* болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

III. НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГААС БАТЛАН ГАРГАСАН БАРИМТ БИЧИГТ ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭГ ТУСГАСАН БАЙДАЛ

НҮБ-аас нийт улс түмэнд хандаж гаргасан эрх зүйн баримт бичгүүдийн дотор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт онцгой байр суурийг эзэлдэг. Яагаад гэвэл чухам энэ баримт бичгүүд нь хүний эрхийн

³ С.Жанцан “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол” 2 боть, УБ, 2014

⁴ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

⁵ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

⁶ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

⁷ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

⁸ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

тухай олон улсын билльд багтдаг бөгөөд орчин үеийн хүн төвтэй нийгмийн хөгжлийн чиг баримжааг илэрхийлсэн эрх зүйн үндсэн эх сурвалж юм.

НҮБ-аас 1966 оны 12 дугаар сарын 16-нд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй”⁹ гэж заажээ. Энэхүү пакт 1976 оны 3 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсоноор түүнд нэгдэн орсон эсвэл соёрхон баталсан улс болгоны хувьд эмнэлгийн туршилтад оруулахгүй байхыг хориглосон хэм хэмжээг дотоодынхоо хуулийн нэгэн адил заавал биелүүлэх үүрэг хүлээх болсон байна.

НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад дээрх хэм хэмжээг анх удаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн явдал нь гэмт хэрэг хэрэг үйлдсэн хүнийг шүүхийн шийдвэргүйгээр албадан эмчлэх, эмнэлгийн байгууллагад байлгах явдлыг халсан төдийгүй уг үзэл санааг нэг улсын хэмжээнээс хальж олон улсын хэмжээнд албан ёсоор хүлээн зөвшөөрөх анхны үе шат болсон гэж дүгнэж болно.

НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт нь дэлхий нийтэд хамааралтай эрх зүйн баримт бичгийн ангилалд багтах ба эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, сэтгэцийн өөрчлөлттэй болон хэрэг хариуцах чадваргүй хүнтэй харьцах зарчим нь НҮБ-аас батлан гаргасан бусад эрх зүйн баримт бичгүүдэд ч тусгагдаж тэр чанараараа олон улсын хэмжээнд ч чухалчлан анхаарагдах боллоо. Үүний жишээнд Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглал (1971 он), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал (1975 он), Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх тухай зарчмууд, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль: 10 зарчмууд зэргийг нэрлэж болно.

а) Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглал (1971 он)

Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглал нь 1971 оны 12 дугаар сарын 20-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээр батлагдсан бөгөөд оюуны хувьд хоцрогдолтой хүний эрхийг хамгаалах, тэдний амьдрах орчныг зохистой байлгах, хөдөлмөрийн чадварыг нь нөхөн сэргээх зорилготой байна.

Тунхагт оюуны хоцрогдолтой хүн бусад хүний эдлэх эрхийг эрх тэгш эдлэх эрхтэй бөгөөд чанартай эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, боловсрох,

⁹ Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

биеийн болоод оюуны чадвараа хамгийн дээд түвшиндээ хүргэх зорилгоор хөдөлмөрийн дадал олж авах эрхтэйг тэмдэглэсэн. Түүнчлэн, дээрх хүмүүс материаллаг хангамжаар хангагдах, таатай нөхцөлд амьдрах эрхтэйгээс гадна зөвхөн төрөөс үзүүлэх тусламж, дэмжлэгээр амьдрах бус өөрийн хөдөлмөрийн үр шимийг хүртэх, ашиг олох замаар орлогоо нэмэгдүүлэх боломжтойг дурдсан байна. Нөгөөтээгүүр, оюуны хоцрогдолтой хүн өөрийн төрөл, садангийн хүн, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтад байж, тэдгээр нь ийнхүү асран хамгаалж байгаа тохиолдолд төрөөс тодорхой тэтгэмж хүртэх ёстой аж. Хэрэв оюуны хоцрогдолтой хүний оршин байгаа газрыг өөрчлөх, хэвтэн эмчлүүлж байгаа газрыг сонгох тохиолдолд тэдгээр нь түүний ердийн амьдралын нөхцөлөөс дордохоор байж болохгүй бөгөөд асаргаа, эмчилгээний нөхцөл нь ч бусад хүний адилаар тодорхой стандартад нийцсэн, таатай байх боломжийг бүрдүүлэхийн чухлыг дурджээ.

Мөн оюуны хоцрогдолтой хүнтэй хүнлэг бус харьцах, тэднийг нийгмээс тусгаарлах, хортой зүйлд ашиглах нөхцөл бүрдэхээс улс орнууд сэргийлэх, энэ тал дээр тодорхой үндэсний хэмжээний арга хэмжээ авах шаардлагатайгаас гадна гэмт хэрэгт холбогдох, шүүхэд эрхээ хамгаалуулах тохиолдолд өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхээр нь хангах, шүүх, төрийн байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдол гаргах эрхтэй байх зэрэг эрхүүд нь салшгүй эрх болохыг тунхагласан байна.

Дээрх тунхаглалын 7 дугаар зүйлд “Хэрэв оюуны хоцрогдолтой хүн өөрт олгогдсон эрхээ бүрэн дүүрэн эдлэх чадамжгүй, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тодорхой тохиолдолд түүний эрхийг хязгаарлах шаардлагатай бол энэ нь зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдахаас гадна эмнэлгийн мэргэжилтэн, мэргэшсэн шинжээчийн дүгнэлтэд үндэслэсэн байвал зохино. Оюуны хоцрогдолтой хүний сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүний өөрчлөлтөд тогтмол үзлэг, шинжилгээ хийх ба тухайн хүн аливаа байгууллагын шийдвэрт гомдол гаргах эрхээр хангагдана.” гэж заажээ¹⁰.

Дээрх тунхаглал нь гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээдүүдэд авах арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, ерөнхий зарчмыг тодотгосон бөгөөд тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэнийг шүүхийн журмаар тогтоохоос гадна сэтгэцийн эрүүл мэндийн улмаас эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай эсэхийг зайлшгүй мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоох, тухайн дүгнэлт нь тодорхой хугацааны давтамжтай хийгдэх, дээрх хүмүүсийн эрхийг хуульд заасны дагуу хязгаарлах, асаргаа, эмчилгээний орчныг нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөх тохиолдолд тэр нь бусад этгээдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанараас дордож

¹⁰ Организация Объединённых Наций, Генеральная Ассамблея, Декларация о правах умственно отсталых лиц, 1971.

https://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/retarded.shtml

болохгүй, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах зорилгоор хууль зүйн туслалцааг төрөөс үзүүлэх, ямар ч тохиолдолд эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр эцсийнх байж болохгүй бөгөөд түүнд дээд шатны байгууллага, албан тушаалтанд нь гомдол гаргах буюу шийдвэрийг хянан магадлуулах эрхтэй зэргийг тодорхойлсон нь оюуны хоцрогдолтой хүмүүсийн эдлэх эрх, үүрэг дэлхийн улс орнуудын дотоодын эрх зүйн баримт бичгүүдэд тусгалаа олох эх сурвалж болсон бөгөөд хүний эрхийг дээдэлсэн, хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчим, үзэл баримтлал болсон гэж үзэх үндэслэлтэй.

Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглалын удиртгал хэсэгт “Дэлхийн энх тайван, хүний эрх, эрх чөлөө, хувь хүний үнэт зүйл, нийгмийн шударга тогтолцоог цогцлоон бүтээх, эдийн засаг, нийгмийн салбар дахь хөгжлийн түүчээг залгамжлах их үйлсийг ухамсарлаж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүний эрхийн олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тунхаг, боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбарт авч хэрэгжүүлж байгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл ажиллагаа, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн фонд болон бусад баримт бичгүүдийн зарчим, үзэл санаанд тулгуурлан, оюуны хувьд хоцрогдолтой хүмүүст нийгмийн бүхий л салбарт тусламж хүргэх, хэвийн амьдралын горимд ороход нь дэмжлэг үзүүлэх зорилгод нийтээр нэгдэн улс орнууд энэ тунхаглалыг үүрэг хэмээн ёсчлон биелүүлэхийг зарлан тунхаглаж байна.” гэсэн нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс орнууд уг зарчмыг өөрийн орны Үндсэн хууль, дотоодын эрх зүйн зохицуулалтад тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын өмнө тайлан, илтгэл тавих үүрэгтэйг тодорхойлсон нь харагдаж байна.

б) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал (1975 он)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал нь 1975 оны 12 дугаар сарын 09-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээр батлагджээ. Оюуны хоцрогдолтой буюу нийгмийн харилцаанд бие даан оролцох, эрх, үүргээ хэрэгжүүлэх чадваргүй хүнийг нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй гэх тодотголд хамааруулан авч үздэг. Энэ ч утгаар төрөлхийн болоод олдмол, биеийн хөгжил хийгээд оюуны бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дээрх тунхагаар баталгаажуулсан нь илүү өргөн хүрээг хамарсан гэж ойлгож болох юм.

Тунхаглалын 1 дүгээр зүйлд тодорхойлсноор хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт төрөлхийн, эсхүл олдмол бие, эрхтний дутмаг, хоцрогдол, оюуны хоцрогдлоос шалтгаалан өөрийн ердийн амьдралын хэрэгцээг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах чадваргүй этгээдийг ойлгохоор тусгажээ¹¹.

¹¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал, 1975

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гарал үүсэл, хүйс, итгэл үнэмшил, шашин шүтлэг, нийгмийн давхарга зэргээс үл хамааран бусад хүний эдлэх эрхийг чөлөөтэй эдлэхээс гадна тэдэнд зориулсан нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөрийн дадал олох, цаашлаад хөдөлмөрлөж, ашиг орлого олох нөхцөл бололцоо тодорхой хэмжээнд хүртээмжтэй байдаг¹².

Тус тунхаглалын 10 дугаар зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь аливаа ялгаварлах, гутаан доромжлох шинжтэй үйл ажиллагаанаас ангид байх ба тэднийг зүй бусаар ашиглаж болохгүй.”, 11 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн болоод эд хөрөнгөтэй холбоотой хэрэгт, эсхүл тэдгээр нь хууль бус үйлдлийн холбогдогч болсон бол хууль зүйн туслалцаа авах эрхтэй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний биеийн болоод оюуны нөхцөл байдлыг харгалзан үзсэн байвал зохино.”¹³ гэж тус тус тодотгожээ.

Дээрхээс үзвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал нь зөвхөн оюуны хувьд бэрхшээлтэй хүнээс гадна бие, физиологийн хувьд бэрхшээлтэй хүний суурь эрхийг авч үзсэн байх ба тодорхой тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа тэдний нөхцөл байдлыг харгалзан үзсэн байх, цаашлаад хүний эрхэм чанар, эрх, эрх чөлөөг нь хүндэтгэх, аливаа хэлбэрээр гутаасан, доромжилсон, эрхийг нь боогдуулсан шинжтэй аливаа үйл ажиллагаа явуулахгүй байхын чухлыг тэмдэглэсэн нь Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглалын адил ач холбогдолтой болсон гэж үзэж болох юм.

в) Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх тухай зарчмууд

Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх тухай зарчмууд хэмээх баримт бичиг 1991 оны 12 дугаар сарын 17-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээр батлагджээ.

Тус зарчмуудад дурдсанаар хэн ч болов Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад үндэслэн өөрийн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болоод соёлын эрхүүдээ чөлөөтэй эдлэх эрхтэй бөгөөд гагцхүү тодорхой тохиолдолд, хуульд заасан үндэслэл,

¹² Мищенко Е.В., Международно-правовое закрепление особенностей правового статуса лиц, к которым могут быть применены принудительные меры медицинского характера, Вестник ОГУ, №3, 2011.

<https://cyberleninka.ru/article/n/mezhdunarodno-pravovoe-zakreplenie-osobennostey-pravovogo-statusa-lits-k-kotorym-mogut-byt-primeneny-prinuditelnye-mery-meditsinskogo/viewer>

¹³ Организация Объединённых Наций, Генеральная Ассамблея, Декларация о правах инвалидов, 1975.

https://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/disabled.shtml

журмын дагуу тухайн этгээдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай, эсхүл нийгмийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, эрх чөлөөг хангах зайлшгүй шаардлагатай үед хүний эрхийг тогтоосон хэм хэмжээгээр хязгаарлаж болно гэж тодорхойлсон байна.

Дээрх баримт бичигт тусгасан зарчмуудын дийлэнх хэсэгт сэтгэцийн хувьд эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай байгаа хүний эрх зүйн байдал, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын ажиллах зарчмуудыг тодорхойлсон буюу, тухайлбал, сэтгэцийн эмгэгийг оношлох зарчим, эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, өвчтөний эрүүл мэндийн байдлыг нууцлах, тусламж, үйлчилгээ үзүүлэх стандартууд, эмчилгээ, эм, эмийн бүтээгдэхүүн хэрэглэх, эмчилгээ хийлгэх зөвшөөрөл зэрэг болно.

Түүнчлэн, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой үзэл баримтлал, тухайн ажиллагааны үндсэн зарчим, ойлголтын талаар тусгасан нь энэ салбарын эрх зүйн зохицуулалтын цаашдын чиг хандлага бүрэлдэн тогтоход онолын ач холбогдолтой гэж үзэх үндэслэлтэй.

Дурдаж буй баримт бичгийн 11 дүгээр зарчимд эмчилгээ хийхэд өвчтөний зөвшөөрлийг авах, тодорхой мэдээллээр хангах зарчмыг тодотгосон бөгөөд үүнд:

- өвчтөний урьдчилсан онош
- өвчтөнд санал болгож буй эмчилгээний зорилго, арга, үргэлжлэх хугацаа, хүлээгдэж буй үр дүн
- хавсарсан эмчилгээ, эсхүл явц дундын нэмэлт эмчилгээ
- боломжит буюу илэрч болзошгүй зовиур, өвчин, төрүүлэх мэдрэмж, харших шалтгаан, болзошгүй эрсдэл зэргийг тодорхой мэдээлсэн байхыг тусгасан байна.

Дээр дурдсан арга зам нь зөвхөн өвчтөн эмчилгээ хийлгэхийг сайн дураар зөвшөөрсөн тохиолдолд хэрэглэгдэх бөгөөд тэрээр эмчилгээ хийлгэхээс татгалзах ч эрхтэй гэжээ.

Харин 11 дүгээр зарчмын 8 дахь хэсэгт өвчтөнд яаралтай эмчилгээ хийхгүй бол өөртөө болон бусдад хохирол, гэм хор учруулж болзошгүй гэж сэтгэцийн эрүүл мэндийн шинжээчийн дүгнэлт гарвал эрх бүхий байгууллагын шийдвэрээр өвчтөнд дээр дурдсан мэдээллийг хүргэлгүй албадан эмчилгээ хийх боломжтой бөгөөд энэ нь уг зарчим, хэм хэмжээг зөрчихгүй гэж үзсэн байна.

Албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хүнийг эмчлэхдээ таатай орчинд байлгах, асарч, сувилахаас гадна эмч нарын зүгээс байнгын хараа хяналтад

авч, өвчтөний эрх чөлөөг тухайн албадан эмчилгээг хийж гүйцэтгэх хамгийн богино хугацаанд хязгаарлах, аливаа хэрэглэгдэж буй эмчилгээний арга техник, үйл явцын талаар өвчтөний асран хамгаалагч, төлөөлөгчид даруй мэдэгдэх ба өвчтөн өөрөө зөвшөөрсөн, эсхүл тийнхүү зөвшөөрөл өгөх чадваргүй тохиолдолд тусгайлсан эрх бүхий байгууллагын албан ёсны шийдвэр гарснаас бусад байдлаар сэтгэцийн өвчтэй хүнийг клиник туршилтад оруулахыг хориглох учиртай хэмээн тогтоосон¹⁴.

Түүнчлэн, 17 дугаар зарчимд тайлбарласнаар хэрэв хүнийг албадан эмчлэх шаардлагатай гэх шинжээчийн дүгнэлт гарсан бол шүүх тийнхүү эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргамагц тухайн шийдвэрийг даруй гүйцэтгэх, нөгөөтээгүүр, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд хэрэг хариуцах чадваргүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулсан журмаар, тусгай буюу түргэвчилсэн журмаар явуулах шаардлагатай болохыг дурдсан. Мөн нэгэнт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэгдсэн этгээдэд эмчилгээ хийгдэж эхэлсэн бол тийнхүү албадан эмчлэх нөхцөл байдал арилсан эсэх, цаашид сайн дурын эмчилгээнд хамруулах эсэхийг тогтмол магадлах нь чухал гэж заасан байна.

Харин тодорхой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцаа авахдаа тухайн этгээд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхтэй бөгөөд хэрэв өөрийн зардлаар өмгөөлөгч авах боломжгүй бол шүүх түүний орлого олох байдлыг харгалзан үнэ төлбөргүй өмгөөлөгч томилуулах, түүнчлэн тухайн этгээдэд орчуулагч, хэлмэрчийн туслалцаа шаардлагатай бол мөн дээрх журмын дагуу төлбөргүй орчуулагч, хэлмэрч томилуулах шаардлагатай аж. Үүнээс гадна сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй этгээд шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхээр хангагдах ба хэрэв тухайн хүн шүүх хуралдаанд тодорхой этгээдийг байлцуулах хүсэлт гаргасан бол шүүх хүсэлтийг хүлээн авах, ингэхдээ шүүх хуралдаанд байлцах хүний хэргийн холбогдогчид үзүүлэх сөрөг нөлөөллийг харгалзан үзнэ гэжээ.

18 дугаар зарчмын 7 дахь хэсэгт “Хэрэг хариуцах чадваргүй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах зорилгоор шүүх хуралдааныг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэх нь тухайн этгээдийн саналаас хамаарна.” гэсэн нь сонирхол татдаг. Өөрөөр хэлбэл, хуульд энэ төрлийн гэмт хэргийг заавал нээлттэй, эсхүл тодорхой тохиолдолд хаалттай явуулахаар заах бус ер тухайн холбогдогчийн өөрийнх нь саналаас хамаарах учиртай хэмээжээ. Харин хэрэгт холбогдогч этгээд шүүх хуралдааныг хаалттай, эсхүл нээлттэй явуулах тухай саналаа илэрхийлэх чадамжгүй тохиолдолд хэрхэхийг тусгаагүй байна.

¹⁴ Организация Объединённых Наций, Генеральная Ассамблея, Принципы защиты психически больных лиц и улучшения психиатрической помощи, 1991.
https://www.un.org/ru/documents/decl_conv/conventions/mental_health_care.shtml

Түүнчлэн, 18 дугаар зарчмын 8 дахь хэсэгт шүүхийн шийдвэрийг нийтийн хүртээл болгох талаар заасан. Тухайлбал, шүүх шийдвэрээ бичгээр гаргах бөгөөд шийдвэрийн хувийг хэрэгт холбогдогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нарт гардуулна. Харин шийдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийтлэх эсэх нь мөн л холбогдогчийн саналаас хамаарахаас гадна шүүх давхар хувь хүний нууцыг хамгаалах, мөн тухайн төрлийн гэмт хэргийн талаар олон нийтийн сонирхол, эрэлт хэрэгцээ ямар байгаа зэргийг харгалзах нь чухлыг тэмдэглэсэн. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд шийдвэрийг нийтийн хүртээл болгохоос татгалзаагүй ч гэсэн хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай гэж шүүх үзсэн бол нийтлэхгүй байх, эсхүл олон нийтийн эрэлт хэрэгцээ буюу тухайн тохиолдлыг практик ач холбогдолтой гэж үзэх үндэслэл байвал нийтэлж болохыг тодорхойлсон гэж ойлгогдож байна.

Нөгөөтээгүүр, уг баримт бичиг нь гэмт хэрэг үйлдэж, эрүүгийн хариуцлага хүлээж байхдаа хэрэг хариуцах чадваргүй болсон, эсхүл гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүхийн шийдвэр гарахаас өмнө хэрэг хариуцах чадваргүй болсон, эсхүл гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан этгээдүүдэд нэгэн адил хамаарна гэж 20 дугаар зарчимд тусгажээ.

Дээрх Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх тухай зарчмууд нь хэрэг хариуцах чадваргүй этгээдийн эрх зүйн байдал, түүний эрх, үүрэг, цаашлаад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шүүхийн шатан дахь журам зэргийг тоймлон үндсэн зарчмуудыг тодотгосон бөгөөд уг арга хэмжээг хэрэглэхдээ уг зарчмыг удиртгал болгох, эш татах, түүний суурь үзэл баримтлалаас гажихгүй байх явдлыг дотоодын эрх зүйн хэм хэмжээгээр тогтоох шаардлагатайн дээр эл зарчмыг тууштай баримтлах үүрэг улс бүрийн өмнө тулгарч байна.

г) Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль: 10 зарчмууд

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага 1996 онд Швейцарийн Женев хотод “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль: 10 зарчмууд” гэх баримт бичгийг батлан гаргасан. Энэхүү баримт бичиг нь НҮБ-ын “Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх тухай зарчмууд”-ын залгамж болсон бөгөөд гишүүн улс орнуудын сэтгэцийн эрүүл мэндийн салбарт зөвлөмж, эсхүл дагаж мөрдөх заавар болгох үүднээс 10 зарчмыг тодорхойлж, тэдгээрийн тодорхойлолт, агуулга, хэрэгжүүлэх арга замыг тоймлон тусгаж, Зарчмуудын Удиртгал хэсэгт дурдсанаар хууль тогтоогч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, сэтгэцийн эмгэгтэй хүн, тэдгээрийн гэр бүл, өмгөөлөгч нарт зориулсан олон улсын баримт бичиг болгов гэжээ.

Тус баримт бичгийн 9 дүгээр зарчимд сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой аливаа шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан (тухайлбал, шүүгч хэмээн тодотгосон) нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1) Мэдлэг, ур чадвартай;
- 2) Хараат бус;
- 3) Төвийг сахисан байх гэжээ.

Түүнчлэн, сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан нь 1-ээс илүү хүнээс (тухайлбал 3 гэж тодотгосон) бүрдсэн байвал зохино гэсэн байна.

Харин хэрэг, маргааныг үнэн зөвөөр шийдвэрлэхийн тулд шүүгчийг сэтгэцийн эрүүл мэнд судлал, сэтгэл зүй, нийгмийн халамж үйлчилгээний талаар үргэлжилсэн сургалтад хамруулах, шударгаар шийдвэр гаргахын тулд цалин хангамжийг нь хангалттай хэмжээнд хүргэх, ашиг сонирхлын зөрчил гаргасан шүүгчийн албан тушаалаас нь огцруулах арга хэмжээ авбал зохино¹⁵ гэж тодотгосон. Дээрхээс үзвэл сэтгэцийн эмгэгтэй хүнийг шүүхийн журмаар албадан эмчлэх ажиллагааны журам чухлаас гадна басхүү шийдвэр гаргах шүүгчийн энэ салбарын талаарх мэдлэг, ур чадвар чухал болохыг онцолсон нь харагдана.

IV. ЕВРОПЫН ЗӨВЛӨЛИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛЧЛЭХ СЭТГЭЦИЙН ЭМГЭГТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЗӨВЛӨМЖ

Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах зөвлөмж нь 2004 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны чуулганаар батлагджээ. Европын Зөвлөл нь 1949 онд буюу Дэлхийн 2 дугаар дайны дараахан байгуулагдсан бөгөөд Европт хүний эрх, ардчилал, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх эрхэм зорилгын хүрээнд эдүгээ Европын 47 орныг гишүүнчлэлээр элсүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Тэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан ёсны ажиглагч хэмээн тооцогддог бөгөөд Европын Хүний эрхийн шүүх уг байгууллагын харьяанд ажиллаж байна.

Европын Зөвлөл 1977 онд Сэтгэцийн эмгэгтэй хүний нөхцөл байдлын зөвлөмж, 1994 онд Сэтгэцийн эрүүл мэнд болон хүний эрхийн талаарх зөвлөмж зэрэг тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан холбогдох баримт бичгүүдийг батлан гаргаж байсан бөгөөд 2004 онд шинэчлэн баталсан нь уг зөвлөмж болно.

¹⁵ World Health Organization, Division of Mental Health and Prevention of Substance Abuse, Mental Health Care Law: Ten Basic Principles, Geneva, 1996. https://www.who.int/mental_health/media/en/75.pdf

Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах зөвлөмжөөр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэгдэх хүний эрх, хүн ёсны эрхэм чанарыг сахин хамгаалахад гишүүн улсуудын баримтлах зарчим, чиг баримжааг тодорхойлохоос гадна уг зөвлөмжид дурдсан үзэл баримтлалыг гишүүн улсууд дотоодын эрх зүйн хэм хэмжээнд тусгахыг зөвлөмж болгон батласан нь онолын болоод практик ач холбогдолтой болсон. Өөрөөр хэлбэл, уг зөвлөмж нь сэтгэцийн эмгэгтэй хүний эрх зүйн байдал, уг ойлголтын мөн чанар, өөртөө болон нийгэмд үзүүлэх үр нөлөөний илрэл, цаашлаад эмнэлэг, шүүх, цагдаагийн байгууллагын харилцан оролцоо ямар байх талаар наад захын хэм хэмжээг тусгасан агаад үүнийг улс орнууд эш татан, улмаар илүү нарийвчилсан зохицуулалт бүхий хууль, журмаар зохицуулж болохыг зөвлөсөн нь онцлог юм.

Зөвлөмж нь нийт 38 зүйлтэй бөгөөд түүний хавсралтад зүйл бүрийн нарийвчилсан тайлбарыг оруулсан нь үүний хэрэгжилтэд ихээхэн үр дүнтэй болсон гэж үзэхээр байна.

Зөвлөмжид тодорхойлогдож буй сэтгэцийн эмгэг гэдгийг Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас батлан гаргасан Өвчин болон түүнтэй адилтгах эрүүл мэндийн бусад шалтгааны олон улсын статистик ангиллын (International Statistical Classification of Diseases and Related Health Problems) ICD-10 буюу Оюуны болон зан үйлийн эмгэг гэх ангилалд авч үзсэнээр тайлбарлаж буйг дурдах нь зүйтэй.

Тус зөвлөмжийн 3 дугаар бүлгийн 16 дугаар зүйлд зааснаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг: 1) сэтгэцийн хувьд ухамсарлах чадвартай боловч эмчилгээ хийлгэхээс татгалзсан этгээдэд (тодорхой болж буй үйл явдалд сэтгэл хөдлөл, хариу үйлдэл гаргах чадвартай). 2) сэтгэцийн хувьд ухамсарлах чадваргүй бөгөөд эмчилгээ хийх шаардлагатай этгээдэд тус тус хэрэглэнэ гэж тусгажээ. (уурлах, дургүйцэх зэрэг хариу илрэл үзүүлэх чадамжгүй).

Зөвлөмжийн 17 дугаар бүлэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх нөхцлийг тодорхойлсон ба үүнд:

- 1) тухайн этгээд сэтгэцийн эмгэгтэй байх;
- 2) тухайн этгээдийн оршихуй нь өөртөө болон бусдад аюултай байх; (бусдад аюултай байх гэдэг нь түүний үйлдсэн гэмт хэргийн шинжээр тодорхойлогдоно. Тухайлбал, галдан шатаах гэх мэт)
- 3) албадлагын арга хэмжээ нь эмчилгээний зориулалттай байх; (албадан эмчлэх арга хэмжээ нь улс төрийн, ёс суртахууны, эдийн засаг, нийгмийн шалтгаантай байж болохгүй)
- 4) тухайн этгээдийн саналыг харгалзсан байх¹⁶ зэргийг тусгажээ.

¹⁶ Council of Europe, Committee of Ministers, Recommendation No. Rec(2004)10 of the Committee

Түүнчлэн, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх субъект нь шүүх, эсхүл трибунал зэрэг түүнтэй адилтгах эрх бүхий байгууллага байх ба шийдвэр гаргахдаа юуны өмнө эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай этгээдийн саналыг харгалзах, эрх бүхий эмчийн албан ёсны шийдвэр, хуульд тухайлан тодорхойлж заасан журамд үндэслэх ёстойг дурджээ.

Хэрэв холбогдогч өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадваргүй тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчийн саналыг (байгаа тохиолдолд) харгалзах ба эцсийн шийдвэрийг шүүх гаргана. Өөрөөр хэлбэл, хууль ёсны төлөөлөгч нь холбогдогчид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж мэдүүлж болох хэдий ч шүүх гагцхүү саналыг нь харгалзах бөгөөд албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэх нь эцсийн бүлэгт шүүхийн бүрэн эрх болно.

Сэтгэцийн эмгэгтэй хүн өөрийн зардлаар өмгөөлөгч авах чадваргүй бол шүүх төлбөргүй өмгөөлөгч томилуулах шаардлагатай. Хэрэв холбогдогч хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан эрх, үүргээ хэрэгжүүлэх бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдох харилцааг хууль ёсны төлөөлөгчөөр нь дамжуулан явуулна. Ийнхүү албадан эмчлэх шаардлагатай гэх шүүхийн шийдвэр гарсан бол энэ нь тодорхойгүй хугацаанд үргэлжлэх эмчилгээ байх хэдий ч өвчтөнийг эмчилж буй эмч түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх болсон шалтгаан арилсан эсэхэд тодорхой хугацааны давтамжтай хяналт тавьж, цаашид албадан эмчилгээг үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзвэл эмчийн дүгнэлт гаргах, улмаар шүүх уг арга хэмжээг хүчингүй болгох зохицуулалт хэрэгжих учиртайг тодорхойлсон.

Мөн шүүх сэтгэцийн эмгэгтэй хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэхдээ аль болох богино хугацаанд шийдвэрлэх нь зохимжтой бөгөөд шүүхийн шийдвэрийг холбогдогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нарт хүргүүлвэл зохино гэсэн байна¹⁷.

Уг зөвлөмжийн нэгэн онцлох зохицуулалт нь мониторинг хийх явдал юм. Өөрөөр хэлбэл, гишүүн улс орон бүр зөвлөмжийн хэрэгжилт зохист байдлаар хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих дотоодын мониторингийн албатай байх бөгөөд тус алба нь шалгуулагч байгууллагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулах чадамжтай, өөрсдийн дүрэм, стандарттай, технологийн дэд бүтэц, санхүү, хүний нөөцийн чадавхитай байх шаардлагыг тавьж байна. Тухайн албад нь хяналт шалгалтаа хийхдээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байгууллагад урьдчилан мэдэгдэл өгөлгүйгээр

of Ministers to member States concerning the protection of the human rights and dignity of persons with mental disorder and its Explanatory Memorandum, 2004.

<https://rm.coe.int/rec-2004-10-em-e/168066c7e1>

¹⁷ Мөн тэнд.

очих, ингэхдээ өвчтөний эмчлүүлж байгаа эмчилгээний явц, үр дүн, орчин, нөхцөл, эмнэлгийн ажилчдын стандарт мөрдөж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт өгөхөөс гадна эрх бүхий алба хаагч өвчтөнтэй биечлэн уулзах, өвчтөнөөс “нууцлал” бүхий гомдлыг биечлэн хүлээн авах, өвчтөний талаар дурын мэдээллийг эмнэлгээс саадгүй гаргуулан авах эрхтэй байх ёстой хэмээн заасан. Мөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний талаар нэгдсэн тоон мэдээг тогтмол гаргах, тэдгээрийг хэвлэн нийтлэх, хяналт шалгалт хийгдсэнээр илэрхий болсон асуудал, зөвлөмжид тухай бүр хариу арга хэмжээ авах нь зүй ёсны шаардлага, зохицуулалт мөн гэж тодорхойлсон нь онцлог байна. Учир нь тоон мэдээ нь сайн туршлагыг нээн илрүүлэх, олон улсын харьцуулалт хийхэд хэрэгтэй ажээ.

V. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. мөн зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасныг удирдлага болгон дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нэгдэн орсон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх ажил тасралтгүй хийгдэж байна. Монгол Улсад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх, гүйцэтгэх, өөрчлөх, зогсоохтой холбогдсон харилцааг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмаар зохицуулж байна. Эдгээр хууль тогтоомж нь Монгол Улсын нэгдэн орсон болон бүс нутгийн хэмжээнд үйлчилж байгаа дээрх эрх зүйн баримт бичигт тусгагдсан хүний эрхийн зарчим, хэмжээнд нэлээд дөхсөн боловч цаашид боловсронгуй болгох шаардлага гарсаар байна. Түүнчлэн батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, хууль хоорондын уялдаа холбоо сул байгаагаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд цөөнгүй хүндрэл учирч байна. Түүнээс гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч сэтгэцийн өвчтэй болон оюун ухааны хомсдолтой хүмүүсийн эрхийг хангах асуудал хангалтгүй хэвээр байгааг анхаарах шаардлагатай юм.

VI. НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Усын Үндсэн хууль 1992
2. С.Жанцан, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол” 2 боть, УБ, 2014
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал, 1975.
4. Эрүүгийн хууль 2002
5. Эрүүгийн хууль 2015
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017
7. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966
8. Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглал 1971

Гадаад эх сурвалж:

1. Hans Joachim Salize, Harald Dressing, Monika Peitz, Compulsory Admission and Involuntary Treatment of Mentally ill Patients – Legislation and Practice in EU-Member States (Final report), Mannheim, Germany, 2, 2002.
2. Организация Объединённых Нации, Генеральная Ассамблея, Декларация о правах умственно отсталых лиц, 1971.
3. Мищенко Е.В., Международно-правовое закрепление особенностей правового статуса лиц, к которым могут быть применены принудительные меры медицинского характера, Вестник ОГУ, №3, 2011.
4. Организация Объединённых Нации, Генеральная Ассамблея, Декларация о правах инвалидов, 1975.
5. World Health Organization, Division of Mental Health and Prevention of Substance Abuse, Mental Health Care Law: Ten Basic Principles, Geneva, 1996. https://www.who.int/mental_health/media/en/75.pdf
6. Council of Europe, Committee of Ministers, Recommendation No. Rec(2004)10 of the Committee of Ministers to member States concerning the protection of the human rights and dignity of persons with mental disorder and its Explanatory Memorandum, 2004.
7. <https://rm.coe.int/rec-2004-10-em-e/168066c7e1>
8. https://ec.europa.eu/health/ph_projects/2000/promotion/fp_promotion_2000_frep_08_en.pdf
9. https://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/retarded.shtml
10. <https://cyberleninka.ru/article/n/mezhdunarodno-pravovoe-zakreplenie-osobnostey-pravovogo-statusa-lits-k-kotorym-mogut-byt-primeneny-prinuditelnye-mery-meditsinskogo/viewer>
11. https://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/disabled.shtml
12. https://www.un.org/ru/documents/decl_conv/conventions/mental_health_care.shtml



Я.БИЛЭГДЭМБЭРЭЛ

Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн нэгдүгээр тасгийн дарга, цагдаагийн хошууч, докторант

МӨНГӨН УСТАЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН ХОР УРШИГ:ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

CONSEQUENCES OF MERCURY-ASSOCIATED CRIMES AND HUMAN RIGHTS PROBLEMS

Хураангуй: Химийн хортой бодис болох мөнгөн усны хор аюул, энэ төрлийн гэмт хэргийг шалгаж байгаа алба хаагчид, оролцогч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хангагдаж байсан эсэх болон мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд хураан авсан химийн бодисыг аюулгүй тээвэрлэх, түр хугацаанд хадгалж байгаа байдал, энэхүү харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, учирч болзошгүй эрсдэлийг тооцож бууруулах арга замыг тодорхойлохд саналаа хуваалцана.

Abstract: The dangers of toxic chemicals such as mercury, the safety of officers and participants in the investigation of such crimes, and the safe transportation and temporary storage of confiscated chemicals were examined.

Түлхүүр үг: Цагдаа, Мэргэжлийн хяналт, Онцгой байдлын алба хаагчид болон иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, химийн

бодис болох мөнгөн усны хэрэглээг тодорхойлж, байгаль орчинд үзүүлж байгаа хортой нөлөөллийг тооцох,

Keywords: Fulfilling the rights of officers of police, specialised inspection, and emergency management, and citizens to safe and healthy environment, defining mercury utilization and assessing harmful impact to the environment.

I. ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж хуульчилсан байдаг. Энэ заалт нь сүүлийн жилүүдэд үйлдвэржилт, уул уурхайн олборлолт, хүний амын төвлөрөл зэрэгтэй холбоотойгоор зөрчигдөх тохиолдол гарах болсон байна.

Энэ эрх нь үндсэн хоёр эрх зүйн баримт бичигт тусгагдаж, хамгаалагдсан байдгаараа хууль зүйн бодит биеллээ олдог. Үүний нэг нь бол Монгол Улсын Үндсэн хууль юм. Монголчууд байгаль орчноо хамгаалах эртний уламжлалтай боловч “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн” талаарх зохицуулалт 1924, 1940 болон 1960 оны Үндсэн хуулиудад огт тусгагдаагүй юм. Магадлал нь байгалийн юмс үзэгдэлтэй зохицон амьдрах ахуйд илүүтэй суралцсан, хөгжлийн буурай байдал болон ялангуяа хүний эрх болон байгаль хамгаалах асуудлыг ангид хүлээн авч ойлгож байсантай шууд холбогдоно. Харин ардчилсан шинэ Үндсэн хууль батлахтай холбоотойгоор энэхүү заалт нь хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх байдлаар Үндсэн хуульд тусгалаа олсон байна.¹

1972 оны Стокхольмын тунхаг, 1993 оны НҮБ-ийн хүний эрхийн тухай Венийн тунхаглалаас эхлэлтэй “Эрүүл орчинд амьдрах” хүний эрхийн заалтууд пост-коммунист орнуудын Үндсэн хуульд шинэ өөрчлөлт, зохион байгуулалттай хамт биеллээ олсон байдаг.

Үг зүйн хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн хувьд “Орчин” хэмээх ойлголтыг хэрхэн ойлгохоос энэхүү эрхийн агуулгыг өргөн эсвэл явцуу хүрээнд авч үзэх эрх зүйн үндэслэл тодорхойлогдоно. Монгол хэлний эх тайлбар тольд “Орчин” хэмээх ухагдахууныг “ямар нэг зүйлийг тойрон хүрээлж буй ойр хавь, тойрон хүрээлж буй шим ертөнц зэргээр тодорхойлжээ. Харин Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн тухайд Б.Чимэд багш “Хэн нэгний танхайрал, эсвэл ослоор нас барах мэт эрүүл, аюулгүй орчинд амьдрах өөр нэг эрх зөрчигдсөний үр дагавар байдаг” гэж тайлбарласан байна.²

¹ Д.Баяр, “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх”-ийн ойлголт, тайлбар, хэрэглээ өгүүлэл, УБ, 2017, 6 дахь тал,

² Мөн өгүүллийн 7 дахь тал

Дээрх нэр томьёо, хууль зүйн тайлбаруудаас үзэхэд энэхүү эрх нь зөвхөн хүрээлэн буй байгаль орчны бохирдлын асуудлаар хязгаарлагдахгүй өргөн утга асуулгатай байна.

Ийм учраас судлаачийн зүгээс химийн хорт, аюултай бодис болох мөнгөн усны хор аюул нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа алба хаагч, иргэдэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлон үзэх шаардлагатай болсон.

Монгол Улсад 1961 онд Шинжлэх ухааны Академи байгуулагдаж, байгаль шинжлэлийн хүрээлэнгүүдэд химийн хорт, аюултай бодисыг бага хэмжээгээр хэрэглэж эхэлсэн. 1970 оноос эхлэн газар тариалангийн салбарт ургацын гарцыг нэмэгдүүлэх, болцыг түргэсгэхэд, 1990 оноос эхлэн зах зээлийн харилцаанд шилжиж байгалийн нөөц баялаг, ашигт малтмалыг олборлоход химийн бодисыг ашиглаж эхэлсэн байдаг.³

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний эрүүл мэндэд хор уршиг үзүүлдэг химийн бодисын эхний аравт мөнгөн усыг багтааж, Нэгдсэн үндэстний байгууллагаас мөнгөн усныг хэрэглэхгүй байх тухай МИНИМАТА-гийн конвенцыг 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурж батлан, дэлхийн 92 улс орон нэгдэн орж, хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол Улс 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр нэгдэн орсон байна.

Конвенцод нэгдэн орсон гишүүн орнууд гар аргаар болон алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны хэрэглээг таслан зогсоох, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, бохирдлыг бууруулахад чиглэсэн үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Монгол Улс энэхүү үүргээ биелүүлж, 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын 317 дугаар тогтоолоор Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг баталсан байна. Тус хөтөлбөрт алтны бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулж, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг ханган, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх үндсэн зорилгын хүрээнд дөрвөн зорилт, 13 үйл ажиллагааны чиглэл, 59 арга хэмжээг 2019-2023 онуудад хэрэгжүүлэхээр тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор мөнгөн усыг хэрэглэхийг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад оруулж Байгаль орчны сайдын 2008 оны 135 дугаар тушаалаар уул уурхайн үйлдвэрлэлд мөнгөн ус ашиглахыг хориглосон байдаг.

³ Э.Хулан, Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж УБ, 2020

Мөн Химийн хорт, аюултай бодисын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь хортой, аюултай гэж тус тус ангилсан байна.



Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн 24.3 дугаар зүйлд Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийн хуульчлан өгсөн байдаг.

1 дүгээр хэсэгт “Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан” гэсэн 9 төрлийн үйлдлийн гэмт хэрэгт тооцсон байна.

Хүндрүүлэх нөхцөл байдалд

- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон;
- Их хэмжээний хохирол учирсан
- Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэсэн 3 төрлийн хүндрүүлэх нөхцөлийг зааж өгсөн байна.

Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, байгаль хамгаалах болон химийн хорт, аюултай бодисыг үйлдвэрлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, ашиглах журамд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлагад хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм.⁴

⁴ С.Гантулга, Б.Энхболд Эрүүгийн эрх зүй /тусгай анги/, УБ, 2018, 438 дахь тал

II. ХИМИЙН ХОРТ БОДИС БОЛОХ МӨНГӨН УСНЫ ХОР УРШИГ БА ХҮНИЙ ЭРХ

Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулах хортой бодис болох мөнгөн ус нь тасалгааны температурт шингэн байдаг цорын ганц металл бөгөөд металлтай нэгдэж амальгам үүсгэдэг ба энэ шинж чанарыг ашиглаж уул уурхайн салбарт хүдрээс металлыг ялгаж авахад хэрэглэдэг аж. Мөнгөн усны уур нь маш хортой бөгөөд амьсгалын замын эрхтнүүдийг гэмтээдэг, хүний биед орсон тохиолдолд амьсгал давчдуулж, амьсгалахад хүнд болох, толгой өвдөх, булчин татах, цуллаг эрхтнүүд, тэр тусмаа элгэнд хуримтлагдаж гэмтээх, хорт хавдар үүсгэх зэрэг аюултай болохыг анагаахын шинжлэх ухаан тогтоожээ. Мөн арьс, салстад хүрсэн тохиолдолд түлж, шархлуулах, арьсаар нэвчиж хүний биед орох аюултай юм.

Аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулж байх үед нь барьж саатуулан хэргийг газрын үзлэг хийх үед алба хаагчид, тухай орчинд байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах асуудал маш чухал байна.

Мөнгөн ус /Hg/ гэсэн тэмдэглэгээтэй энэ бодис химийн үелэх системийн 80 дахь элемент бөгөөд хүний эрүүл мэнд, амь насанд маш аюултай. Анх алт угаах зориулалтаар 1550 онд Африкт ашиглаж эхэлсэн байна.

Мөнгөн ус нь байгаль дээр:

- Метал буюу элемент
- Органик бус
- Органик гэсэн 3 хэлбэрээр оршдог.

Монголд метал хэлбэрийн мөнгөн усныг хэрэглэдэг бөгөөд энэ төрлийн хордлого ихэвчлэн тохиолддог.⁵

Японы Минимата мужид гарсан хордлого нь органик мөнгөн усны хордлого гэж эрдэмтэд үздэг байна. 1956 онд Японы Кюшу арлын Минимата хотод үйл ажиллагаа явуулдаг “Чисо” групп химийн үйлдвэр хог хаягдлаа далай руу хаядаг байснаас тэнд амьдарч, далайгаас хоол хүнсээ залгуулдаг байсан олон мянган япон иргэн мөнгөн усанд хордож амь насаа алдсан харамсалт түүх бий. Минимата гэж нэрлэгдсэн уг өвчин нь органик мөнгөн уснаас үүдэлтэй, төв мэдрэлийн системийг эмгэгшүүлж, генийг гэмтээн удамшдаг хорт, аюулт өвчин юм. Мөнгөн усны хордлого авсан эхчүүдээс төрөлхийн ургийн гажигтай хүүхдүүд төрж, уг хор хохирол хэдэн арван жил үргэлжилж, өдгөө ч Японы Засгийн газраас нөхөн олговор олгосоор байдаг.

Монгол улсын Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2016-2018 онд төрөхийн өмнөх үеийн мөнгөн усны өртөлтийг тодорхойлох судалгааг Сэлэнгэ

⁵ Нийгмийн эрүүл мэндийн төвөөс гаргасан 2018 оны судалгааны тайлан.

аймгийн Сүхбаатар, Мандал сумдын 2016 оны 7-11 сард төрсөн нийт 265 эхэд хийжээ. Судалгаагаар эхчүүдийн биологийн дээжин дэх мөнгөн усны агууламж бага гарсан байна. Гэвч дөрвөн эхийн шээсэнд, нэг эхийн хүйн цусанд мөнгөн усны агууламж Германы хүний биомониторонгийн зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарсан байна⁶.

Мөн тус төвөөс 2014 онд бичил уурхай эрхлэгчдийн дунд мөнгөн усны нөлөөллийн судалгааг хийжээ. Судалгаанд мөнгөн усгүй технологи ашигладаг баяжуулах цех, нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон 33 бичил уурхайн нөхөрлөлийн 147 бичил уурхай эрхлэгчдийг хамруулахад долоон хүн мөнгөн усны архаг хордлоготой нь тогтоогджээ. Судалгааны явцад бичил уурхай эрхлэгчдийн цус болон шээсэнд хийсэн шинжилгээгээр 20-30 хувьд нь мөнгөн усны агууламж өндөр гарсан байна.

Үндэсний статистикийн хорооны 2016 онд хийсэн судалгаагаар 15 аймгийн нийт 34 сум, нийслэлийн Багахангай дүүрэгт 5108 иргэн алтны бичил уурхай эрхэлж байгаагаас 1415 нь хувиараа буюу хууль бусаар алт олборлодог аж. Харин Монгол банкинд 2017 онд нийт 20.01 тонн алт тушааснаас 12.66 тонн буюу 63.3 хувийг бичил уурхайчид нийлүүлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагаас 2012, 2014 онуудад түүврийн аргаар алтны үндсэн орд бүхий 12 сумын 308 алтны бичил уурхай эрхлэгчид үзлэг, шинжилгээ хийхэд цус, шээсэн дэх мөнгөн усны агууламж нь 14.3-24.5 хувьтай гарчээ.

Энэ нь манай улс мөнгөн усны хэрэглээг хууль, эрх зүйн орчинд хориглосон боловч хууль бусаар ашигт малтмал олборлох зорилгоор худалдан борлуулж, ашиглаж байгааг харуулж байна.

Мөнгөн ус бол байгальд байдаг шингэн төлөвт, хүнд элемент. Харин хүний үйл ажиллагааны улмаас хүний амьдрах орчинд дэгдэж, биед орвол буцаж хэзээ ч гардаггүй учраас хүний эрүүл мэндэд маш их хор уршигтай. Мөнгөн усны хордлогод орох эрсдэлт нөхцөлд хөдөрмөрлөж байгаа бичил уурхай эрхлэгчид юм. Хэдийгээр хил, гаалиар нэвтрүүлэхийг хориглож, хязгаарласан ч ямар нэг байдлаар ашигласаар байгаа нь судлаачийн анхаарал татаж байна.

Мөнгөн усыг хэрэглэж байгаа газруудын байршлыг тодорхойлох зорилгоор Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтэс, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн 35 алба хаагчтай ярилцлага хийж, 22 асуулт бүхий анкетаар судалгаа хийж үзэхэд:

- Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороонд байрлах Урт цагааны худалдааны гудамжинд “Алт авна. Хайлна” гэсэн зар байрлуулсан газарт алтыг өндөр температурт хайгуулж мөнгөн усыг ууршуулдаг байж болзошгүй

⁶ News.mn сайт. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Орчны эрүүл ахуй, хор судлалын лабораторийн химич Д.Баатарцолтой хийсэн ярилцлага.

- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Нарантуул олон улсын худалдааны төвийн хойд хаалганы орчим жижиг шилэнд хийсэн мөнгөн усыг зарж борлуулдаг байж болзошгүй
- Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг алтны тээрмүүд шорооноос алтыг ялган авах үед мөнгөн усыг хэрэглэдэг байж болзошгүй гэсэн судалгааны ажлын дүгнэлт гарсан.

Урьд нь мөнгөн ус ашиглаж байгаа хөрсөнд нь нэвтрэн үлдсэн байж болзошгүй газруудыг тогтоох зорилгоор Экологийн цагдаагийн албанаас албан бичгээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хандаж хариу авч нэгтгэн үзэхэд:

- 2020 оны 9 дүгээр сард Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Цагдаагийн газартай хамтран хариуцсан нутаг дэвсгэрт мөнгөн усны хууль бус хэрэглээ байгаа эсэхийг тогтоох зорилгоор шалгалт явуулж Манлай суманд хуучин тээрэм ажиллаж байсан газрын хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабортори дээр шинжилгээ хийлгүүлсэн байна. Уг дүгнэлтээр хөрснөөс мөнгөн ус илэрч байжээ.
- Сэлэнгэ аймгийн Баянгол сумын “Нарангийн гол” гэх газарт 2000-2003 онд БНХАУ-ын иргэд 5 газарт, 2008, 2010, 2011 онуудад дотоодын аж ахуй нэгжүүд тээрэм ажиллуулж мөнгөн ус ашиглан алтны олборлолт явуулж хөрсийг бохирдуулж байжээ. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газартай хамтран 2008 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “Нарангийн гол” гэх газраас мөнгөн усаар бохирлогдсон шороог зөөж өөр газарт булж хорыг саармагжуулах арга хэмжээ авч байсан байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын хэмжээнд Хүрээлэн байгаа орчны эсрэг 1578 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 1.0 хувийг эзлэж, илрүүлэлт 65.3 хувьтай байжээ. Харин 2021 оны эхний 11 сарын байдлаар цагдаагийн байгууллагад Хүрээлэн байгаа орчны эсрэг 571 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 40 хэрэг буюу 6.5 хувиар буурч, илрүүлэлт 56.7 хувьтай байна.

Бүртгэгдсэн хэргүүдээс Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан “Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах” гэмт хэрэг 15 бүртгэгдсэн байна. Үүнээс мөнгөн ус \химийн бодис\ -ыг хууль бусаар олж авсан, зарж борлуулсан, ашигласан гэмт хэрэг Дорноговь аймагт 1, Чингэлтэй дүүрэгт 3, Баянзүрх дүүрэгт 1, нийт 5 бүртгэгдсэн байна.⁷

⁷ Экологийн цагдаагийн албанаас гаргасан “Гэмт хэргийн нөхцөл байдлын танилцуулга” мэдээ, УБ, 2021.11 сар, 3 дахь нүүр

Дээрх судалгаа, тоо баримт, бүртгэгдсэн хэргийн үзүүлэлтээс үзэхэд Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт урьд нь мөнгөн ус хэрэглэж хөрс, усанд нэвтрэн үлдсэн бол Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт Урт цагаан худалдааны гудамж, Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Нарантуул олон улсын худалдааны төвийн алт худалдан авдаг ченжүүд, Дорноговь, Төв, Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт байрлах тээрэм ажиллуулдаг иргэд мөнгөн ус хэрэглэдэг байж болзошгүй гэж үзэж байна.

Экологийн цагдаагийн албанаас Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэгтэй тэмцэж 2020 онд 61000 грамм⁸, 2021 оны эхний 11 сарын байдлаар 14750 грамм⁹ мөнгөн усыг хураан авч ажилласан байна.

1 грамм мөнгөн ус ууршихдаа 20 га хүртэл талбайг бохирдуулдаг талаар судаач эрдэмтэдийн тэмдэглэснээс үзэхэд 2020, 2021 оны эхний 11 сарын байдлаар нийт 75.750 грамм / (76 кг) мөнгөн усыг хураан авсныг тооцоолбол $75.750 \times 20 \text{ га} / 1 \text{ грамм мөнгөн усны бохирдуулж болох талбай} = 1.515.000$ га газрыг бохирдуулж болзошгүй байна. 1.515.000 га талбай мөнгөн усанд бохирлогдож, иргэдийн эрүүл, аюулгүй орчин амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг зөрчих, хүний эрүүл мэндэд эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх нөхцөл болсон байна.

Харин 2021 онд цагдаагийн байгууллагад химийн бодис, мөнгөн ус илэрсэн 23 дуудлагад¹⁰ ирснийг хүлээн авч шуурхай ажилласан, энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй 15 үйлдлийг шалгасан алба хаагчдын аюулгүй байдал хангагдсан эсэх, мөнгөн усны хордлогод орсон эсэхийг тооцож үзэх ёстой.

Экологийн цагдаагийн албаны 35 алба хаагчдаас “Та химийн бодисыг дуудлага очихдоо тусгай хамгаалалтын хувцас өмссөж байсан уу?” гэж асуухад БҮГД ҮГҮЙ гэж хариулсан байна.

Цагдаагийн байгууллагад химийн хорт, аюултай бодис илэрсэн тухай дуудлага, мэдээлэл ирсэн тохиолдолд баримтжуулан ажиллах Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 206-д/ Хэргийн газрын үзлэг хийх, /код 211-д/ Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч, ажиллах гэсэн энэ үйл ажиллагааг зохицуулсан журмууд хэрэгжиж байна.¹¹

Харин Онцгой байдлын ерөнхий газарт Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотой гарч

⁸ Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2020, 4 дэх нүүр

⁹ Мөн албаны 2021 оны 11 дүгээр сарын тайлан, УБ, 2021, 3 дахь нүүр

¹⁰ Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвөөс авсан тоон мэдээлэл

¹¹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/262 дугаар тушаал

болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулах заавар¹² байна.

Мөнгөн усыг хадгалах, зарж борлуулах гэж байсан үйлдлийг илрүүлсэн тохиолдолд хэргийн газар дээр ирж хамтран ажиллаж мөнгөн усыг хураан авч аюулгүй тээвэрлэлт хийх байгууллага, албан тушаалтан, энэ үйл ажиллагааг зохицуулсан журам байхгүй байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшиг судлалын хүрээлэнд мөнгөн ус хадгалах сав байгаа боловч бүх мөнгөн усыг нийлүүлж нэгтгэн хадгалж байгаа учраас дараа нь авч шинжилгээ хийлгүүлэх боломжгүй болж байгаа.

Хураан авсан мөнгөн усыг хадгалах, аюулгүй тээвэрлэх харилцааг зохицуулсан дүрэм, журам байхгүй байгаагаас илрүүлсэн, хэргийн газрын үзлэг хийсэн алба хаагчид өөрийн өрөө, тасалгаанд хадгалж байгаад шинжилгээ хийлгүүлж дүгнэлт гарсны дараа Онцгой байдлын ерөнхий газрын Гамшиг судлалын хүрээлэн хүргүүлж байгаа нь алба хаагчид өөрсдөө хордох аюултай байна.

Энэ нь хэргийг шалгаж байгаа алба хаагчид, ажиллагаанд оролцож байгаа болон тухайн орчинд байгаа иргэдийн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах” эрх ноцтой зөрчигдөж байна.

III. ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын үр дүнд манай улс нэгдэн орсон конвенцын хүрээнд химийн хортой бодис болох мөнгөн усыг хууль, эрх зүйн орчинд ашиглахыг бүрэн хориглосон боловч хууль бусаар ашигт малтмал олборлох зорилгоор Баянзүрх дүүргийн Нарантуул, Сонгинохайрхан дүүргийн Хархорин захуудад нууцаар худалдан борлуулж, Баянхонгор, Сэлэнгэ, Өмнөговь, Төв аймгийн нутаг дэвсгэрт хууль бусаар ашиглаж байна.

Мөн мөнгөн усны хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаатай холбоотой хэрэг шалгаж байгаа алба хаагчид, мөрдөн шалгах ажиллагаанд оролцож байгаа болон тухайн орчинд байгаа иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх нь зөрчигдөж, энэ төрлийн бодист хордох аюултай байна гэж дүгнэж байна.

¹² Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/76 дугаар тушаал

IV. САНАЛ

Иргэдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хураан авах, хадгалах, тээвэрлэлт ажиллагааг зөв, аюулгүй явуулах зорилгоор судалгааны ажлыг хийснээр онол, практикийн дараах саналуудыг гарган танилцуулж байна. Үүнд:

- Хамтарсан ажлын хэсэг байгуулж “Химийн бодисын хэргийн газрын үзлэгт мэргэжилтэн оролцуулах”, “Хураан авсан химийн бодисыг хадгалах” журмуудыг боловсруулан Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын тушаалаар батлуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Мэргэшсэн мөрдөгч бэлтгэх болон хэргийн газрыг хамгаалалтад авах чиглэлээр сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах,
- Химийн бодис /мөнгөн ус/ илэрсэн үед хэргийн газрыг хамгаалалтад авч ажиллах алба хаагчдад сургалтыг шат дараатай зохион байгуулах,
- Хэргийн газрын үзлэгт оролцогч нарын хэрэглэх хамгаалалтын хувцас, хэрэглэлийг стандартыг гаргаж батлуулан, хангаж өгөх гэсэн саналуудыг гаргаж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

V. НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992
2. Эрүүгийн хууль 2015
3. Химийн хорт, аюултай бодисын тухай хууль 2006
4. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоол. Мөнгөн усыг хэрэглэхийг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт
5. Байгаль орчны сайдын 2008 оны 135 дугаар тушаал Уул уурхайн үйлдвэрлэлд мөнгөн ус ашиглахыг хориглох тухай

Монгол эх сурвалж:

1. С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги
2. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй
3. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй
4. Экологийн цагдаагийн албанаас гаргасан “Гэмт хэргийн нөхцөл байдлын танилцуулга” мэдээ
5. Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн 2020 оны үйл ажиллагааны тайлан
6. Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвөөс авсан тоон мэдээлэл
7. Нийгмийн эрүүл мэндийн төвөөс гаргасан 2018 оны судалгааны тайлан.
8. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Орчны эрүүл ахуй, хор судлалын лабораторийн химич Д.Баатарцолтой хийсэн ярилцлага.
9. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/262 дугаар тушаал
10. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/76 дугаар тушаал
11. News.mn сайт
12. П.Чимэдцэрэн. Химийн хорт бодисоос үүсэх эрсдэл, түүнийг бууруулах арга зам докторын зэрэг горилсон бүтээл. УБ, 2018
13. Э.Хулан. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл, ДХИС, 2020
14. Ц.Ариунцэцэг. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн криминологийн зарим асуудал. Магистрын зэрэг горилсон бүтээл, УБ, 2006
15. А.Мяасүрэн. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн криминологи шинж. Магистрын зэрэг горилсон бүтээл, УБ, 2013

ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ¹

FERNANDA PIRIE. THE ANTHROPOLOGY OF LAW

Фернанда Пирие**Удиртгал**

Антропологийн салбар ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ, хууль зүйн шинжлэх ухаанд ямар талаас гэрэл гэгээ өгөх вэ гэсэн асуултуудад хариулт өгнө.

Антропологи бол бодит туршлагад суурилсан салбар ухаан юм. Антропологийн судлагдахуун нь ихэнхдээ урт хугацааны турш зорилтот оролцогчид дээр ажиглалт хийх замаар бодит амьдрал дээрх зүйлсийг шинжлэн авч үздэг. Өөрөөр хэлбэл антропологичид эртний эсвэл төдийлөн авч үзэгддэггүй зүйлсийг хамруулаад аливаа юмс, үзэл бодол, бодит үйлдэл зэрэг олон төрлийн хэлбэрээр орших нийгмийн үзэгдлийг судалдаг. Харин эрх зүйн судлагдахуун гэдэгт дундад зууны Европын алс холын өнцөг булан бүрт байгаа, эсвэл Түвдийн тал хээр нутагт байгаа эрдэмтдийн хийсэн судалгааны ажил, мөн түүнчлэн олон улсын санхүүгийн зохицуулалт, хүний эрхийн төлөө тэмцэгчдийн гаргаж буй нэхэмжлэл, шаардлага зэргийг хамруулан үздэг.

Хууль гэдэг нь өөрөө ээдрээ төвөгтэй ойлголт бөгөөд энэ нь ерөнхийдөө зан үйлийг зохицуулж буй арга хэрэгсэл бүхий санаа юм. Хэдий тиймч бидний "хууль" гэж боддог нийгмийн үзэгдлүүд нь шууд ямар нэгэн ангиллыг бүрдүүлдэггүй. Хууль гэдэг нь олон улсын жишигт нийцсэн, ардчилал, сайн засаглал, улс үндэстэн бүрэлдэн тогтох зарчмыг хангах зорилго бүхий "эрх зүйт ёс" гэдэг санааг агуулж байдаг. Гэвч энэ тодорхойлолт нь уг санааг хангалттай илэрхийлж байна уу? Өөрөөр хэлбэл "дүрэм журам" гэдэг санааг дэвшүүлдэг хүмүүсийн хувьд "хууль" гэдэг нь ямар утгатай ойлголт вэ? Дэлхийн өнцөг булан бүрт хууль гэдэг нь юу гэсэн үг вэ? Эрх зүйн мөн чанарын талаарх эрх зүйн маргаантай өнцгөөс харахад үүнд нарийн тодорхойлолт хийх боломжгүй байна. Харин антропологичид эмпирик үзэгдлийг "хууль" гэх нэр томьёотой зохих ёсоор нийцүүлэн харьцуулан судлах замаар хуулийн

¹ Монголын Криминологичдын холбооноос санаачилан Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, МУИС–ийн Шинжлэх ухааны сургуулийн Археологи, антропологийн тэнхим, Монголын Антропологийн холбоо нарын хамтран хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд "Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013" хэмээх номын орчуулгыг цувралаар хүргэж байна. Энэхүү номыг дараах холбоосоор орж үзнэ үү. https://books.google.mn/books?id=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false (Сүүлд үзсэн огноо: 2022.05.08)

тухай ойлголтыг тодорхойлох боломжтой гэж үзэж байна. Бид заавал нарийвчилсан тодорхойлолтыг эрэлхийлэхгүйгээр тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, нийтлэг болон ялгаатай байдал, зөрчилдөөнийг тодруулж болох юм. Гүн ухааны түвшинд төгс төгөлдөр ойлголтыг эрж хайхгүй. Харин эрх зүйн онолчдоос бага зүйлийг амлах хэдий ч антропологичдын дэвшүүлэх санаа илүү баялаг, илүү тодорхой, илүү нарийн байх болов уу.

Тэгэхээр энэхүү ойлголт нь антропологид ямар ач тустай вэ? Антропологичид яагаад эрх зүйн мөн чанарын талаар судлах хэрэгтэй вэ? Чухам үүний зорилго нь шийдвэрлэх боломжгүй асуудлуудын тодорхойлолтод хариулт өгөх бус харин эрх зүйн мөн чанар, эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн чиг үүрэгт чиглэсэн олон асуултыг дэвшүүлэх явдал юм. Энэ нь эрх зүйн антропологийн өргөн хүрээний салбар доторх тодорхой судалгааны хэсэг байх юм. Эрх зүйн сэтгэлгээний талаарх бичвэр, үйл явдал, гүн ухаан төдийгүй бүр засгийн газрын хүрээнд хүртэл судлах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ нь төрөлжсөн хууль, үзэл санаа, учир шалтгааны хэлбэрүүдийг судална гэсэн үг юм. Дэлхий ертөнцийн тухай болоод түүнийг зохион байгуулах арга хэлбэрийн талаар сэтгэх байдлаар легализмыг судлах нь хуулийг дүрэм журам, төрөлжүүлэлт, аргументын хувьд шинжилж, цаашлаад хууль одоогоор ямар үүрэг гүйцэтгэдгийг бус харин хуулиар юу зохицуулж, юуг бүтээж болохыг судлах явдал юм.

Энэ бүлэгт уг номын зорилго болон бусад төрлийн судлагдахуунд хууль зүйн болон антропологийн салбар хэрхэн холбогдож байгааг тоймлон харуулахыг зорив.

Нийгмийн антропологи

Нийгмийн антропологи нь нийгмийн үзэгдлүүд, өөрөөр хэлбэл нийгмийн институт, зан үйлийн хэв маяг, нийгмийн харилцаа, тэдгээрийг тусгасан үзэл санаа, утга учрыг илэрхийлсэн бэлгэ тэмдгүүдийг судалдаг. Антропологичдын хувьд тухайн юмс үзэгдэл нь судлагдаагүй танил бус, шинэ ойлголт байх тохиолдолд эсвэл тэр нь тухайн судалгааны ойлголтоос юугаараа ялгаатай байгаа буюу тус ойлголтоос юугаараа эрс өөр байгааг таньж мэдэхэд ихэвчлэн тухайн нийгэм, соёл нь юугаараа онцлог ялгаатай болохыг тодорхойлох нь илүү хялбар байдаг. Хэдий тийм ч заримдаа анхааралтай ажиглалт хийх нь бидний өөрийн нийгмийн талаарх олон талт ойлголтуудыг бий болгоход дөхөм болгодог.

Антропологичид эдгээр нийгмийн орчныг болоод түүнд орших хүмүүс өөрсдийгөө төдийгүй дэлхий ертөнцөд өөрийн гүйцэтгэх үүргээ ухамсарлах онцлог байдлыг бодит туршлага дээр тулгуурлан судалдаг. Өөрөөр хэлбэл,

антропологичдын судалгааны зорилго нь хүмүүс өөрийгөө хэн болох, юу хийдэг, эргэн тойрондоо юу оршиж байгааг болон тэдний үйлдлийг юу удирдан чиглүүлж байгааг тайлбарлаж өгөх явдал юм. Тухайлбал, бидний хувьд золгүй явдал мэт санагдаж болох зүйлийг Зүүн Африкийн Занде ястнууд хорлол эсвэл ид шид гэж үздэг (Иванч—Ричард 1962: 226—27). Түвдийн нүүдэлчдийн хувьд үхлээр дуусдаг халз тулаан бол хүний амь хөнөөсөн гэмт хэрэг биш. Харин үүнийх нь төлөө өшөө авах ёстой явдал гэж үздэг бөгөөд шийтгэл ногдуулахгүй, хариуд нь өшөө авах эсвэл хохирлын нөхөн төлбөр болгож мөнгө төлөх ёстой байдаг (Пири 2005).

Хүний зан авир нь "утга учир бүхий зорилготой" гэдгээрээ бусад амьтдаас ялгагддаг (Райн 1970:16). Антропологич Дреш, Жеймс (2000:4) нарын тодорхойлсноор нийгэм судлаачид "тухайн үеийн цаг хугацааны баримжаа, соёлын уур амьсгал, нийтийн уламжлал" зэргийг судалдаг. Нийгмийн антропологичид нийгмийг ёс суртахууны үнэлэмж, үнэт зүйл дээр тулгуурлан нэгдсэн хүмүүсийн нийгэмлэгээс бүрдэж буй ёс суртахууны тогтолцоо болохоос байгалийн тогтолцоо биш гэж үздэг (Иванс—Ричард 1962:26). Тэд хуулийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлахаас илүүтэй хүний төрөлхийн зан авирыг утга учиртай болгох /"зөв үйлдэлд чиглүүлэх" орч./ хэв маягийг олж, уг ойлголтыг хөрвүүлэн буулгахыг зорьж байна. Мөн антропологичид нийгмийн зан үйлийг хэлбэржүүлж бүрдүүлдэг ойлголт, таамаглалыг судалдаг. Жишээлбэл, Түвдийн зүүн хэсэгт төрийн зүгээс хүчирхийлэл гэж тооцоогүй үйлдлийг бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг ард түмний дунд уур хилэн, эсвэл зөвтгөж болох байх ёстой зүйл гэж үздэг. Энэ нь зөвхөн тухайн нутгийн овог аймгийн зохион байгуулалтын заншлын харилцааны хүрээнд л зөв гэж ойлгогдох үзэгдэл юм. Нөгөө талаас үүнтэй төстэй маргааныг шийдвэрлэх маргаан таслагч нь өөрийгөө ямар нэг ламын хойд дүр гэж итгүүлснээр олон түмнийг өөртөө татдаг байна (Пири 2012).

Витгенштейний хэлснээр нийгмийн зан үйлийг тогтмол хэвшсэн зан үйл гэж үзэх бус харин тодорхой нэг дүрэм журмыг дагаж мөрдөж буй хэрэг гэж ойлгох нь зүйтэй гэжээ (Райн 1970:128). Антропологичид хүмүүсийн үйл хөдлөлийг чиглүүлэн зохицуулдаг (бүх төрлийн) дүрэм журмыг сонирхон судалж байна. Гэсэн хэдий ч эдгээр зан төлөв нь тойруу утгатай хэвээр байгаа бөгөөд нийгмийн амьдралыг шууд ойлгоход бэрх. Үүнийг хэт системчилж болно гэж үзэх нь буруу юм.

Антропологичид өөртөө болон бусдад хүний амьдралын аливаа хэлбэрийг ойлгомжтой байдлаар тайлбарлахыг оролддог. Хүний амьдралын хэлбэрүүд нь тодорхойлоход ээдрээ төвөгтэй ойлголт бөгөөд одоогоор нэгдсэн тодорхойлолтод хүрээгүй байна. Хэдийгээр тэдгээр тодорхойлолт нь объектив байр суурьтай байгаа ч тодорхой нөхцөл, хүмүүсийн амьдралын

хэв маяг дахь аливаа үг, дүрслэл, бүтээсэн зүйл, томъёолол, харилцан үйлчлэл зэргийн тогтсон хэмнэлтэй байна (Дрэш ба Жэймс 2000:7).

Бид маш нарийн, илэрхий ойлгомжтой нийгмийн хэлбэр, дүрэм журмыг эсвэл хэт хялбарчилсан аналитик тайлбарыг хайх ёсгүй. Хэрэв нийгмийн амьдрал эмх замбараагүй, зөрчилдөөнтэй байдаг гэж үзвэл бидний анализ илүү нарийн байх ёстой буюу тэр чинээгээр объектив загвар, тасралтгүй байдлыг эрэлхийлж, аливаа өөрчлөлт, хувирлыг хүлээн зөвшөөрөх ёстой.

Социологич, эдийн засагч, улс төр судлаачид нь үндэс угсаагаар ялгаварлан гадуурхалт ба эдийн засгийн нөхцөл байдлын хоорондох уялдаа холбоог илүү объектив, тодорхой судлах боломжтой бөгөөд үүнд судалгааны нарийн аргачлалыг ашиглах шаардлагатай байдаг. Судалгаа, түүвэр, нарийвчлан тодорхойлсон асуулт дэвшүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг ажлын арга барилыг баримталдаг.² Ийм аргыг антропологичид ашиглахаас гадна мөн угсаатан зүйн хээрийн судалгааны аргуудын нэг хэсэг болгон ашигладаг. Мерри (1990:5)–ийн хэлснээр "эрх зүйн ухамсар"–ын талаар хийсэн том хэмжээний судалгаануудаас үзвэл хувь хүн бүр хуулийг олон өнцгөөс авч үзэхээс илүүтэйгээр хүмүүс хуулийг хэрхэн ойлгож, хэрхэн хэрэглэх арга замыг нэгтгэсэн ерөнхий байр суурь бий болгохыг зорьж байна. Харин угсаатан зүйн судалгааны арга нь эсрэгээрээ нарийн төвөгтэй, зөрчилдөөнтэй, эсрэг тэсрэг ойлголтыг тайлбарлахыг зорьдог. Антропологичид ихэвчлэн бодит байдлын цаадахыг харах гэж, нүдэнд үзэгдэхгүй гарт баригдахгүй зүйлсийн талаар шинэ таамаглал дэвшүүлж, тухайн орон нутагт тодорхойгүй хэвээр байгаа зүйлсийн илэрхий байгаа хэсгүүдийн хоорондын холбоосыг олох гэж удаан хугацаагаар судалгааны талбай дээр ажилладаг билээ (Дрэш ба Жэймс 2000:23).

Хуулийг антропологийн талаас авч үзэх нь

Антропологичдын хувьд хуулийн мөн чанар ба оршихуйн аль алиныг нь шууд хүлээн зөвшөөрч чадахгүй. Бид судлах үйлдэл, тэдгээр нь эрх зүйн үзэгдлүүдийн талаар хэрхэн эргэцүүлдэг, эдгээрийг хэрхэн зохих ёсоор ашиглаж болох тухай дүн шинжилгээний ангиллын талаар ямагт судалж байх шаардлагатай. Үнэн хэрэгтээ дэлхийн олон оронд "хууль" гэсэн нэршлийг тийм ч зөв хэрэглэдэггүй. Бидний судалж буй хүмүүс хуультай байдаггүй тэдгээрийг бүтээдэггүй бөгөөд бидний үзэж байгаа хуулийн талаарх ухагдахууныг сайтар харуулсан ангилал байдаггүй. Хэдий бидний сайн мэддэг франц, германы ойлголтууд болох *la loi* болон *le droit* эсвэл *das*

² Жишээ нь, Зүүн Түвдийн бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг хүмүүсийн дунд хийсэн судалгааны ажлуудаас ялгаатай нь эдийн засагч Эндрю Фишерийн (2004, 2008, 2009) хийсэн гайхалтай судалгааг дурдаж болно.

Gesetz болон *das Recht* хоёрын хоорондох ялгаа нь англи хэл дээрх хуулийн үзэл баримтлалтай яг таардаггүй билээ. Эртний Грекийн эрдэмтэд *nomos* гэдэг үгийг ямар тохиолдолд "хууль" гэж орчуулж болох талаар урт удаан хугацаанд маргаж ирсэн (Gagarin 2005) бөгөөд энэ нь тийм шинэ үзэгдэл, асуудал биш юм. Эртний Грекчүүд (*nomos, dikaion*), Ромчууд (*ius, lex*) болон дундад зууны үеийн зохиолчид латин хэл дээрх нэр томъёог оновчтой ашигладаггүй байсан бөгөөд тэдгээр нэр томъёоны хооронд яг дүйцэх ижил төстэй ойлголт байгаагүй (Бранд 2012: 59–64; Кантор).

Хууль гэдэг нь англи хэлээр ярьдаг улсуудад хамаарах хэллэг бөгөөд энэхүү хэлний үүслийн түүх нь илүү эрт үеэс улбаатай хэдий ч, хүн төрөлхтний орчлон ертөнцийн түүхийг агуулж байгаа гэж үзэхэд хэт өрөөсгөл юм. Тиймээс тайлбар, дүн шинжилгээ хийхэд өөр бусад нэр томъёо шаардлагатай байж магадгүй.

Хууль нь дэлхий даяар ижил шинж чанартай байдаггүй, мөн ижил идеал руу тэмүүлдэггүй. Үнэн хэрэгтээ олон нийгэмлэг хууль дээдлэх ёс эсвэл эрх зүйн тогтолцоонд хамаарах зүйлгүйгээр ямар ч асуудалгүй оршин тогтнодог гэж санагддаг. Антропологичид бодит тохиолдлыг нарийвчилан судлах аргачлал, сайн харьцуулалтыг ашигласнаар нийгэм, газарзүй, соёлын янз бүрийн үзэгдлийг ойлгох, тэдний соёлын онцлог шинж чанарыг судлах, нийгэм, газарзүй, соёлын ялгааг олж илрүүлэх, хуулийн тодорхой дүр төрхийг бий болгосон түүхэн нөлөөг тодруулах боломжтой гэж үзэж байна. Хуулийн нэр томъёо, тодорхойлолтын талаар нэгдсэн ойлголтгүй, маргаантай байх тул хэд хэдэн судлаачид дүн шинжилгээ хийх зорилгоор болон судалгааны салбарыг тодорхойлох үүднээс энэхүү нэр томъёог хэрэглэхээс зайлсхийж байсан хэдий ч бид хууль гэж юу вэ гэдэг асуултын хариултыг эрэлхийлсээр байна. Хавсарга шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн судлаачид энэ нэр томъёог ашигласнаар байгаа бөгөөд олон нийт хууль дээдлэх үзэл санааг 21 дүгээр зуунд улс төрийн идеал болох ёстой гэж нийтээр хүлээн зөвшөөрөх болжээ. Мөн үүний зэрэгцээ уугуул иргэд өөрсдийн өмч, соёл, эрхээ хамгаалах талаар хууль ёсны шаардлагыг ч мөн тавьдаг болсон байна.

Хуулийн мөн чанарыг судлах нь орчин үеийн, англи хэлт соёл бүхий улсуудыг судлахаас эхэлнэ. Энд хууль нь төрт улсын хэмжээнд үзвэл чухал ач холбогдолтой, нягт холбоотой болсон боловч бид англи хэлээр ярьдаггүй бусад орны хүмүүс бидэнтэй адилхан хуулийн зохицуулалт дор аж төрнө гэж үзэж болохгүй. Тодруулбал, бид эрх зүйн түүхээ болон дэлхийн бусад орнуудын хувьд ч өөрсдийн орны хууль гэх ойлголтоор тайлбарлаж болохгүй. Бид дэлхийн бусад улс орнууд, тэр дундаа өөрийн эрх зүйн түүхийг ижил нэр томъёогоор тайлбарлахгүй байх талаар анхаарах нь зүйтэй.

Энэ бол улс төрчид, бодлого боловсруулагчид, олон нийт, эрх зүй судлаачдын бүгдийнх нь өмнө тулгардаг аюул боловч чухамдаа эрх зүй судлаачид нь уг асуудлыг шууд шийдвэрлэх нөөц бололцоотой субъектүүд юм. Жишээлбэл, Макс Вебер хуулийг хүний зан үйлийн бодит хүчин зүйлээр тодорхойлж байв (1968: 312). Энэхүү номын сүүлчийн бүлгүүд дэх дундад зууны эхэн үеийн Европын хууль тогтоомж, Түвд, Африкийн хойд хэсэгт орших тосгодын хуулийн жишээнүүдээс харахад шүүгчийн шийдвэрт, эсхүл өдөр тутмын амьдралд ямар ч нөлөө үзүүлдэггүй хууль тогтоомжтой төстэй хэм хэмжээнүүд нэлээд байдаг тухай жишээнүүд гарна. Дундад зууны эхэн үед амьдарч байсан эрх зүйн түүхч Вормальд (1999) тайлбарлахдаа бичиг үсэггүй хүн амын дунд германик, англо—саксоны удирдагчдын боловсруулсан хууль тогтоомж практик ач холбогдолгүй, шүүх ч авч ашигладаггүй байсан. Антропологич Паул Дреш (2006) Йемен омгийн бичиг баримт дээр судалгаа хийж, ажиллаж байхдаа омгийн гишүүн хоорондын нарийн төвөгтэй харилцааг "легалистик" үүднээс тусгасан хэд хэдэн гэрээ хэлэлцээр олжээ. Эдгээрийг хууль ёсны дүрэм журмаас өөр зүйл гэж тодорхойлохын аргагүй байжээ. Тодруулбал, үүнд хүмүүс бие биенээсээ тусламж хүсэх, нөхөн олговор шаардах нөхцөлүүдийг заасан байх бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхэд аливаа төр, эрх мэдэлтнүүлийн оролцоо тусгагдаагүй байсан (Дреш 2006:295). Хууль тогтоомжийг захирагчаар баталгаажуулж, хэрэгжүүлэх шаардлагатай, бүрэн тодорхойлогдож, практик хэрэглээг нь үнэлэх боломжтой гэсэн хуульч эрдэмтдийн таамаглал эргэлзээ төрүүлэхүйц хууль болон хуультай адилтгах зүйлсийн жишээ бидэнд байна.

Эрх зүй судлаачид хуульчид, антропологичдын үзэж байгаагаар зарим улс орны нийгэм аливаа маргааныг зохицуулахдаа хууль тогтоомжгүйгээр сайн шийдвэрлэгддэгээс үл хамааран эрх зүйн дүрэм журам болон төрлүүд нь нийгэм дэх буруу зүйлсийг тодорхойлж, үр дагаврыг нь тогтоож, зөрчилдөөнийг шийдвэрлэдэг гэх ойлголт хүчтэй хэвээр байна (Маркби 1905: 21; Салмонд 1920: 13; Иванс—Ричард 1940: 162). Би Ладак тосгонд хээрийн судалгааны ажил хийж байхдаа тосгоны иргэд маргаанаа шийдвэрлэхийн тулд ямар нэгэн дүрэм журам баримтлах шаардлагагүй, эсвэл буруу үйл хийсэн гэм буруутай хүнд ямар нэг сахилгын шийтгэл оноох шаардлагагүй байгаа нь ажиглагдсан юм.

Би Ладаки тосгоны бичил улс төрийн байгууллага болон зөрчилдөөнөөс үүдэх үр дагавраас айх айдас зэрэг ёс суртахууны өндөр мэдрэмжээр нийгэмлэгийн үнэт зүйлийг бүрдүүлсэн байгааг олж илрүүлсэн. Аливаа маргааныг эрхийн зөрчилтэй холбон шийдвэрлэхийг тосгоны оршин суугчид хөршүүдийн хооронд түнжин хагалсан зүйлд тооцон үздэг бөгөөд үүний оронд торгууль төлж, эвлэрүүлэх ёслолын арга хэмжээ зохион байгуулдаг. (Пири 2007b: 4—р бүлэг) Ойролцоох тосгонд хээрийн судалгааны ажил хийж

байсан нэгэн антропологич надаас бэлгийн хүчирхийллийг зохицуулдаг ямар нэгэн тосгоны "хууль"—ийн талаар олж мэдсэн эсэхийг асуусан юм. Түүний "хүчингийн хэрэг" хэмээн тодорхойлсон эмгэнэлт хэрэг дээр нэгэн охин төрөхийн хүндрэлээр нас барж, хүчирхийлэл үйлдсэн залуу нь охины ар гэрийнхэнд болон тосгоны гэм үйл ариусгах зан үйлийн санд нэг нөхөн төлбөр л төлөөд өнгөрчээ (Гатчовчов 2004: 410–26).³

Улмаар ийм "зөрчил"—тэй холбоотой нутгийн ямар нэг дүрэм журам, хууль тогтоомж байгаагүй нь судалгааны явцад тодорхой болсон юм. Зодоон, тэр ч байтугай "хүчирхийллийн хэрэг"—ийг "гэмт хэрэгтэн", "хохилогч" эсвэл "хүчирхийлэгч"—тэй холбоотой гэмт үйл явдал гэхээсээ илүү хоёр өрх хоорондын аливаа маргаантай, үл ойлголцох харилцаанаас үүссэн зүйл гэж үздэг байжээ. Өөрөөр хэлбэл, Ладак тосгоны оршин суугчид эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар нэг хийсвэр дүрэм журмыг хэрэглэх шаардлагагүй гэж үзэж байсан (Пири 2002: 253–56).

Эрх зүй судлаачид хууль гэж үздэг ойлголтоо тодорхойлохын тулд институц (Раз 1970), ёс суртахуун (Фуллер 1964; Финнис 1980), дүрэм (Харт 1994)—ийн тухай ойлголтын талаар онцлон тэмдэглэдэг. Харин антропологичид ихэвчлэн үүний эсрэг жишээ гаргадаг. Хууль тогтоомжийг ямар нэг улс төрийн тодорхой эрх мэдлийн хүрээнд бус шашны эрдэмтэн ч боловсруулж болдог. Жишээлбэл, Дэвис (2010) үзэхдээ эртний Хинду бичвэр нь төрөөс батлагддагаас илүүтэй оюуны тогтолцооны хүрээнд буюу эртний Ромын эрх зүй судлаачдын баталсан хуультай илүү төстэй. Нөгөөтэйгүүр удирдагчдын дур зоргын үйлдэл, зан авирыг шийтгэх ёстой гэсэн Хинду санааг Буддын шашны эрдэмтэд нэвтрүүлсэн боловч энэ нь өөрөө буддын шашны ёс суртахууны зарчмыг зөрчсөн гэж үзсэн байна (Зиммерман 2006). Английн эх газрын эрх зүй бол илэрхий дүрэм журамд суурилсан тогтолцоо биш юм (Симпсон 1987). Хэрэв эдгээр нь хуулийн жишээ юм бол чухам ямар онцлог шинж чанар дээр үндэслэн ингэж үзэж байна вэ? Институцийн үүднээс биш юм бол дүрэм журмын хэлбэрийн үндсэн дээр үзэж байна уу? Хэрэв ёс суртахуун дээр үндэслээгүй юм бол оюуны хийсвэрлэл үү? Хатуу тогтоосон дүрэм журам биш юм бол зөвхөн учир шалтгааны эргэцүүлэл үү? Уолдрон (1995:635) хэлэхдээ "Философи" гэдэг бол "бидэнд хачирхалтай санагдсан зүйлсийг илүү энгийн, дөхөм байдлаар ойлгуулах үйл ажиллагаа юм" гэжээ. Антропологийг үүнтэй мөн адил тодорхойлж болох юм. Бодит тохиолдлын судалгаа нь зөвхөн дэлхий ертөнцийн тухай мэдээлэл өгөөд зогсохгүй энэ талаарх бидний таамаглалыг эргэцүүлэн бодоход хүргэдэг.

³ Охиныг нь хүчирхийлсэн залуутай түүний аав нь амьдралын сүүлийн жилүүддээ нэг дор хамт ажиллаж байсан талаар Гучоу дурджээ. Тосгоны оршин суугчдын хувьд энэ бол олон нийтийн харилцааны уур амьсгалыг эерэг хадгалж, хэвээр байлгах нь чухал асуудал байв.

Тэгвэл антропологичдын хувьд хууль судална гэж юу гэсэн үг юм бэ? Монаган, Жаст нарын (2000:2) хэлдгээр "тодорхой ард түмэн, газар нутгуудад хийсэн антропологичдын тодорхой судалгаанаас олж мэдсэн баялаг мэдээлэл" нь хуулийг шинжлэх судлах дэндүү олон хувилбар бий болгох уу?

Хуулийг политемик талаас үзэх нь

Венди Жеймс (2003:55) философийн дүн шинжилгээ хийхэд хүртэл: Тодорхой эхлэлийн цэгээс давсан цэвэр метафизик таамаглал дээр үндэслэх шаардлагагүй, харин одоо үеэс эхлэн бүхий л цаг хугацааны туршид хүн төрөлхтний сэтгэж байсан ойлголтууд дээр үндэслэн нарийн ажиглалт хийх ёстой гэсэн байна.

Аллен (2000:245) нийгмийн антропологийн зорилго бол "бидний мэдэх боломжтой нийгэм, соёлын бүх хэлбэрийг судлах" явдал хэмээн энгийнээр тайлбарласан. Бид "хууль" гэх ойлголтыг нэг тодорхойлолтоор тайлбарлах зүйл гэж ойлгож болохгүй, харин мөн чанарыг нь олж мэдэхийн тулд эмпирик жишээнүүд ашиглаж, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, нийтлэг байдлыг судалж, хэдийний танил болсон барууны жишээнүүдээс давж сэтгэх учиртай. Бид өөрсдийн "хууль"—ийн тухай ойлголтынхоо утга учир, хэрэглээ, тэдгээрийг хэрэглэдэг нөхцөл байдлыг орхигдуулалгүйгээр асуудал дэвшүүлэн судлах хэрэгтэй.

Витгенштейний сүүлийн үеийн философийн үзэл баримтлалыг ашиглахын тулд бид хуулийг өөр хоорондоо "гэр бүлийн гишүүдийн ижил төстэй байдал"—аас хэтрэхгүй үзэгдэл хэмээн үзэж болно. Түүний тайлбарласнаар "бид ижил төстэй байдлын давхцал ба хөндлөн огтлолын хоорондох нарийн төвөгтэй холбоосыг чухалчилж авч үзэх хэрэгтэй: зарим тохиолдолд ерөнхий ижил төстэй байдал, зарим үед нарийвчилсан ижил төстэй байдал гэх мэт" (1958: 32). Гэхдээ тодорхойлох дан ганц тодорхойлолт байх боломжгүй. Хэрэв "хууль" гэсэн нэг л тодорхойлолт эрэлхийлэх юм бол гарал үүсэл, зүй тогтол, чиг үүргийн талаар буруу асуудал дэвшүүлж, хуулийн мөн чанарыг олж илрүүлж чадахгүй. Хэрэв бид өөрсдийн үзэл баримтлал, түүний хэрэглээг зохицуулдаг хэлний дүрмийг ягштал дагаж мөрдөх юм бол энэ олон янз байдлыг танин мэдэж судлах ёстой болно.

Гэхдээ аливаа нэр томъёог ашиглах, дүн шинжилгээ хийх зөв, буруу арга замууд байдаг. Тухайн зүйлийн үзэл санаанд ашиглах аргачлал, тодорхойлолт нь нарийвчлалтай байх шаардлагагүй юм (Витгенштейн 1958:39–40). Хэрэв судалж буй бүлэг зүйл нь жишээлбэл, хууль хийсвэр байх юм бол хийсвэрлэх судалгааны арга нь ээдрээ төвөгтэй байдлыг улам даамжруулна. Хэдий тийм ч мөн чанарыг нь олж мэдэхийн тулд зайлшгүй судлах шаардлагатай. Тэгвэл ийм маягийн судалгааг хэрхэн хийх вэ? "Хууль" гэх энгийн ойлголтоос илүүтэй

том зүйлийг эрэлхийлж байна. Родни Нидхэм (1975) гэр бүлийн гишүүдийн ижил төстэй байдлын тухай Витгенштейний ойлголтыг улам таньж мэдэхийн тулд, мөн үүнд антропологичдод тулгарч буй бэрхшээлүүдийг багасгахын тулд "политетик ангилал" гэсэн нэр томъёог гаргажээ. Энэ бол ижил төстэй байдлаас бүрдсэн ангиллыг нэгтгэн судлах тухай бөгөөд "энэ нь хүний бүхий л чадавхыг судлахтай адил мөн хуулийн салбаруудыг судлахад хэрэгтэй" ойлголт гэжээ (1975: 352). Харьцуулалтын арга нь зарим нэг сорилтуудыг бий болгодог. Судлах хувилбаруудын тоог багасгах бус харин аль болох олон хувилбар байлгахад тохиромжтой судалгааны аргачлал шаардлагатай (1975:362). Эргэлзээтэй, маргаантай судалгааны зүйлс үргэлж л байдаг.

Хуулийн хувьд гэр бүлийн ижил төстэй байдлыг бий болгодог үзэгдлүүдийн давтагдах онцлог шинж чанаруудыг хайж олохыг нэг талаас зорих боловч үүний хажуугаар нийтлэг эсвэл чухал шинж чанаруудыг мөн олох боломжтой. Улс, хуулийн институци, мөрдөгдөх хэм хэмжээг тодотгох, хил хязгаарыг сорихын тулд завсрын шинжтэй жишээнүүдийг авч үзэх боломжтой.

Түүнчлэн бид эрдэмтдийн хийсэн судалгааны ажил, легализмын хүлээн зөвшөөрдөггүй зүйлс, нутагшуулан авсан эрх зүйн тогтсон хэв маяг гэх мэт бидэнд танил болсон жишээнүүдээр өөрсдийгөө хязгаарлавал анзаарагдахааргүй онцлог шинж чанаруудыг тодруулан, давтагдсан агуулга, уялдаа холбоог нь судлах хэрэгтэй. Хууль гэж нэрлэдэг түгээмэл тогтсон ойлголтод гагцхүү анхаарлаа хандуулвал бид холбогдох уялдаа холбоо, ялгаатай байдлыг харж, өнгөц таамаглалыг няцаах боломжтой болно. Ийм байдлаар бид өөрсдийн судалгааны үзэл баримтлалаас гажихгүйгээр тодорхой бус, олон талт ойлголтыг шинжлэн судалж болох юм.

Уг судалгааны зорилго нь танил болсон жишээнүүдээр зөвхөн хязгаарлахгүйгээр хуулийн онцлог шинж чанарыг илэрхийлэх парадигм, аналитик ойлголтыг тодорхойлох явдал юм. Дараагийн бүлэгт "хууль" гэдэг энгийн хэллэгийн хүрээнд багтах өргөн хүрээний ойлголтын талаар авч үзэх болно. Институц, чиг үүрэг, үзэл санаа, тогтсон хэлбэрээр илэрхийлэгдсэн эсэхээс үл хамааран ганц ч санаа онцлог шинж чанарыг агуулж, хуульд үл хамаарах жишээнээс ялгах боломжгүй. Хэдий тийм ч ажиллагаанаас илүүтэй тогтсон хэв маяг, захиргаадалтаас илүүтэй дүрэм журам, зөрчилдөөнийг шийдвэрлэхээс илүүтэй легализмыг баримтлах зэрэг шинжүүд нь хуулийг бусад нийгмийн үзэгдлээс ялгаж салгаж байгаа хэрэг билээ.

Хуулийг эрх зүйн антропологийн талаас үзэх нь

Хууль ба нийгэм судлал нь хууль гэж юу болох талаар авч үзэхээс илүүтэй хууль ямар үүрэг гүйцэтгэдэг талаар авч үзсээр ирсэн билээ (Силбэй 2005:

324). Абел (1995) "Law and Society Reader" номынхоо удиртгал хэсэгт бичсэнээр нийгмийн шинжлэх ухаанчид хуулийн талаар дүрэм журмаас бусад бүхий л ойлголт болох хуулийн институц, бүтэц, үйл явц, зан үйл, хувь хүн, соёл зэрэг талаас нь судалдаг. Гэвч ингэснээр нийгмийн үзэгдлийн нэгэн чухал хэсгийг орхигдуулж болох юм. Дүрэм журам нь нөлөө болон эрх мэдлээс гадна юу илэрхийлдгээрээ нийгмийн амьдралын нэг хэсэг болдог. Эрх зүйн дүрэм журам нь нийгэм хэрхэн, ямар байх ёстойг тодорхойлдог ба ёс суртахууны дэг журмыг олон нийтэд илэрхийлж таниулдаг. Энэ хэсэгт би хууль зүйн антропологичдод тулгардаг үндсэн сэдвүүдийг хянаж үзээд эрх зүйн эргэцүүлэл, аргумент болон холбогдох бусад бичвэр зэрэгт илүүтэй төвлөрөхөд туслах болно.⁴

Эрх зүйн антропологичдын хийсэн анхны судалгаануудын ихэнх нь зөрчилдөөнийг шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлах, шүүн таслах ажиллагаатай холбоотой байсан (Мур 2001). Дүрэм журмаар зохицуулагддаг ба процессын парадигмуудын хоорондох ялгааг эрх зүйн процессыг ойлгох байдлаар тайлбарласан Комарофф, Робертс нарын (1981) судалгаа антропологичид болон бусад эрдэмтдийн дунд үр нөлөөтэй байсан (Таманаха 2001:50). Хоёрдугаар бүлэгт дурдсаны дагуу барууныхнаас бусад нийгэмд хийгдсэн улсын шүүх, хууль тогтоомжийн практик, хэрэглээний талаарх угсаатан зүйн судалгааны ажлыг баруунжсан орнуудад ижил төстэй байдлаар хийсэн байна. Үндэсний болон олон улсын шүүхэд шийдвэрлэгдэж буй уугуул иргэдтэй холбоотой хэргүүд бусад орны шүүх ажиллагааны нэгэн адил олон нийтийн анхаарлыг татсаар байна (Фриман, Напир нар 2009).⁵ Снайдерын (1981: 145) дурдсанчлан энэхүү судалгааны ажил хуулийг үндсэн ойлголт, дүрэм журмуудынх нь хамтаар судалгааны судлах зүйл хэмээн үзэхээ больж, процедур, стратеги, үйл явцын дүн шинжилгээнд харьяалуулах болсон. Хууль уг судалгаанд тодорхой үүрэг гүйцэтгэж ч болно, үгүй ч байж болно. Харин яг хэдийд, хэрхэн хэрэглэх вэ гэдэг нь илүү ач холбогдолтой байх юм. Эрх зүйн аргументын онцлог юунд оршдог вэ? Хүмүүс үүнийг хэрхэн, ямар учраас ашигладаг вэ? Мөн ямар үр дүн, нөлөө үзүүлдэг вэ?

Нийгмийн зохицуулалт, дэг журмыг сахиулах нь эрх зүйн антропологиийг хөгжүүлэх бас нэг чухал сэдэв болсон юм. Мурын (1973) дүрслэн тайлбарласан эрх зүйн олон ургальч үзлийн талаарх нэгэн нөлөө бүхий судалгаа болох хагас автономит нийгмийн талбарын тухай цаашид хоёрдугаар бүлэгт дурдах болно. Эмпирик судалгааг нийгмийн хэм хэмжээнд үндэслэх санаа нь одоо ч нийтлэг хэвээр байна. Жишээлбэл, эмпирик үзлийг дэмжигч

⁴ Энэ бол эрх зүйн антропологиин дүгнэлт биш харин түүний нийтэд нь дүгнэн харуулсан тойм зураглал юм. Тиймээс миний энд дурдсан судалгааны ажил нь өргөн цар хүрээтэй цогц судалгаа гэхээсээ илүүтэй үүнийг дүрслэн харуулахыг зорилоо.

⁵ Исламын бүс нутагт хийсэн судалгаануудад жишээлбэл, Хирш (1998), Боуэн (2003), Стайлс (2009), фон Бенда—Бекманн (2009) нарын судалгааг дурдаж болно.

эрх зүйн онолч болох Мур (2005)—ийн хэлснээр эрх зүйн антропологи нь заавал дагаж мөрдөх дүрэм журам, хэм хэмжээг мөн судлах ёстой гэж үзсэн ба Донован (2007) хууль бол нийгмийн олон хэм хэмжээний зөвхөн нэг хэсэг нь гэж тодорхойлжээ (Таманаха 2001; Твинин 2009). Гэвч хууль нь зохицуулалтын хэлбэр, дүрэм журмын үндэс суурь болохынхоо хувьд ямар онцлогтой вэ? Мур (2005:1)—ийн үзсэнээр улсын хууль тогтоомжууд нь зохион байгуулалттай нийгмийг бий болгох дэг журмын цор ганц эх сурвалж биш юм. Эрх зүйн олон ургальч үзлийн талаарх маргаан тасралтгүй гарч, үргэлжилсээр байгаа. Дээрх ойлголтууд дундаас хууль гэж чухам юу вэ гэдгийг тодорхойлоход бэрхшээлтэй байна. Таманаха (2001:8) болон бусад эрдэмтэн судлаачид нийгмийн дэг журмыг тогтоодог олон төрлийн эх сурвалжийг таньж, судлах ёстой ба хууль тогтоомжийг аналитик байдлаар судлах шаардлагатай гэж үзжээ.

Нэр томьёо, агуулгын тодорхойлолтын талаар авч үзэхээ түр азнаж, түүх болоод эрх мэдлийн харилцааны өргөн хүрээнд эрх зүйн дүн шинжилгээ хийж, судлах тухай санааг Старр ба Коллиер (1989) нар дэвшүүлсэн байдаг. Харин Надер (1997, 2002: 3—р бүлэг) хууль бол зохицуулах үйл явц байх ёстой хэмээн байр сууриа илэрхийлсэн. Энэхүү судалгааны ажлын дийлэнх хэсэг нь эрх зүйг колоничлолын үе ба колоничлолын дараах динамик нийгэм (Мэрри 2003; Дариан—Смит 2007:xii), ил ба далд империализм (Маттеи ба Надер 2008) талаас төдийгүй мөн түүнчлэн зохицуулалт буюу хяналтын нэг хэсэг болох талаас нь судлахыг зорьсон билээ (Мэрц ба Гүүдаль 2012:78). Империализмын талаарх асуудлууд буюу Дарьян—Смит (2007:xiii)—ийн нэрлэснээр дүрэм журмыг үл ойшоох, эрх мэдлийн харилцаа суларч задарч буй өөрчлөлт нь эрдэмтдийн анхаарлыг татаж чадахуйц өргөн хүрээтэй, чухал сэдэв болоод байна. Гэхдээ антропологичид хуулийг антропологийн нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрөөд зогсолгүй илүү гүнзгийрүүлэн судлах ёстой юм. Хууль нь эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болсноор эрх мэдэл хэрэгжүүлэх болон үүрэг гүйцэтгэхэд ямар онцлогтой вэ? Надерын хувьд хууль нь "хүлээн зөвшөөрөгдөх зүйлсийг тогтоодог" (2005:199) гэсэн бол харин Бенда—Бекманн нар (2009:2—3)—ын хэлснээр хууль гэдэг нь "шударга ёс", "эрх мэдэл", "эрх" гэх мэт ойлголтуудын утгыг бүтээж, түүнийг заавал дагаж мөрдөх шинжтэй болгодог гэжээ. Гэвч сүүлийн тодорхойлолтоос харахад хууль тогтоох эрх мэдлийг хэн хэрэгжүүлэх талаарх асуудал маргаан дагуулах боломжтой. Хууль нь дээрх ойлголтуудыг хэрхэн тодорхойлж, хэрхэн хууль ёсны болдог вэ? Хэрэв бид тэдгээрийн хоорондын холбоог илүү сайн ойлгоё гэвэл хуулийг эрх мэдлээс салган ойлгох хэрэгтэй.

Антропологийн бүтээлүүд нь мөн хуулийг эрх мэдэл эсэргүүцэх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох арга хэрэгсэл болгон ашиглах тухай өөр чухал судалгаануудыг багтаадаг. Эдгээр судалгааны ихэнх нь колоничлолын нөхцөл

байдлын үетэй холбоотой бөгөөд өмнө дурдсанчлан наймдугаар бүлэгт хүний эрх, шилжилтийн үеийн шударга ёсны тухай үзэл санааны талаар дэлгэрүүлэн дурдах болно. Хууль болон эрх зүйн ангиллын антропологийн судалгаанууд нийгмийн анхдагч үзэгдлүүдэд зүй ёсоор нь хандахгүй байсан буюу хүмүүст өөрсдийн "эрх"—ээ хамгаалахын тулд хэрхэн боломж олгодог байсныг тодорхойлж чаддаггүй. Энэ нь ялангуяа хүний эрхийн хувьд үнэн боловч колонишлолын дэглэмийн үед ч гэсэн зарим хүмүүс "өөрсдийгөө иргэншсэн хүн төрөлхтөн болгон бүрдүүлэхийн тулд хаант засаглалын эрх зүйн зохицуулалтуудыг өөрт ашигтай байдлаар өөрчлөх" боломжтой байсан (Мэрри 2003:578). Сүүлийн бүлгүүдэд дурдах түүхэн жишээнүүдэд эртний Грекчүүдээс эхлээд XVIII зууны Английн эрдэмтэн И.П.Томпсоны хийсэн судалгаанаас үзвэл хууль нь хэзээ ч хүчирхэг хүмүүсийн зэвсэг байгаагүй, мөн эсэргүүцлийн хэрэгсэл ч байгаагүй, харин хоёуланг нь нэгэн зэрэг агуулж байсныг харуулдаг. Мур (2001:103—06)—ын онцлон тэмдэглэснээр, хуулийг эрх мэдэл тогтоох ба эрх мэдлийг эсэргүүцэх хэлбэр байсан тухай жишээгээр эдгээр үзэл санааг бүхэлд нь дүгнэж ойлгоход дэндүү явцуу болох юм. Эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсэргүүцэхийн аль алинд нь хууль ашиглагддаг гэхээр хууль ямар утгатай болох, үүнийг эрх мэдэл хэрэгжүүлэх эсвэл хяналт тавихын тулд ашигладаг хүмүүсийн эсрэг хэрхэх вэ? гэдэг асуултыг тавих хэрэгтэй болж байна.

Үүнтэй төстэй үзэл санаа нь олон улсад мөн хэлэлцэгддэг бөгөөд энэ нь антропологийн судалгааны сэдэв болжээ. Энэ талаар дараагийн бүлгүүдэд өгүүлэх болно. Мерц ба Гудале (2012: 87—88)—ийн хэлснээр соёлын ялгаатай нутгийн, үндэсний болон олон улсын хууль тогтоомжийн огтлолцлоос үүдэлтэй орчин үеийн дэлхий ертөнцөд эрх зүйг ойлгоход нарийн төвөгтэй байдал бий болж байгаа бөгөөд үүнээс "соёл хоорондын хуулиудыг нэгтгэн судлах" шаардлага үүсэж байна. Гэвч үүнийг хэрхэн нэгтгэж судлах вэ? Зарим антропологичид олон улсын эрх зүй дэх эрх зүйн (эсвэл норматив эрх зүй) олон ургальч үзэл санааг судлахыг зөвлөдөг. Мэрри (2006а: 108) мэдлэгийн практикт анхаарлаа хандуулахыг санал болгож байгаа бөгөөд угсаатан зүйн судалгааны аргыг ашиглах нь олон улсын эрх зүй судлалд ихээхэн хувь нэмэр оруулж чадна гэжээ. Гэхдээ бид "олон улсын үйл ажиллагаа, тэдгээрийн түүх, бүтцийн гарал үүслийг тодорхойлдог утга санааны тогтолцоо" гэж түүнийг тодорхойлж буй хязгаарлагдмал орон зайн практикаас хальж цааш өргөн хүрээнд судлах хэрэгтэй (2006а:106). Хэрэв хууль нь өөр өөр соёл иргэншлийн олон улсын харилцааг бий болгодог, эсхүл бүрдүүлдэг бол хэрхэн ингэдэг, мөн уг хэлбэрийг бий болгож буй агуулга буюу утгын тогтолцоог судлах хэрэгтэй.

Хууль зүйн хэл бичгийн судлагдахуун үүнд нэлээн дөхөм хариулт өгөх болно. Олон антропологичдын үзэж байгаагаар хууль бол аливаа зүйлийг мэдүүлэх практик буюу арга техник бөгөөд эдгээр нь юуны түрүүнд тухайн үндэстний

хэл бичигт хэлбэржин буудаг (Мерц 1994; Мунди 2002:xxiv). Хууль гэдэг нь юу үнэн бэ гэдгийг тогтоож, түүнийг таниулах тогтолцоо болдог. Эрх зүйн хэм хэмжээ, үзэл баримтлал болон нийгэмд тогтох хэвшил нь бичгээр болон баримт бичигт тодорхой тусгагдаж, төрийн болон ёс суртахууны тусгал болж, үнэний хэлбэрийг бий болгосноор өөрөө бүрэлдэн тогтож, хэрэгждэг (Рилэс 2004; Мэрри 2006а: 108). Грийнхаус (2008: 82)–ын ажигласнаар хууль ёсны үнэнийг тогтоох нь тухайн нарийн зүйлийг ерөнхий болгож тодорхойлох асуудал бөгөөд энэ нь энэхүү номоор илэрхийлэхийг зорьсон чухал ойлголт билээ. Тэгэхээр хууль тогтоомж нь ийм байдлаар нийгмийг зөвхөн зохицуулж хянадаггүй, харин нийгмийг бүрдүүлж байдаг зүйл юм. Үүнээс гадна хуулиар зөв, шударга зүйл гэж юу болохыг тодорхойлдог ба хэл бичгээр дамжуулан гадагш илэрхийлэгддэг. Ийнхүү эрх мэдэл болон төрөөс давсан үнэт зүйлсийг өөртөө багтааж чадсанаар хууль ёсны эрх мэдлийг хэрэгжүүлж, түүнийг эсэргүүцэх, эсвэл хянахын аль алинд нь үйлчлэх боломжтой болдог.

Эрх зүйн антропологи нь тухайн нутгийн динамик, хүрээ, анхдагч үзэл бодол, сэтгэлгээ, эсвэл эрх мэдэл, ноёрхол, эсэргүүцлийн талаар илүү өргөн хүрээтэй асуудлуудыг ойлгоход хувь нэмрээ оруулахаас гадна мөн эдгээр олон ургальч үзлийн санааг таньж мэдэх боломж олгоно. Хууль зүйн хэл бичиг болон легалистик шинж чанаруудын ач холбогдлыг судалснаар бид энэхүү ээдрээ төвөгтэй ертөнцөд хууль ямар үүрэг гүйцэтгэдэг, нийгмийн үзэгдлийн хувьд юугаараа онцлогтой болох тухай асуултад зохих хариултыг өгөх юм.

Легализм

Эдгээр динамик болон эмпирик жишээнүүдийн хүрээн дэх тодорхой хэлбэрийн сэтгэлгээ болон аргумент нь эрх зүйн тодорхой хэлбэр, үйл явцыг тодорхойлж болно. Легализм нь ерөнхийдөө ангилал, ерөнхий ойлголт, дүрэм журмаар хүний зан үйлийг тайлбарладаг арга хэлбэрийн хувьд нийтлэг бус нийгмийн үзэгдэл болон тогтжээ. Жишээлбэл, Стратерн (2004) Папуа Ниү Гвинейд хийсэн судалгаагаараа дараахь зүйлсийг дэвшүүлсэн байна. Тэрээр хуулийн хийсвэр, ерөнхий шинж чанарыг тэмдэглээд, үүнийг эсрэг талаас нь бодит байдлын онцлог шинж чанар, харилцаанаас ялгаатай тухай дурдсан. Эцэст нь хууль бодит байдлыг "үгүйсгэх" хандлагатай байдаг хэмээн дүгнэсэн. Хуулийг амьдрал дээр хэрэгжүүлэх үед үүсдэг хурцадмал байдлын тухай олон антропологич тэмдэглэсэн байна (Сантос 1987). Жишээлбэл, хууль нь хувь хүний онцлог шинж чанар, үнэлэмжийн талаар уялдаатай, тууштай хэлбэрийг тогтоож, бий болгодог бол хувь хүний мэдрэмж нь илүү хуваагдмал, тогтвортой бус оршин тогтнодог байж болохыг Конли (2008)

тэмдэглэсэн байдаг. Үүнийг эрх зүйн нэгэн чухал шинж чанар гэж үзэж болно: эрх зүйн хэм хэмжээ, төрөлжүүлэлт нь хорвоо ертөнцийг ерөнхий бөгөөд ихэнх тохиолдолд хийсвэр байх ойлголтоор – худалдагч ба худалдан авагч, эхнэр, нөхөр, оршин суугч, цагаач гэх зэргээр тодорхойлдог. Ийнхүү хялбарчилж, тодорхойлж, төрөлжүүлж, тодруулж өгдөг боловч цаашлаад нийгмийн үзэгдэл, харилцааг бий болгодог. Эрх зүйн ангилал нь нийгмийн үүрэг хариуцлагыг илэрхийлдэг бөгөөд ёс суртахууны таамаглалыг тусгаж, гэрлэлт, моргейж зэрэг шинэ, ихэвчлэн нарийн төвөгтэй байдаг харилцаа тогтоох боломж бүрдүүлдэг.

Энэхүү легализм нь зан байдлын зүй тогтлоор илэрхийлэгдсэн үйлийн далд зохицуулалтуудтай адилгүй юм. Үүнд: дүрэм журам, ангиллын тодорхой томъёоллыг хамруулан ойлгох бөгөөд зан төлвийн стандартыг тогтоож, зөв буруугийн тухай аргументэд ашиглаж болох дискурсив эх сурвалж болдог. Хэдийгээр зарим дүрэм журмыг албадан хэрэгжүүлж болох боловч хууль бол зөвхөн зохицуулалт биш юм: легализмыг ангилж, зохион байгуулалтын хэлбэрт оруулснаар эрх зүйн философичдын "практик үндэслэл" гэж нэрлэдэг аргументийн үндэс болдог.

Легализм нь дүрэм журамд суурилсан зохион байгуулалтын олон хэлбэрийг тодорхойлдог бөгөөд бид бүгдийг нь "хууль" гэж нэрлэдэггүй. Бид "хууль" гэсэн нэр томъёог дэг журам, шударга ёсыг бий болгохын тулд дүрэм журам болон төрөлжүүлэлт болгон ашиглах нь илүүтэй байдаг. Хуулийн олон хэлбэрт идеалист элемент байдаг бөгөөд үүнийг дараагийн бүлгүүдэд олон жишээгээр тайлбарлан харуулах болно. Сэлүүрт завь эсвэл крикет спортын дүрмээс ялгаатай нь хуулиуд бодит байдлаас ангид байх хандлагатай буюу тухайн нөхцөл байдлаасаа тодорхой хэмжээний бие даасан байдалтай байдаг бөгөөд ингэснээр тухайн цаг үеэс давсан дэг журмыг бий болгодог (Дреч 2012:15). Гэхдээ энэхүү ёс суртахуун эсвэл шашны дэг журам нь ихэвчлэн легализмд үл итгэх байдал, эрх зүйн хэлбэрийг шүүмжлэхэд хүргэдэг. Энэ хоёрын хоорондын хурцадмал байдлын талаар бид дараагийн бүлгүүдэд дахин ярилцаж, жишээгээр тайлбарлах болно.

Легализмын үзэл баримтлал нь илүү ерөнхий, маргаантай хуулийн ангилалд багтдаг үзэгдлүүдийн доторх нийтлэг сэдвийг тодорхойлох ач холбогдолтой. Мөн өргөн хүрээнд аналитик ангилалд норматив болон нийгмийн дэг журмын бүх хэлбэрийг хамруулалгүйгээр улсын хуулиас гадуур давж бодох боломж олгодог. Хууль гэж нэрлэгдэх боломжтой нийгмийн үзэгдлүүдийг бүрэн хэмжээгээр авч үзэхийн тулд бид улсаасаа хальж, түүхэн цаг үеийг ч гэсэн эргэн харах хэрэгтэй.

Хууль ба түүх

Эдгээр бүх тохиолдлуудад хууль буюу легализмыг хууль зүйн шинж агуулаагүй зүйлээс ялгаж ойлгосноор дүн шинжилгээг улам сайжруулж, нийгмийн үзэгдэл, практик, газарзүйн орон зай, цаг хугацааны тасралтгүй байдал болон тасалдалт зэргийг анхаарч үзэх боломжтой болох юм. Тухайлбал, хууль зүйн техник болон хэл зүйг зөвхөн сүүлийн үеийн эсвэл барууны үзэгдэл биш гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хуулийн түүхийг судалснаар олон зүйлийг олж мэдэх боломжтой: хуулиуд олон мянган жилийн турш олон улсын хэмжээнд хөгжиж ирсэн бөгөөд эрх зүйн орчин нь ойлгоход төвөгтэй байх нь элбэг. Түүхэн болон орчин цагийн жишээнүүд эрх зүйг бүрэн эрхт байдалтай адилтгаж, дэлхийг хууль зүйн эрх мэдлүүдэд хуваасан гэж үздэг хуулийн зүй тогтол, дэг журмын үндэс болгон харуулсан төрийн эрх зүйн тухай нийтлэг загварт эргэлзэх үндэслэл болдог. Төрт улс үүсэхээс өмнө хууль тогтоомж, эрх зүйн үзэгдэл байсан бөгөөд нийгмийн зохион байгуулалтад оруулахыг хичээж байсан нь бичгээр хадгалагдан үлджээ. Үүнд: шашин шүтлэгтэй холбоотой, ялангуяа Исламын ертөнц, эсвэл эртний түүхэн гарал үүсэлтэй Английн нийтлэг эрх зүй гэх мэт эрх зүйн үйл ажиллагаанууд багтана. Харьцуулсан түүхийн үзэл баримтлалыг ашигласан эрх зүйн антропологи нь шинэ нийтлэг загвар болон дүн шинжилгээ хийх боломж бүрдүүлдэг. Үүнд: эрх зүйн хэлбэрийн сонирхол татахуйц байдал, идеалист элементүүд буюу хуулиар дээд дэг журмыг хэрэгжүүлэх хандлагатай арга замууд нь хуулийг хэрэгжүүлэх болон нутагшуулалгүйгээр практик дахь үр нөлөө хамрагдана.

Бичмэл хуулиуд антропологиин судалгааны гол цөм байх нь ховор байсан бөгөөд нийгэм судлаачид тэдгээрийг харьцуулсан судалгаандаа бараг хэзээ ч оруулж байгаагүй. Абел (1995) тэмдэглэснээр тэд дүрэм журам, бичмэл хэм хэмжээнээс бүрмөсөн зайлсхийх хандлагатай байсан. Ингэж зайлсхийх нь бичиг үсэг тайлагдаагүй нийгэмд гарцаагүй байсан байж болох ч Христийн шашинтнуудаас гадна Хятад, Энэтхэг улсын томоохон хэсэг, Исламын шашинтнууд дэлхийн олон зууны турш бага дагагчтай шашны ном судруудаас эхлээд тосгоны хууль хүртэл бүх байдлаар ашиглахад ач холбогдол бүхий эрх зүйн бичвэрүүдийг бүтээж, ашиглаж, хуулбарлаж ирсэн байдаг. Номын сүүл хэсэгт түүхч, дорно дахины судлаачдын хийсэн легалистик бичвэр, үзэл бодлын эргэцүүллийн хэд хэдэн нарийн дүн шинжилгээг дурдах болно. Хууль нь хүмүүс өөрсдийн ертөнцийг танин мэдэхэд нэгэн чухал эх сурвалжийг бүрдүүлдэг ба антропологиичдод хуулийн мөн чанарыг судлахад баялаг материал болж өгдөг.

Эрх зүйн онол

Хэрэв антропологич хуулийн мөн чанарыг судлах гэж байгаа бол энэхүү ном нь аналитик философийн номноос хэр зэрэг ялгаатай вэ?⁶ Лэйси (2000: 18–19) хуулийг онол хэлбэрт оруулах зорилгод социологи, философийн шинжлэх ухааны оруулсан хувь нэмэр тийм ялгаатай биш бөгөөд социологиос ялгагдах зүйл нь түүний арга зүй гэхээсээ илүүтэй хуулийг нийгмийн үзэгдэл гэж ойлгох ерөнхий зарчим хэмээсэн. Галлиганы хэлснээр эрх зүйн онол нь эрх зүйн тогтолцооны нийтлэг болон чухал шинж чанаруудыг багтаасан эрх зүйн сэтгэлгээний ерөнхий хүрээг судлахыг эрмэлздэг (2010:978); ‘эрх зүйн онол нь философийн шинж чанартай ч нийгмийн зорилгын үүднээс бүтээгдэж, хэрэгжүүлсэн нийгмийн үзэгдэл байсаар байгаа’ тул нийгмийн бодит амьдралд нийцэх ёстой (2010: 991).

Эрх зүйн онолын академик салбар нь тус номын мөн чанараас гадна онолын нарийвчилсан мэтгэлцээн, үзэл санааны хуваагдлаар дүүрэн байдаг. Зарим судалгаа эмпирик жишээн дээр үндэслэдэг бол зарим нь хийсвэр ойлголтод дүн шинжилгээ хийдэг. Зарим онол нь тодорхойлохыг зорьдог бол зарим нь идеал загварыг бий болгодог. Гэхдээ тэдгээр нь хоорондоо хэд хэдэн ялгаатай.

Нэгдүгээрт, хууль бол үндсэндээ ердийн хэлний ойлголт гэдгийг хүлээн зөвшөөрдөг онолчид байдаг. Ламонд (2001:38) хууль бол бидний өөрсдийн болон бусдын нийгмийг харах өнцгийн тухай ойлголт юм гэжээ:

Хуулийн мөн чанарын тухай философийн судалгаа нь эдгээр үзэгдлүүдээс системтэй, зохион байгуулалттай ойлголт гаргаж авахыг зорьдог бөгөөд ...түүний гол шинж чанар, нийгмийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг тодорхойлдог. Энэхүү судалгаа нь бидний амьдарч буй эрх зүйн тогтолцооны практикт тулгуурласан хуулийн талаарх бидний ойлголтыг өөрийн мэдэгдэхүүний хүрээнд хийгдсэн.

Энэ нь үндсэндээ "позитивист" онолч Харт, Раз нарын баримталсан гол хандлага юм. Жишээлбэл, Харт "The Concept of Law" (1994:vi) номоо үгийн утга санаа, холбогдох хэллэгүүдийн стандарт хэрэглээг судалсан" тодорхойлох социологийн эссэ" хэмээн тодорхойлсон. Тэрбээр энэхүү ном нь эрх зүйн

сэтгэлгээний ерөнхий хүрээг тодруулсан аналитик эрх зүйн онолын бүтээл гэж хэлсэн юм. Хэрэглээг тодорхойлох нь философийн дүн шинжилгээний үндэс болдог. Раз (1998) мөн үзэл баримтлалд энгийн хэллэгээр дүн шинжилгээ

⁶ Эрх зүйн онол гэдэг нь одоо үед "jurisprudence" гэх нэр томъёогоор илэрхийлэгддэг. Эрх зүйн онол ба гүн ухааныг хооронд нь ялгаж салгаж болох ба сүүлийнх нь илүү нарийвчилсан салбар байдаг бол эхнийх нь социологи, улс төрийн шинжлэх ухаан зэрэг бусад салбаруудын онолыг мөн багтаадаг байна (Галлиган 2010: 977).

хийхийг онцолжээ. Тэрбээр ("хууль" гэх мэт) үгийг хэрхэн зөв хэрэглэхийг мэдэх болон тухайн ойлголт болох зүйлийн талаар нарийн мэдлэгтэй байх (хууль гэж юу болохыг ойлгох) хоорондын ялгааг гаргажээ. Хууль гэж юу болохыг тайлбарлах чадвартай байна гэдэг нь хууль болон бусад үзэгдэл хоорондын уялдаа холбоог харуулна гэсэн үг юм. (1998:256—57) Энэхүү ялгаа нь ойлголтыг хэрхэн зөв ашиглахаа мэдэх буюу Витгенштейний нэрлэдэгээр "хэлний тоглоом" болон уг ойлголтын мөн чанарыг нь тайлбарлах хоёрын хоорондох ялгааг харуулж байна. Ойлголтын зөв зохистой хэрэглээ нь эрх зүйн антропологийн (эсвэл бусад) аливаа дүн шинжилгээ хийх эхлэлийн цэг байх ёстой, гэхдээ зорилго нь соёл хоорондын зөв зохистой ойлголтыг тодруулах явдал юм.⁷

Бусад онолчид гаргасан таамаглалынхаа талаар тодорхой тайлбар өгүүлээгүй байж болох ч тэдгээр тайлбар нь барууныхтай төстэй эрх зүйн тогтолцооны хуулийн үндсэн элементүүд дээр үндэслэсэн байдаг. Финнис (1980:4) эрх зүйн философийн тоймдоо тэмдэглэсэнээр ихэнх онолчид нийтлэг үзэл баримтлал, ойлголт дээр тулгуурладаг гэжээ. Норматив онолын зохиолч Рональд Дворкин (1986:92) хүртэл эрх зүйн хүрээ, хуулийн практик, институцийн хувьд "тайлбарлахын өмнөх урьдчилсан шат"—ыг дэвшүүлсэн байна. Аливаа дүн шинжилгээ нь ердийн хэлний ойлголтоос эхлэх ёстой.

Харт, Раз нарын хийсэн тайлбар, дүн шинжилгээний ажлыг илүү норматив ажлуудтай харьцуулж болох юм. Жишээлбэл, Дворкин хууль бол "тайлбарлагч ойлголт" бөгөөд "манай хууль нь бүхэлдээ хуулийн практикийн хамгийн сайн зохицуулалтуудаас бүрдэж, ... эдгээр үйлдлүүдийг байж болох хамгийн сайн зүйл болгож буй өгүүлэмжээс бүрддэг" гэж үздэг (1986:vii). Тэрбээр судалгаандаа "нийтлэг эрх зүйн хэргийг шийдвэрлэх шүүгчээс ... өөрийгөө нийтлэг эрх зүйн гинжин хэлхээн дэх зохиогч гэж үзэх тухай" санааг илэрхийлдэг (1986:238). Энэ бол нийгмийн үзэгдлийн хувьд хууль гэж юу болох талаар бус, нийтлэг эрх зүйн ертөнцөд шүүгчдийн практикийн хувьд энэ нь ямар байх ёстойг асуудаг норматив судалгаа юм. Финнис (1980) эрх зүйн философичдын зорилтыг зөвхөн тодорхойлогч шинж чанартай зүйл бус ёс суртахууны хувьд үнэлж дүгнэх зүйл гэж үздэг: "Юу нь хувь хүнд сайн болох, практик үндэслэлтэй байхад юу үнэхээр шаардлагатай байх тухай үнэлэн шинжлэх ажилд оролцохгүйгээр ямар ч онолч дүн шинжилгээг хийж,

⁷ Разын хэлснээр (1996: 5; 2009: 36) бид бусад нийгмийг ойлгохын тулд тэдний үзэл баримтлалыг эзэмших ёстой, гэхдээ бид тэдгээрийг өөрсдийнхөө үзэл баримтлалтай холбож чаддаг байх ёстой бөгөөд энэ нь бусад нийгэмд хэрэглэж болохуйц ойлголтуудыг эзэмшсэн байх ёстой гэсэн үг юм. Тэрээр ердийн хэлний философийн үнэ цэнийг үл тоомсорлож байгаа боловч: "Хүн хуулийн мөн чанар болон түүний төв институцуудын талаар хэлэлцэхдээ хэлийг алдаагүй ашиглаж байгаа л бол энэ тухай ойлголтыг ахиулахад хэлний философийн хийж чадах зүйл бараг байхгүй (1998:254). Энэ нь үнэн байж болох ч хэлийг алдаагүй ашиглахад тийм ч хялбар байдаггүй. Олон антропологичид аналитик байдлаар ялгах ёстой үзэгдлийн ангиллыг төөрөгдүүлэх үүднээс "хууль" гэсэн нэр томъёоны хэрэглээг хэт өргөжүүлсэн байдаг. Раз (2009: 24)—ын хэлснээр хүмүүс үзэл баримтлалын талаар алдаа гаргаж болно гэжээ.

нийгмийн баримтуудын онолын тодорхойлолтыг өгч чадахгүй" (1980:3). Эрх зүйн онолын зорилго нь "үйл ажиллагаа явуулахад холбогдох хүмүүсийн практик эргэцүүлэлд туслах" явдал билээ (1980: 18). Уолдроны тодорхой хэлснээр, "жам ёсны эрхийн хуульч нь хуулийн үзэл баримтлалыг зөвхөн нийгмийн шинжлэх ухааныг тодорхойлох ойлголт биш, харин ёс суртахууны хүсэл эрмэлзэл гэж үздэг". (1990:35)⁸ Галлиган (2007:37) хэлснээр Дворкин, Финнис, Роулс (1971) болон Хабермас (1996) нар эрх зүйг ойлгох зорилго нэгтэй байсан боловч цааш нь хуулийг хүн төрөлхтний хамтын ажиллагааны илүү өргөн зарчим, зорилготой холбож, ёс суртахууны хүрээнд багатаахыг зорьжээ. Энэ бол антропологийн төсөл биш.

Эдгээр хандлагын ялгааг Европын олон хэлэнд байдаг la loi ба le droit, das Gesetz ба das Recht нарын хоорондын ялгааг иш татах замаар гаргаж ирэх боломжтой. Le droit нь das Recht шиг "зөв" эсвэл "шударга" гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд энэ нь хүний эрхийн утгаараа хууль гэсэн үг юм. Энгийнээр философийн болон утга зүйн асуудлын хувьд хууль бол шударга ёс шиг норматив ойлголт биш юм: хүмүүсийн дунд шударга ёсны талаар өөр өөр санаанууд байж болох юм. Жишээлбэл, татварын дахин хуваарилалт дахь нийгмийн шударга ёсны талаархи санал зөрөлдөөн. Гэхдээ шударга ёс нь дотроо ёс суртахууныг агуулдаг: ёс суртахуунгүй шударга ёсны үзэл санаа байх боломжгүй. Харин хуулийн хувьд бол байх боломжтой: хууль, тухайлбал, торгохгүйгээр баривчлах заалт, татварын шинэ зохицуулалт зэргийг шударга бус буюу ёс суртахууны зарчимд харшилж байна гэж шүүмжлэх нь утга учиртай. Хартын хэлснээр хуулийн талаар нарийвчилсан ойлголт буюу түүнийг үндсэндээ ёс суртахуунлаг хэмээн авч үзэх нь жигшүүртэй хууль байдгийг үгүйсгэх боловч "хуулийн бусад цогц шинж чанаруудыг агуулж байгаа эсэхээс үл хамааран зарим дүрэм журмыг үгүйсгэхэд хүргэдэг" гэжээ. Энэ нь эрх зүйн хөгжил болон хөгжих бололцоог ойлгох гэсэн бидний хүчин чармайлтыг сулруулдаг (1994:209–10). Хууль нь ихэвчлэн шударга ёс болон ёс суртахууныг цогцлоодог. Раз (2009:1–4)—ын хэлснээр "эрх зүйн тухай ярина гэдэг нь ёс суртахууны тухай ярьж байна гэсэн үг" буюу эрх мэдэл ба ёс суртахуун хоёр нь хоорондоо нийцсэн, нэг утгатай гэж үздэг — гэхдээ энэ нь нийгмийн үзэгдэл гэж үзэж болох хууль эсвэл хууль санаачлагчдын танилцуулгын нэг хэсэг болох эмпирик асуудал юм.

Гуравдугаарт, онолчид эмпирик жишээнүүдийг дурдаж, ашигласан хэр хэмжээгээрээ харилцан адилгүй байдаг: Лэйси (2000:19) хуулийг өөрийнх нь оршин буй нийгэм — түүхийн нөхцөл байдлаас ангид нэгэн утгын хүрээ гэж ойлгох боломжгүй хэмээн үзсэн. Үүний эсрэгээр тодорхой нэгэн онолын ёс

⁸ Вальдроны төсөл нь ихэвчлэн тодорхой норматив шинж чанартай байдаг жишээлбэл, түүний хууль тогтоомжийн идиал загварчлал нь (1995) үргэлж эмпирик болон түүхэн жишээн дээр тулгуурладаг байна.

суртахууны уялдаа холбоог голчлон авч үздэг эрх зүйн философийн үндэслэлд дүн шинжилгээ хийх нь хуулийг метафизикт үндэслэсэн буюу бодитойгоор илэрхийлдэг. (Лэйси 2000:21) Түүний судалгааны бүтээл нь аж ахуйн нэгжийн эрүүгийн хариуцлагын талаарх орчин үеийн онолын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах үүднээс хуулийн этгээдийн талаарх философийн үзэл бодлын түүхийг эрүүгийн хуулийн түүхэн хөгжлийн хүрээнд авч үздэг билээ. Үүнд: эрх зүйн үзэл баримтлал, нийгмийн хүчин зүйлсийн харилцан үйлчлэлд онцгой анхаарал хандуулах шаардлага тулгардаг (2000: 38). Түүхчид өөрсдийн баримтуудыг эрх зүйн онол, тухайлбал, улс төрийн захиргаадлын хэрэгсэл болох хууль тогтоомжийн дагуу хуулийн эрх мэдлийн загварыг шүүмжлэхдээ ашиглаж болно. Жансен (2010:138) хувийн эрх зүйн эрх мэдэл нь үндсэндээ хууль тогтоогчийн улс төрийн хүсэл зоригт суурилдаг гэсэн санааг эргэцүүлэхийн тулд Ромын ертөнцөөс эхлээд XX зууны арилжааны хууль хүртэлх жишээнүүдийг авч үзсэн байна.

Таманаха (2001) болон Твининг (2009) нар барууны ертөнцөөс хол давсан, антропологичдын хийсэн олон судалгааг багтаасан олон тооны эмпирик жишээг хамруулсан гэдгээрээ эрх зүйн онолчдын дунд алдартай. Гэсэн хэдий ч үр дүнд нь тэдний судалгааны сэдэв нь эрх зүйн олон ургальч үзлийн үзэл баримтлалын нэгэн адил өргөн хүрээтэй үзэгдлүүдийг хамрахаар өргөжиж, бид хаанаас эхлэн хуулийн талаар ярихаа больж, нийгмийн амьдралыг дүрсэлж эхлэх вэ гэсэн сонгодог асуудлыг хөндөж байна. (Мэрри 1988: 878–79) Ид хуулийг тодорхойлогч категорийн хувьд судлахаа орхиж, харин нормативын олон ургальч үзэл дээр төвлөрөх ёстой хэмээн Таманаха судалгааныхаа дүгнэлтэд тодорхой илэрхийлжээ. Энэ номонд би хуулийн үзэл баримтлалыг орхихгүйгээр өргөн хүрээний эмпирик жишээг авч үзэх боломжтой гэдгийг харуулахыг зорьсон юм. Хоёрдугаар бүлэгт эрх зүйн олон ургальч үзлийг авч үзэхдээ эдгээр маргаантай асуудлуудыг эргэн авч үзэх болно.

Бусад эрх зүйн онолчид эсрэгээрээ эмпирик судалгаанд төдийлөн ач холбогдол өгдөггүй. Харт "энгийн нийгэм"—дээ үндсэн дүрэм журмын тухай ярихдаа ч антропологийн жишээг авч үзээгүй. Түүний дүрэм журамд суурилсан судалгаа нь Английн нийтлэг хуулийн бодит байдалд нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр шүүмжлэлд өртөж байсан. Симпсоны хэлснээр нийтлэг эрх зүй нь дүрэм журмын тогтолцоо биш харин заншлын эрх зүйн тогтолцоо буюу өөрөөр хэлбэл уламжлалт үзэл санаануудын цогц юм. (2011:361–62) Постэма (2002) XVII зууны хууль зүйг үүнтэй ижил аргаар ашиглаж, Харт болон бусад позитивистуудын тайлбарыг шүүмжилдэг. Тэрбээр нийтлэг эрх зүйг хэм хэмжээ, заавар эсвэл хуулийн саналын багцаас илүү "нийтлэг, бодит үндэслэлтэй практик" гэж тодорхойлсон. (2002: 602) Хоноре (1977) ч гэсэн Хартын дүрэм журмын тухай судалгааг шүүмжлэхийн тулд "бодит

хуулиуд” буюу Их Британийн хууль тогтоомж, нийтлэг эрх зүйн заншлын хэм хэмжээний жишээг судалжээ.

Эцэст нь эрх зүйн олон онолууд нь хуулийн үндсэн буюу нийтлэг шинж чанарыг эрэлхийлдэг. (Галлиган 2010:978) Харт “хууль” гэх нэр томъёоны талаар ердийн хэлний тодорхой ойлголт байхгүйг хүлээн зөвшөөрч, “хууль” гэх оновчтой тодорхойлолт гаргаж ирэх боломжийг үгүйсгэж, харин бидний “хууль” гэсэн нэр томъёог хэрэглэж буй олон янзын тохиолдлуудыг шууд бусаар ч гэсэн голчлон хэрэглэдэг тохиолдолд холбох боломжтой гэжээ. (1994: 81, 199) Тэрээр гол цөм нь дүрэм журмын үзэл санаа байдаг “хотын эрх зүйн тогтолцоо”—ны парадигматик жишээн дээр тулгуурлан, гол элементүүдийг тусгаарлаж, тодорхойлох боломжтой гэдэг санал дэвшүүлсэн байна. (1994:16–17,80) Энэ нь түүнийг үүргийн үндсэн дүрэм журмууд болон тодорхойлолтын нэмэлт дүрэм журмын бүтцээр тодорхойлогддог хуулийн загвар руу хөтөлж, үндсэн дүрэм журмыг хэрхэн таньж, тайлбарлаж, өөрчлөх боломжтойг тодорхойлсон юм. Раз мөн “ердийн тохиолдол”—ыг өөрийн дүн шинжилгээний гол цөм болгон авч үздэг боловч уг шинжилгээний ерөнхий шинж чанарууд нь бүх жишээн дээр давтагдахгүй болохыг хүлээн зөвшөөрдөг. (1975:150) Тэрбээр хууль гэх мэт ойлголтыг хэрхэн оновчтой тайлбарлах тал дээр болгоомжтой ханддаг: үүнд онолын тайлбар хангалтгүй; хэл шинжлэлийн хүрээллийн эмх замбараагүй, хэлбэлзэлтэй нийгмийн амьдралын хүрээн дэх уг ойлголтын тодорхой бус байдлыг тэд багасгахыг хичээдэг боловч зөвхөн тодорхой хүрээгээр хязгаарлахгүй бол тайлбар нь уг үзэл баримтлалаа үнэн зөв илтгэх боломжгүй болно. “Хуулийн тухай ойлголт нь тодорхойгүй байдгийн адилаар хуулийн мөн чанарын тухай ойлголт ч мөн тодорхойгүй байна”. (1998:272)

Финнис голчлон хэрэглэгддэг тохиолдлын тухай магадлалд илүү нааштай хандлагатай байна:

Гол тохиолдлыг тодорхойлсон тайлбар нь тэдгээр гол тохиолдлуудын талаар зохистой асуудлуудад бүгдэд нь хариулахад шаардагдах хэмжээнд үзэл баримтлалын хувьд баялаг, нарийвчлалтай байх ёстой. Улмаар түүний бусад тохиолдлуудын тайлбарын тухайд жишээлбэл, тэдгээр болон гол тохиолдлууд хооронд хэлбэр, үйл ажиллагаа, эсвэл агуулгын хувьд ижил төсөөт болон ялгаат талын хүрээг, төсөө болон ялгаат зүйлийн харьцуулалтыг тодорхойлох боломжтой. Ийм маягаар ('үндсэн хууль', 'дайсагнал', 'хууль') гэх ерөнхий нэршил голлон хэрэглэгддэг тохиолдлоос ямар нэг байдлаар завсрын тохиолдлуудад, үндсэн утгаасаа дам утга руу дэлгэрэх 'зарчим буюу үндэслэл'—ийг илрүүлдэг. (1980:11)

Түүний хэлснээр Аристотелийн 'гол утга'—ын талаарх санаа Веберийн 'идеал – төрөл' буюу 'үзэл баримтлалын цогцлоос'—той дүйж байгаа юм. (Геданкенбилд) (1980:9)

Хэдий тийм ч ганц голлон хэрэглэгддэг тохиолдолд байж, бусад нь туслах шинжтэй байх боломжтой гэх үзэл санаанд болгоомжтой хандах хэрэгтэй. Онолыг цогцлоох зорилгод юуг голлох, нийтлэг хэмээн авч үзэхийг бид хэрхэн шийдэх вэ? Ламонд хуулийн ялгаатай тохиолдлууд хоорондоо давхацсан шинж чанараараа хэсэгчлэн холбогддог нь бидний практиктай төсөөтэй байхаас илүү зүйлийг илэрхийлэхгүй байж, 'үндсэн' шинж чанарын эрэл хайгуул хийх нь ямар ч үр дүнгүй юм гэж үү? хэмээн эргэцүүлжээ. (2001:37) Веберийн идеал төрөл нь голлон хэрэглэгддэг тохиолдлоос зарим талаар ялгаатай. Тэрбээр хуулийн олон идеал загвар бүтээгдэх боломжтой ба загвар бүр нэгэн асуудлыг зохицуулахыг эрмэлздэгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд хуулийн идеал төрөл нь ёс зүйн үүрэг хариуцлага юм уу ямар байх 'ёстой' тухай загвар биш; харин 'бодитой байх боломжтой' хуулийн загвар юм (1949:91–92).

Идеал төрөл нь эмпирик жишээнүүдийг тайлбарлах шинж чанар, бүтцийг санал болгох боломжтой бөгөөд тодорхойлоход ихээхэн тустай байдаг. Гэхдээ Вебер хуулийн тийм загварууд бодит амьдралын тусгал болно гэж таамаглаагүй. (1949:90) Финнис хуулийн гол тохиолдол юу чухал, ач холбогдолтой талаарх үнэлгээг багтааж байх ёстой гэсэн санал дэвшүүлсэн бөгөөд анхаарал, шийдвэр, үйл ажиллагаа нь тухайн зүйлийг бүтээж, цогцлоодог хүмүүсээс асуух замаар үнэлнэ. (1980:12) Гэвч бид чухал хэрэгцээ, ач холбогдлыг гадны жишээн дээр хэрхэн үнэлбэл зохилтой вэ? Бид соёл хоорондын харьцуулалт хийхэд хэрэглэх шаардлагатай тохиолдлуудад тодорхой нэг л соёлын үнэт зүйлд үндэслэсэн загварыг авч ашигладаг аюул оршино. Тэдгээр нь Паркин (2000:92)—ын тайлбарлаж буйгаар мужааны загварын хэв шиг тодорхой зураглалыг шинэ зүйлд хуулбарлан буулгахад ашиглагдах ёсгүй юм; загвар нь үүнээс илүүтэй үйлдэл, хөдөлгөөн, үг, хандлагын хүрээг тодорхойлох ёстой бөгөөд тэдгээрийн аль нь ч яг таг хуулбарлагдах ёсгүй.⁹

Жишээлбэл, Раз өөрийн судалгааг 'норматив, институцилсэн, албадсан' 'нийгэмд давамгайлсан хуулийн талаарх нийтлэг үзэл'—д суурилдаг (1970:3, 216). Тэрбээр өөр нэгэн бүтээлд 'хуультай хэрнээ түүнийгээ хууль биш хэмээн үздэг улсын шүүх тохиолдлыг угтаа хууль дээдлэх ёс болох тогтолцооны

⁹ Энэ утгаараа бид Галлиганы (2007:6) нийгэм дэх хуульд дүн шинжилгээ хийхдээ задлан шинжлэх эрх зүй судлалыг эхлэл цэгээ болгон авах ёстой гэх саналд болгоомжтой хандах ёстой. Энэ нь зохистой буух боломжгүй эмпирик өгөгдөл дээр парадигматик хуулийн загвар тогтоох эрсдэл дагуулдаг.

дүрэм журмуудын дагуу шийдвэрлэхэд анхаарах болно' (1998:280).¹⁰ Гэсэн хэдий ч барууны жишээнээс давж сэтгэвэл институтүүдийг онцолсон нь бидний мэдэх эртний Энэтхэг, эсвэл Исламын хуулийг байтугай олон тооны нутгийн жишээнүүдийг ч хамрахгүй нь ойлгомжтой болдог. Идеал төрөл нь ижил төсөөт зүйлсийг харьцуулах юм уу жишээ байдлаар хэрэглэгдэх ёстой; тэдгээр нь тайлбарласан шинжтэй болохоос шийдвэрлэгч хүчин зүйлс биш бөгөөд эмпирик судалгаа нь идеал төрлийн санал болгосон загварыг нарийн өнгө аястай болгох боломжтой, эсвэл бүр шинэ загварын үндэс суурь ч болох боломжтой юм.

Тиймээс антропологийн төсөл нь тодорхой нэгэн эрх зүйн онолчлолын хэлбэрээр авч үзэгдэж болох юм: эхлэл цэгээрээ энгийн хэлний ухагдахууныг авдаг; эмпирик жишээнүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр суурилдаг; идеалчлахаас илүүтэй тодорхойлохыг зорьдог; аль нэгийг нь үндсэн хэмээн тааварлалгүй, гол тохиолдол цогцлоох боломжтой хэмээлгүй давхацсан шинж чанаруудыг илрүүлж тодорхойлохын тулд тохирох ухагдахуун, үзэл санаануудыг олж, хэрэгжүүлдэг. Хэрвээ бид түүхчид, сонгодгууд, дорно дахины судлаачид болон антропологичдын эмпирик судалгаануудыг, тэдгээрийн 'хууль' хэмээдэг зүйлсийн судалгааг миний энэ номын дараахь бүлгүүдэд дурдсанчлан харгалзан үзвэл бид давхацсан шинж чанарууд олж харна; гэвч эдгээр нь үйлдлээс илүүтэй хэлбэрийн асуудал; тэдгээр нь институци юм уу зохицуулалтаас илүүтэй легализм руу чиглүүлдэг. Легализм нь удирдагчийн тушаалыг хэрэгжүүлэх, маргаан шийдвэрлэх, ердийн, урьдчилан хэлэх боломжтой зан байдлыг дэмжих механизм гэхээсээ илүү сэтгэлгээний төрөл юм. Хуулиуд тодорхой тохиолдолд эдгээр зүйлсийг бүгдийг нь хэрэгжүүлэх боломжтой боловч миний санал дэвшүүлж байгаагаар сэтгэлгээний өвөрмөц төрөл бөгөөд өөр өөр жишээнүүд дунд төсөөтэй байдлын мэдрэмж төрүүлдэг.

Эрх зүйн онол энэ төрлийн сэтгэлгээг илүү ойлгомжтой болгож өгдөг. Онолчид зуун зууны туршид хуулийн талаарх бидний бодолд нөлөөлж, тус ойлголтын ердийн хэлний хэрэглээг шууд бусаар хэлбэржүүлж байдаг. Ламонд (2001:37) бидний соёл дахь хуулийн хэлбэр нь бидний итгэл үнэмшил болон хандлагын үр дүн байдаг хэмээсэн. Ласи (2000:18) социологичид хуулийг нийгмийн үзэгдлийн хувьд ойлгохын тулд тодорхой хүрээнд эрх зүйн онолын 'журмыг сурч мэдэх' ёстой хэмээх саналыг дэвшүүлсэн. Ийнхүү эрх зүйн онолын журмыг сурах нь хуулийн тусгай норматив байдал, түүний учир шалтгааны арга, харьцангуй хараат бус шинж чанар гэх мэт асуудлуудыг хамардаг (2000:39). Антропологич Аннелис Райлс (2004) мөн

¹⁰ Түүний сүүлийн үеийн бичвэрт уг үзлийн тодорхойлолт илүү нарийн өнгө аястай болсон байдаг. Тэрбээр өөрийн тодорхойлолтынхоо эхэнд институтүүдийг жагсаасан хэвээр байсан боловч 'хууль өөрийн харьяатуудтай учир шалтгааны тогтолцоо болохынхоо хувьд тулж зогсдог' (2009:8).

эрх зүйн онолын шинж чанар болон бүтээлийг угсаатан зүйн судалгааны судлагдахуун болгон авч үзэх ёстой хэмээсэн. Дараачийн бүлгүүдэд хэлэлцэх жишээнүүд эдгээр шинж чанарын ач холбогдлыг илтгэдэг: өөрсдийгөө зөрчилдөөн шийдвэрлэх туршлагаудаар хязгаарлагдалгүйгээр, хууль учир шалтгааны тусгай хэв маягтай гэх хэм хэмжээ болон номлолуудыг нухацтай авч үзэх ёстой; хууль хараат бус байж, нийгмийн хэм хэмжээнээс ангид оршдог. Эрх зүйн онолчид нь антропологичдод легалист сэтгэлгээний хүрээ, онцлог мөн чанарыг эргэцүүлэхэд туслалцаа үзүүлдэг.

Эрх зүйн антропологи

Хуулийн ойлголт өргөн, тодорхой бус ба нэг нь нөгөөтэйгөө төсөөтэй жишээнүүдээс бүрддэг бөгөөд бусад олон хэлэнд орчуулагдах боломжгүй байхаас үл хамааран үзэл баримтлал болохынхоо хувьд ач холбогдолтой юм. Эрх зүйн антропологи нь хуулийг нийгмийн хэлбэр болохын хувьд утга учир олгодог таамаг, санаануудынх нь хамтаар шинжлэх ёстой. Хууль гэж нэрлэдэг нийгмийн үзэгдлийн бүхий л хүрээг төрөл зүйл, нийцэшгүй байдал бүхэнд нь нухацтай авч үзэж, хэв маяг, нийтлэг байдал, холбоог тэдгээрийн дундаас эрэлхийлнэ гэсэн үг юм. Зорилго нь тодорхойлохоосоо илүүтэй зааварчилж, нийтлэг шинж, ойлголтыг эрэлхийлэх юм. Улмаар бид зарим эрх зүйн философичдын адилаар дүн шинжилгээ хийхийн тулд тодорхойлдог боловч антропологичдын төсөл ерөнхийдөө илүү өргөн хүрээтэй, ялгаатай, үл мэдэгдэх зүйлсийг анхааралдаа авдаг. Бид философийн хувьд эмх замбараагүй боловч нарийвчлал бүхий, нарийн өнгө аястай судалгаа явуулдаг бөгөөд үр дүнд нь эрх зүйн философичдын судлах эмпирик материалууд ихэсдэг.

Бид хууль бол зан үйлийг тодорхойлогч, улс, удирдагчаар баталгааждаг, зөрчилдөөний шийдлийн институтүүд юм уу үйл явцуудыг агуулсан жишээнүүдээр хязгаарлагдахаас сэргийлэх ёстой. Антропологич нь тус ойлголтын энгийн үгээр илэрхийлэгдсэн аргуудаас эхлэх боловч ингэхдээ хил хязгаарыг сорьж, гээгдсэн шинж чанар, хамаарал, дутагдлуудыг тодотгохын тулд ач холбогдол багатай жишээнүүдийг эрэлхийлэх ёстой. Үүнтэй адилаар бид уг ойлголтыг норматив ба нийгмийн дэг журам, шүүх үйл явц ба маргаан шийдвэрлэлтийн бүх хэлбэрийг хамаарахаар өргөжүүлж болохгүй. Хэрэв ингэж судлах зүйлээ өргөжүүлбэл аналитик шинж чанараа алдана.

Миний санал дэвшүүлж буйгаар эрх зүйн антропологичдын судалж буй өргөн хүрээний сэдэв дундаас эрх зүйн сэдэвт илүү анхаарлаа хандуулах хэрэгтэй. Энэ нь хуулийн бичвэрээс гадна нийгмийн туршлага, хэлбэрээс гадна үйл ажиллагааг шинжилнэ гэсэн үг болно. Мөн жишиг болсон эрх

зүйн тогтолцоонуудыг ажиглаж, нарийвчилсан эрх зүйн сэтгэлгээнүүдийн жишээг олж харна гэсэн үг. Жам ёсны эрх зүй болон уг нэр томъёог зохистой хэрэглэсэн олон тооны жишээнүүдэд нухацтай хандсанаар легализм буюу эрх зүйн сэтгэлгээ болон дүрэм журам, хийсвэр ангиллуудыг дэлгэрүүлэх ашиг тусад анхаарлыг чиглүүлж өгнө.

Дараах бүлгүүдэд эрх зүйн антропологийн судалгаа хийх аргачлалыг харуулахын тулд түүхчид, сонгодгууд, дорно дахины судлаачид, антропологичдын эмпирик судалгаануудыг авч хэлэлцэнэ.

- Хоёрдугаар бүлэгт эрх зүйн антропологийн утга зохиол дахь үндсэн санаануудыг авч үзэх болно. Тэд хууль нь нийгмийн дэг журмыг баталгаажуулдаг гэсэн нийтлэг нотолгоог судалдаг. Гэхдээ тэд мөн тус ойлголтыг хэт дэлгэрүүлэхээс болгоомжлуулдаг.
- Гуравдугаар бүлэгт хуулийг утга болохын хувьд авч үзэх боломжийг, хуулийг эрх мэдлийн хэлбэр болохын хувьд авч үзэх илэрхий хувилбаруудыг, тэдгээрийн хязгаарлалтыг хэлэлцэх болно. Энэ хоёрын илэрхий ялгаа нь гуравдагч хандлага шаардлагатайг харуулж байна. Тиймээс би хуулийн талаарх өөр харах өнцөг танилцуулахын тулд эртний хуулийн эмхэтгэлүүдийн жишээнд, хуулийн тусламжтайгаар дэг журам тогтоож, үүрэг хариуцлагыг уриалсан эмхэтгэлүүдэд хандах болно. Энэ нь номын үлдсэн хэсгийн сэдвийг гаргаж өгч байгаа юм.
- Дөрөв болон тавдугаар бүлэгт би Энэтхэг, Ром, Ислам, Хятадын ертөнцийн агуу эрх зүйн тогтолцоонууд руу шилжиж, эрх зүйн эрдэм шинжилгээний болон оюун санааны мөн чанарыг авч үзсэн түүхчид болон дорно дахины судлаачдын тохиолдлын судалгаануудыг ашиглана. Зургадугаар бүлэг буюу уг номын амин зүрх болсон хэсэгт би легализм буюу ерөнхий дүрэм журам, хийсвэр ангиллуудыг хэрэглэдэг, ингэснээр эрх зүйн учир шалтгааны өвөрмөц мөн чанарын үүсгэвэр болдог сэтгэлгээний төрөлд хандана.

OIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Ромын дараах Европт бий болсон хөгжлийг авч үзэхийн сацуу зургаа болон долдугаар бүлэгт ач холбогдол багатай нийгмүүд рүү шилжиж, агуу эрх зүйн тогтолцоонуудын зах хязгаар дээр үүссэн тосгод, омгуудын эмхэтгэлүүдийн жишээг, нийгмийн бүлгийн өөр өөр хэлбэрүүдтэй холбогдох харилцааг хэлэлцэнэ.
- Наймдугаар бүлэгт удирдагч, улс, хууль хоорондын харилцан хамааралд шилжиж, хүний эрх, олон улсын эрх зүйг авч үзнэ.

Номын туршид газар зүй, цаг хугацаагаар нэвт шувт харьцуулалтууд явагдаж, нийтлэг үндсэн санаанууд болон сөргөлдөөнүүдийг онцолж, хуулийн авч болох янз бүрийн хэлбэрүүдийг дүрсэлнэ. Түгээмэл биш боловч ертөнцийг легалист арга барилаар бодох, маргах, зааварлах, тодорхойлох нь идеализмын бүрдэл хэсэг болж, бурханлаг байдлыг сэргээж, шударга ёсны найдвар зэрэг нь жишээнүүд дунд давтагдана. Энэ нь эргээд эрх зүйн хэлбэрт үл итгэх байдлыг өдөөж, бидний хууль хэмээн сэтгэдэг нийгмийн үзэгдлүүдийн ихэнхид тааралддаг легализм болон идеализмын хооронд сөргөлдөөн үүсгэх нь элбэг байдаг. Эдгээр нь миний дүгнэлт хэсэгт эргэн очих үндсэн санаанууд билээ.

*Орчуулсан: Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач
С.Номынбаясгалан, судлаач О.Анударь, гэрээт судлаач З.Тамир,
М.Агиймаа, О.Түвшинсанаа.*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



Б.НАРМАНДАХ

Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор

МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЭРХ
ЗҮЙН МЕХАНИЗМ БҮРЭЛДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭХЛЭЛИЙН ТҮВШИНД БАЙНА.

FORMATION OF LEGAL SYSTEM TO FULFIL HUMAN RIGHTS
IN MONGOLIA IS AT THE INITIAL LEVEL

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргадаг “Хүний эрх сэтгүүл”-ийн энэ удаагийн ярилцлагын зочноор Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор Б.Нармандахыг урьж ярилцлаа.

Таны хувьд хүний эрхийн чиглэлээр судалгааны хэд хэдэн бүтээлүүд гаргасан байдаг. Уншигчдад хамгийн энгийнээр хүний эрхийн тухай ойлголтыг тайлбарлаж өгнө үү?

Хүний эрх бол хүний хүсэл зориг, хэрэгцээг илэрхийлсэн, чөлөөт байдалд үндэслэн, зохих баталгаагаар хангагдсан, хязгаарлагдмал хүрээнд хэрэгжих зан үйлийн боломж юм. Өөрөөр хэлбэл, бидний “эрх” гээд эдэлж, хэрэгжүүлж

байгаа үйл ажиллагаа хүний хэрэгцээ, хүсэл зоригийн илэрхийлэл байх ёстой. Мөн уг “эрх”-ийг эдлэх эсэх нь таны өөрийн сонголтод үндэслэсэн, хуулиар тогтоосон ямар нэг хязгаарлалтыг зөрчөөгүй, хүссэн үедээ баталгаатай эдлэх, хэрэгжүүлэх боломжтой байхыг ойлгоно. Тухайлбал, байгууллагынхаа хурал дээр даргын хүсэлт, ятгалга, даалгавраар “үг хэлэх” нь “үг хэлэх эрх”-ээ эдэлж байгаа явдал биш. Учир нь энэ тохиолдолд хүний эрхийн хүсэл зоригийн болон чөлөөт байдалд үндэслэсэн байх шинж үгүйсгэгдсэнээр магадгүй үүрэг, тулган хүлээлгэлт болж хувирна.

Өөр нэг жишээ хэлэхэд хүний хамгийн өргөн хэрэгжүүлдэг эрхийн нэг болох “сурч боловсрох эрх” нь нэгдүгээрт, хүний сурч боловсрох хэрэгцээ, хүсэл зоригт үндэслэсэн байх; хоёрдугаарт, уг эрхийг эдлэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгаагаар хангагдсан байх; гуравдугаарт, хүний өөрийнх нь сонголт, боломжид үндэслэсэн байх; дөрөвдүгээрт, хязгаарлагдмал хүрээнд хэрэгжих зан үйл байна.

Гэтэл зарим хүмүүс “эрх” гэхээр л хүссэн үедээ хязгааргүй эдлэх боломж хэмээн ойлгодог. Эрх нь хүний өөрийнх нь чадавх, сонголтоос хамааралтайгаар хуулиар тогтоосон хязгаарын дотор баталгаатай хэрэгждэг үнэ цэнтэй боломж.

Эндээс чадавх нь боломжийн хязгаарыг илэрхийлдэг бол, сонголт нь хүсэл зориг болон чөлөөт байдлыг, хуулиар тогтоосон байдал нь баталгаа болон хязгаарыг илэрхийлнэ.

Тэгвэл хүн эрхээ эдлэхийн тулд юуг анхаарах ёстой вэ?

Хэн боловч эрхээ эдлэхдээ өөрийн хэрэгцээ, хүсэл зоригт үндэслэж, чөлөөтэйгээр, баталгаатайгаар, хуулиар тогтоосон хязгаарын дотор эдэлнэ.

Хүний эрхийн баталгааг хангах нь төрийн үүрэг хэдий ч эрхийг хуулиар хязгаарлах нь төрийн бүрэн эрхийн асуудал байна. Гэхдээ бид аль болох “өргөн” баталгааг бүрдүүлж, “бага” хязгаар тогтоохыг төрөөс шаардах эрхтэй.

“Эрхээ хамгаалуулна”, “Миний эрхийг зөрчиж байна” гэж хүн бүхэн ярьдаг. Гэсэн хэдий ч хүний эрх зөрчигдсөөр л байна шалгаан нь юу вэ?

Хүний эрхийн асуудал хэн хүний чихэнд улиг дасал болсон энгийн үг хэллэг биш. Харин улс гүрэн, тив дэлхийн улс төр, нийгмийн амьдрал, хүний оршин хөгжихүйн үндэс бөгөөд засаг төр, олон улсын бодлогын анхаарлын төвд байдаг, заяагдмал шинжтэй объектив ухагдахуун. Тиймээс ч хүн бүр нийгмийн олон талт харилцаанд оролцох эрх, эрх чөлөөтэй.

Харамсалтай нь хүний аж төрж буй төр улсын засаглалын хэлбэр, хөгжлийн түшин, үндэсний уламжлалт ёс заншил, шашин, хувь хүний өөрийнх нь хүсэл зориг, ухамсар, сэтгэлгээнээс хамааралтайгаар хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж тэнцвэртэй бус байна. Энэ бүхэн бидний дээр дурдсан олон шалтгаанаас үүдэлтэй ч хүний эрхийн зөрчилтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох гол үндэс нь хүн бүр өөрийн эрхийг мэдэх, түүнийг үнэлэх үнэлэмжийг олж авах явдал мөн.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан “Өнөө болон ирээдүйд зөвхөн та л өөрийн эрхийг хэрэгжүүлнэ. Хүний эрх бол таны эрх. Тэдгээрийг эзэмш, хамгаал, дэлгэрүүл. Түүнийг ойлго, түүнийг шаард, тэдгээрийг тэтгэ, баяжуул” хэмээн хүний эрхийг танин мэдэх хэрэгцээ шаардлагын талаар сургасан байдаг. Үнэхээр ч хүн та эрхтэй эсэхээ мэдэхгүй бол эрхийг эдлэх боломж үгүй болно.

Учир нь өөр хэн нэгэн эрх мэдэлтэн, тэр дундаа төр таны эрхээ эдлэх боломжийг хязгаарлах замаар өөртөө давуу байдал олж авах, улмаар таны эрх хязгаарлагдах, зөрчигдөх нөхцөл бүрдэнэ. Хүн төрөлхтөний түүхээс үзвэл үеийн үед хүчтэй нь хүчгүйгээ, эрх мэдэлтэй нь эрх мэдэлгүйгээ түрэмгийлж, өөр хоорондоо зөрчил, тэмцэл үүсгэж ирсэн байдаг. Тиймээс ч Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Удиртгал хэсэгт “...Хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг хуулиар хамгаалах нь зайлшгүй чухал...” хэмээн тунхагласан байдаг. Товчоор хэлбэл хүн эрхээ мэддэггүйгээс, эрхээ шаарддаггүйгээс, эрхээ хамгаалдаггүйгээс л хүний эрх зөрчигчийн үйлдэл тасралтгүй гарсаар ирсэн байдаг.

Та төр хүний эрхийн зөрчлийн гол субъект гэж ярилаа. Гэтэл агаар бохирдлуулагч нь иргэн, хуулийн этгээд өөрөө байдаг хэрнээ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн зөрчлийн субъект нь яагаад төр болж байгаа билээ?

Төр оршин байгаагийн объектив шинжийн нэг нь ард түмэнтэй байх явдал мөн. Тиймээс төр өөрийн ард түмнийхээ буюу иргэдийнхээ эрхийг хангах, хамгаалах нь төрийн үүрэг болно. Энэ талаар Б.Чимид багш “Үндсэн хуулийн мэдлэг” бүтээлдээ “Хүний эрхийг хангах, хамгаалах нь засаг төрийн зөвхөн халамж анхаарлын буюу сайн санааны үйлс төдий биш юм. Харин дотоод, гадаад хоёр үндсэн шалтгаанаар ард түмнийхээ өмнө Үндсэн хуулийн ёсоор хүлээсэн зайлшгүй үүрэг мөн. Шалтгаан нь нэгдүгээрт, өөрсдөө өөрсдийнхөө тусын тулд байгуулж эцэг эх нь болсон ард түмнийхээ эрх, эрх чөлөөг хамгаалах, сайн сайхныг хангах нь засаг төрийн эрхэм зорилго мөн. Энэ бол дотоод гол шалтгаан. Нөгөө нь Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн

бүрэн эрхт гишүүний хувьд хүний эрхийн олон улсын гэрээг шударгаар сахин биелүүлэх үүргийг дэлхийн улсуудын өмнө хүлээсэн байдаг. Энэ бол гадаад гол шалтгаан хэмээн тэмдэглэсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр дүгээр зүйлд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" хэмээн заасны дагуу төр зөвхөн эрхийг эдлэхэд шаардагдах баталгааг бүрдүүлээд зогсохгүй хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй.

Энэ хүрээнд төр агаар бохирдуулалтаас сэргийлэх, бохирдуулсан үйлдлийн улмаас хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зэрэг арга хэмжээг авах үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд энэ нь хүний эрхийн зөрчил болно.

Харин төр энэ үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд аль болох эрүүл аюулгүй технологи хэрэглэхийг иргэн, хуулийн этгээдээс шаардах, тэдний үйлдлийг хязгаарлах зэрэг хэм хэмжээ тогтоож, түүнийг нь ард иргэд мөрдөх үүрэг хүлээнэ. Энэхүү тогтоосон хэм хэмжээг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл нь эрх зүйн зөрчил болно.

Өөрөөр хэлбэл, иргэн, хуулийн этгээдийн зөрчил бол эрх зүйн шаардлагыг зөрчсөн шинжээрээ эрх зүйн зөрчил болно. Харин эрх зүйн зөрчил гаргах нөхцөл боломж бүрдүүлсэн, түүнийг хуулиар хязгаарлаагүй, хянаагүй, баталгаа хангаагүй, хүн бүрт тэгш боломж олгоогүй зэрэг шалтгаанаар төр хүний эрхийн зөрчлийн субъект болно.

Таны докторын судалгааны ажил ихээхэн сонирхол татдаг. "Монгол Улс дахь хүний эрх, түүнийг хангах эрх зүйн механизмыг боловсронгуй болгох зарим асуудал" сэдэвт судалгааны ажлын үр дүн нь юу байв?

Би 2012 онд энэ сэдвээр МУИС-ийн Хууль зүйн сургуулийг түшиглэсэн докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр хууль зүйн докторын зэрэг хамгаалж байсан. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч маань Хөдөлмөрийн баатар, гавьяат багш, Үндсэн хуулийн эрхийг баригч, доктор, профессор Б.Чимид багш байсан. Тухайн үедээ бол надад ахадсан сэдэв байсан. Үндсэндээ багшийнхаа л зааж хэлсэн, зөвлөсний дагуу судалгааны ажлынхаа ард гарч байлаа.

Бид тус диссертацаар Монгол Улс дахь хүний эрхийн Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын тухайн үеийн төлөв байдал, түүнийг хангах механизмыг нэгтгэн дүгнэж, өөрсдийн үзэл бодлоо түүний дотор хүний эрхийг хангах эрх зүйн механизмыг боловсронгуй болгох арга замыг дэвшүүлж, түүнийг хангах, тодорхойлоход хувь нэмэр оруулахыг зорьж, хүний эрхийг хангах

баталгаа, механизмыг бүрдүүлэх, хүний эрхийн зөрчилтэй тэмцэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгааныг судалж, уг үйл явцад шинжлэх ухааны үндэслэл бүхий хариу эрэлхийлж, дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх гарцыг эрэлхийлэх зорилго дэвшүүлж ажилласан.

Аль ч нийгмийн үед засаг төрийн зүгээс хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдал гардгийг харгалзан Монгол Улсад хүний эрхийн хамгааллын асуудал ямар түвшинд байгааг объектив байдлаар судлан хууль зүйн хувьд хүний эрхийг хангаж хамгаалах нөхцөл зохих түвшинд бүрдсэн боловч, түүнийг хэрэгжүүлэгч төр, түүний байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагааны оновчтой бус зохион байгуулалт, чадавх, хөрөнгө санхүүгийн хангалтгүй байдал зэргээс хамааралтайгаар хүний эрхийн зөрчил байсаар байна гэж дүгнэсэн.

Гэвч уг асуудал дан ганц дээр дурдсан объектив хүчин зүйлсээс хамаарахаас гадна төрийн албан хаагчид, улс төрчид, хуульчдын ёс зүй, хараат бус байдал, шударга, энэрэнгүй ёс зэрэг субъектив хүчин зүйлсээс хамааралтай бөгөөд энэ бүхэн нь төрөөс хүний эрхийг хангах нийгэм, эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргээ хангалтгүй биелүүлж байгаагийн үр дүн бөгөөд төр эл үүргээ илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах Үндсэн хуулийн механизмыг тасралтгүй, үр дүнтэй ажиллуулах, хүний эрхийн суурь зарчмыг хэрэгжүүлэх асуудлыг ердийн хуульд тусгаж, механизмын үр нөлөөг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал мөн болохыг дүгнэн харуулсан.

Таны судалгаагаар төрөөс хүний эрхийг хангах, хамгаалахад ямар тогтолцоог бүрдүүлж ажиллавал зохилтой гэж дүгнэсэн бэ?

Төрөөс хүний эрхийг хангах, хамгаалах үүрэг нь хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулах, олон улсын механизмыг аль болох өргөн бөгөөд түүнийг нааштайгаар ашиглах, хэрэгжилтийг хангаж чадах төрийн байгууллагын тогтолцоог бүрдүүлэх, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хязгаарлах явдлаас сэрэмжилж чаддаг, зөрчигдсөн эрхийг сэргээх, хангах шударга шүүхийн тогтолцоог бүрдүүлж ажиллуулах зэрэг өргөн агуулгаар тодорхойлогдоно. Үүнийг институц хэлбэрээр авч үзвэл:

- Үндсэн хуульт төр;
- Төрийн эрх мэдлийн оновчтой хуваарилалт;
- Хуулиар халхавчлан түрэмгийлэх аюулыг зайлуулах механизм болох RULE OF LAW үзэл санаа;
- Хараат бус шүүх;

- Иргэний нийгмийн хөгжил;
- Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, стандартын хэрэгжилт зэрэг нь багтах бөгөөд бид судалгааны ажлынхаа үр дүнг түшиглэн Монгол Улсад хүний эрхийг хангах эрх зүйн механизм бүрэлдэх үйл ажиллагаа эхлэлийн түвшинд байна гэж үзэж, цаашид эл асуудал онолын түвшинд хэрхэн ойлгогдож байгаа, практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар нэгтгэн боловсронгуй болгох механизмыг төгөлдөршүүлэх нь зүйтэй хэмээн дүгнэсэн.

Та судалгааныхаа хүрээнд хэд хэдэн дүгнэлт гаргажээ. Тэгвэл шийдвэрлэх ямар гарц харагдаж байна?

Миний бодлоор дээрх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд хэд хэдэн гарц байна гэж харж байгаа. Тухайлбал:

Нэг. Үндсэн хуулиар олгогдсон хүний үндсэн эрхийн хамгааллын асуудал Үндсэн хуулийн цэцийн авч үзэх маргааны хүрээнд ороогүй тул Үндсэн хуулийн эрхээ зөрчигдлөө гэж үзсэн иргэн Үндсэн хуулийн Цэцэд хандах боломжийг хуульчлан бий болгож, олон улсын жишигт нийцүүлэх;

Хоёр. Төрийн эрх мэдлийг хуваарилах нь хууль дээдлэгдэх, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах эрх зүй, бүтэц-зохион байгуулалтын илэрхийлэл болох бөгөөд хүний эрх эрх чөлөөг хөндөх эрх бүхий байгууллагуудыг харилцан тэнцвэртэй орших, бие биенээ хянах, нэг нэгнийхээ хэрэгт үл оролцох бүтэц, зохион байгуулалтад оруулж, Үндсэн хуулиар хамгаална. Гэтэл Монгол улсын төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын хүсэл зориг, тэр дундаа эрх баригч хүчний хүсэл зориг дангаараа ноёрхож, хуулиа өөрчлөх замаар хүний эрх эрх чөлөөг хөсөр хаях нөхцөлийг бүрдүүлсэн. Иймд Үндсэн хуулийн суурь зарчмыг хөндсөн эл өөрчлөлтийг хүчингүй болгох;


Гурав. Хүний эрхийн талаарх олон улсын гэрээг үндэсний эрх зүйтэй нийцүүлэх үйл ажиллагааг хууль тогтоох үйл ажиллагааны түвшинд болон хууль хэрэглэх үйл ажиллагааны түвшинд нэгэн зэрэг хэрэгжүүлэхэд анхаарах; Өөрөөр хэлбэл олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлыг зохистой байдлаар шийдвэрлээгүйгээс олон улсын гэрээ нь “үхширмэл” байдалд байсаар байх бөгөөд Засгийн газар өнөөдрийн адил гэрээний хэрэгжилтийн тайланг “хэлбэр төдий” байдлаар гаргаж өгсөөр байх болно. Энэ нь хүний эрхийн асуудалд ноцтой тээг гацаа болж, түүнийг хангах механизм бүрэн ажиллах боломжийг хязгаарлах нөхцөл болж байна. Тиймээс Монгол Улсад олон улсын гэрээг шууд хэрэглэдэг практик тогтоохын тулд хуульчдад олон улсын гэрээг хэрэглэх чадвар, дадал эзэмшүүлэх

сургалтыг зохион байгуулах, олон улсын гэрээний заалтыг үндэсний хууль тогтоомжтой нийцүүлэх арга хэлбэрийг оновчтой тодорхойлох асуудлыг хүний эрхийн зарчимд үндэслэн шийдвэрлэх зэрэг саналуудыг дэвшүүлэн тавьсан.

Цаг зав гарган хүний эрхийн чиглэлээр судалгаанд суурилан нээлттэй ярилцсан танд баярлалаа. Таны цаашдын эрдмийн их ажилд нь амжилт хүсье.

Ярилцсан: ХЭҮК-ын Олон нийтийн харилцаа сурталчилгаа хариуцсан референт Ж.Алтантуяа

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, V давхар
Утас: 51-266506, 51-262902, Факс: 976-11-320284
Цахим хаяг: www.nhrcm.gov.mn, Цахим шуудан: info@nhrcm.gov.mn
Иргэдээс гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 7000-0222
Хүний эрхийн цахим номын сан: <https://lib4u.net/?lib=nhrc>

ISSN: 2617-9288